



ЖЕНДЭРИЙН  
ҮНДЭСНИЙ ХОРОО



# ЖЕНДЭРИЙН МЭДРЭМЖТЭЙ ТӨСӨВЛӨЛТ

СУРГАЛТЫН ГАРЫН АВЛАГА

2014 он



# **ЖЕНДЭРИЙН МЭДРЭМЖТЭЙ ТӨСӨВЛӨЛТ**

**СУРГАЛТЫН ГАРЫН АВЛАГА**

**Улаанбаатар хот  
2014 он**

---

## ӨМНӨХ ҮГ

МУ-ын Засгийн газар Жендэрийн Үндэсний Хорооноос НҮБ-ын Хүн амын сантай хамтран хэрэгжүүлж буй улс орныг хөгжүүлэх 5 дахь хөтөлбөрийн хүрээнд улсын болон орон нутгийн төсвийг жендэр мэдрэмжтэй болгох үйл ажиллагааг эхлүүлээд байна. Энэ ажлын хүрээнд сургалт зохион байгуулах, хүний нөөцийг чадавхжуулах зэрэг үйл ажиллагааг зохион байгуулахын зэрэгцээ жендэр мэдрэмжтэй төсөвлөлтийн сургалт зохион байгуулах зорилгоор энэхүү гарын авлагыг олон хүний оролцоо, туслалцаагаар боловсруулж Та бүхэнд хүргэж байна.

Бид оролцсон бүх хүмүүст, ялангуяа олон улсын зөвлөх Катрин Шнайдер, Үндэсний зөвлөх Даваагийн Цэвээнболор, НҮБ-ын Хүн амын сангийн ажилтан Б.Оюун, Жендэрийн үндэсний зөвлөх, шинжээч Б.Онон, Т.Амгалан, Сангийн яамны жендэрийн асуудал хариуцсан мэргэжилтэн Л.Түвшинжаргал нарт онцгойлон талархал илэрхийлж, тэдний заавар зөвлөгөө, мэргэжлийн дүгнэлт, туслалцаагүйгээр энэ гарын авлагыг боловсруулах боломжгүй байх байсан гэдгийг тэмдэглэе.

Үндэсний болон олон улсын хэмжээнд гаргасан гарын авлагуудын санаанд тулгуурлан, өөрийн орны нөхцөлд тохируулан өөрчлөн боловсруулсан тус сургалтын гарын авлага нь Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийн асуудлаар НҮБХАС-ын зүгээс Монгол улсын Засгийн газарт үзүүлж байгаа дэмжлэгийн нэг үр дүн юм. Гарын авлага нь сургалтын арга зүй, жендэрийн үндсэн ойлголтуудын талаар мэдлэгтэй мэргэжлийн жендэрийн сургагч багш нарт зориулагдсан бөгөөд хичээлийн сэдвүүд, дасгал ажлуудыг сургагч багш зорилтот бүлгүүдийн хэрэгцээ сонирхол болон сургалтын үргэлжлэх хугацаанаас шалтгаалан сонгон хэрэглэх боломжтой юм. Энэ гарын авлагыг ашиглан сайжруулж улам чанаржуулах нь дамжиггүй бөгөөд дахин та бүхний практик үйл ажиллагааны туршлага дээр тулгуурлан сайжруулах боломжтой билээ.

Жендэрийн Үндэсний Хорооны нарийн бичгийн дарга  
бөгөөд Ажлын албаны дарга **М.Болормаа**

2014 оны 12 дугаар сар

---

---

## АГУУЛГА

### УДИРТГАЛ

<b>МОДУЛЬ 1</b>	<b>ЖЕНДЭРИЙН МЭДРЭМЖТЭЙ ТӨСӨВЛӨЛТ: ҮНДСЭН ОЙЛГОЛТ, ЗОРИЛГО, ҮЙЛ ЯВЦ</b> .....	09
	Хичээл 1. Жендэрийн тэгш байдал ба жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлт	
	Хичээл 2. Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийн үйл явц	
<b>МОДУЛЬ 2.</b>	<b>ТӨСВИЙН БҮТЭЦ, ТӨСӨВЛӨЛТИЙН ҮЙЛ ЯВЦ БА ЖЕНДЭР</b> .....	19
	<b>Хичээл 1.</b> Монгол улсын төсвийн бүтэц, төсөвлөлтийн үйл явц	
	<b>Хичээл 2.</b> Төсөв цаг ашиглалт, нөхөн үржихүйн эдийн засагт нөлөөлөх нь	
<b>МОДУЛЬ 3.</b>	<b>ТӨСВИЙН ЖЕНДЭРИЙН ШИНЖИЛГЭЭ</b> .....	33
	Хичээл 1. Жендэрийн нөхцөл байдлын үнэлгээ	
	Хичээл 2. Бодлогын ба төсвийн орлого зарлага төлөвлөлтийн жендэрийн дүн шинжилгээ	
<b>МОДУЛЬ 4.</b>	<b>ЖЕНДЭРИЙН МЭДРЭМЖТЭЙ ТӨСВИЙН ХЭРЭГЖИЛТ</b> .....	45
	Хичээл 1. Жендэрийн тэгш байдлын зорилт, шалгуур үзүүлэлтүүд	
	Хичээл 2. Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийг зохион байгуулах алхамууд	
<b>МОДУЛЬ 5.</b>	<b>ТӨСВИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ ТАВИХ БА ЖЕНДЭРИЙН ТӨСӨВЛӨЛТИЙГ ХӨГЖҮҮЛЭХ</b> .....	59
	Хичээл 1. Төсвийн үр ашгийн (зардлын) хүрээний шинжилгээ ба үр ашиг хүртэгчдийн жендэрийн үнэлгээ	
	Хичээл 2. Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийг хөгжүүлэх нь	
<b>ХАВСРАЛТУУД</b>	Хураангуйлсан үгс .....	69
	Ном зүйн эх сурвалж	

---

## УДИРТГАЛ

### Гарын авлага юунд зориулагдсан бэ?

Гарын авлага нь улсын, орон нутгийн, байгууллагын төсөв боловсруулахад жендэрийн асуудал яагаад чухал болох талаарх мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх, жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийн арга зүйг системтэйгээр институтчилэх чадавхийг дээшлүүлэх, улмаар Жендэрийн Мэдрэмжтэй Төсөвлөлтийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд зориулагдсан.

### Яагаад жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийг хөгжүүлэх хэрэгцээтэй болов?

Монгол улсын Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулиар жендэрийн тэгш байдлыг хангах, жендэрийн эрх тэгш байдлын үзэл баримтлалыг бодлого төлөвлөлт, үйл ажиллагаанд нэгтгэхдээ Жендэрийн Мэдрэмжтэй Төсөвлөлт (ЖМТ)-ийн арга зүйг бүх түвшинд нэвтрүүлэхийг Засгийн газрын бүрэн эрхийн хүрээнд үүрэгжүүлсэн. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийг хэрэгжүүлэх Засгийн газрын дунд хугацааны үндсэн чиглэлд жендэрийн мэдрэмжтэй төсөв зохиох арга зүйг улсын нэгдсэн болон орон нутгийн төсвийг боловсруулах, батлах үйл явцад нэвтрүүлэх зорилтыг тавьсан юм.

Олон улсын хэмжээнд Бээжин хотноо 1995 онд болсон Дэлхийн эмэгтэйчүүдийн 4 дүгээр Бага хурлаас хойш жендэрийн тэгш байдлын үзэл баримтлалыг бодлого төлөвлөлт, хөтөлбөрт тусгах нь жендэрийн тэгш байдлыг хангахад дэмжлэг үзүүлэх гол стратеги гэж үзэж байна. Бээжингийн Үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт “Жендэрийн агуулга, үзэл санааг бодлого, хөтөлбөрийн төсвийн шийдвэртэй уялдуулах, эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн тэгш байдлыг хангахад чиглэсэн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд хангалттай төсөв хуваарилах” шаардлагатайг онцолсон. Улсын төсөвт жендэрийн дүн шинжилгээ хийх нь дэлхий нийтэд төсөвт шинжилгээ хийх шинэлэг аргуудын нэг болж байгаа бөгөөд эрэгтэй, эмэгтэй хүмүүст төсвийн зарцуулалт хэрхэн нөлөөлж байгааг тодруулах замаар хөрөнгийн тэгш хуваарилалтыг хангахад туслах үр дүнтэй хэрэгсэл, жендэрийн дүн шинжилгээний нэг арга гэж үзэн ихээхэн ач холбогдол өгч байна.

### Гарын авлага хэнд зориулагдсан бэ?

Энэхүү сургалтын гарын авлага нь сургалтын арга зүй, жендэрийн үндсэн ойлголтуудын талаар мэдлэгтэй мэргэжлийн жендэрийн сургагч багш нарт зориулагдсан болно.

### Гарын авлагын бүтэц, агуулгыг хэрхэн ойлгох вэ?

Сургагч багшид зориулсан тус сургалтын гарын авлага нь 5 модуль, 10 хичээлээс бүрдэнэ.

<sup>1</sup>МУ-ын Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 16.1.1

<sup>2</sup>ЖЭТБХТ хуулийг хэрэгжүүлэх Засгийн газрын дунд хугацааны стратегийн 6.1-р зорилт

<sup>3</sup>НҮБ-ын Ерөнхий Ассамблейн тогтоол. Бээжингийн тунхаглал, Үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа, санаачлагууд, S23/3, 2000 оны 11 дүгээр сарын 16, параграф 36. Энэхүү үзэл баримтлал нь Бээжин+5 баримт бичиг, Хөгжлийн санхүүжилтийн асуудлаар Дохагийн тунхаглал (2008) зэрэг олон улсын хэд хэдэн гэрээ хэлэлцээрүүдэд тусгалаа олсон.

<sup>4</sup>Сургалтын модуль нь сургалтын хөтөлбөрт багтах бөгөөд тус тусад нь хэрэгжүүлж, үнэлгээ өгөх боломжтой нэг буюу хэд хэдэн тооны судлах зүйлийн нэгж юм.

**Сургалтын модуль, хичээлийн нэр:**

Модуль	Хичээл
<b>Модуль 1.</b> Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлт: үндсэн ойлголт, зорилго, үйл явц	Хичээл 1. Жендэрийн тэгш байдал ба жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлт Хичээл 2. Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийн үйл явц
<b>Модуль 2.</b> Төсвийн бүтэц, төсөвлөлтийн үйл явц ба жендэр	Хичээл 1. Монгол улсын төсвийн бүтэц, төсөвлөлтийн үйл явц Хичээл 2. Төсөв цаг ашиглалт, халамжийн эдийн засагт нөлөөлөх нь
<b>Модуль 3.</b> Төсвийн жендэрийн шинжилгээ	Хичээл 1. Жендэрийн нөхцөл байдлын үнэлгээ Хичээл 2. Бодлогын ба төсвийн орлого зарлага төлөвлөлтийн жендэрийн дүн шинжилгээ
<b>Модуль 4.</b> Жендэрийн мэдрэмжтэй төсвийн хэрэгжилт	Хичээл 1. Жендэрийн тэгш байдлын зорилт, шалгуур үзүүлэлтүүд Хичээл 2. Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийг зохион байгуулах алхамууд
<b>Модуль 5.</b> Төсвийн хэрэгжилтэд хяналт тавих ба жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийг хөгжүүлэх нь	Хичээл 1. Төсвийн үр ашгийн (зардлын) хүрээний шинжилгээ ба үр ашиг хүртэгчдийн жендэрийн үнэлгээ Хичээл 2. Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийг хөгжүүлэх арга зам

**Модулийн бүтэц:**

Модулийн бүтэц нь хичээлийн агуулга, удирдамж, суурь мэдээлэл гэсэн үндсэн гурван хэсгээс бүрдэнэ. Тодруулбал,

- 1. Хичээлийн агуулга:** Модульд хамаарах хичээлийн нэр, түүний зорилго, агуулга, сургалтын хэрэглэгдэхүүн, аргачлал, хугацаа, дасгал ажил, тараах материал болон уншиж судлах материалуудын нэрсийг багтаасан.
- 2. Хичээлийн удирдамж:** Лекцийн гол санаа, сургалтын дүгнэлт, бүлгийн ажлын зааварчилгаа, дасгал ажлуудыг хэрхэн зохион байгуулах зэрэг тайлбаруудыг багтаасан хичээлийг удирдан явуулах чиглэл юм.
- 3. Суурь мэдээлэл:** Сургагч багшид зориулсан лекцийн үндсэн мэдээлэл, агуулгын тайлбар, хичээлийн сэдэвтэй холбоотой жишээ орсон.

**Энэхүү гарын авлагыг ашиглан жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийн асуудлаар үр дүнтэй сургалтыг хэрхэн зохион байгуулах вэ?**

Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийн асуудлаарх сургалтыг амжилттай явуулахын тулд дараах үе шатуудын дагуу сайн төлөвлөлт хийж, бэлтгэл ажлаа хангах хэрэгтэй. Сайн бэлтгэх нь үр дүнтэй сургалт явуулах суурь нөхцөл болно. Үүнд:

**1. Зорилтот бүлгийг тодорхойлох**

Юуны өмнө сургалт хийх зорилтот бүлгээ тодорхойлох шаардлагатай. Сургалтанд оролцох зорилтот бүлгийнхний хэрэгцээ, сонирхол өөр өөр байдаг. Тиймээс оролцогчдын нас, хүйсийн байдал, мэдлэг, туршлагыг анхааралдаа авч, харгалзан үзэх шаардлагатай. Мөн төсөвлөлтийн үйл явц, төсвийн баримт бичгүүдийн талаар мэдлэг ойлголт багатай, жендэрийн үндсэн ойлголт, жендэрийн дүн шинжилгээний хэрэглэгдэхүүнүүдийн талаар хэзээ ч сонсож байгаагүй оролцогчид

байхад зарим нь энэ талаар маш сайн ойлголттой байж болно. Тиймээс сургагч багш нь зарим тохиолдолд сургалтын үеэр заан чиглүүлэгч, зарим үед оролцогчдын мэдлэгээ хуваалцах үйл явцыг нь зохицуулах, хөтлөгч нь болдог.

## *2. Сургалтын хэрэгцээг судлах үнэлгээ*

Зорилтот бүлгээ тодорхойлохын зэрэгцээ сургалтанд оролцох оролцогчид таны явуулах сургалтаас юуг мэдэх ёстой вэ гэдгээ тодорхойлсны дараа тэд юуг мэддэг вэ гэдгийг олж мэдэх шаардлагатай. Тэд юуг мэдэх шаардлагатай вэ гэдэг нь тэд жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийн үйл явцад ямар үүрэгтэй оролцох вэ гэдгээс ихээхэн шалтгаална. Улсын төсөв, санхүүгийн асуудлаар мэргэшсэн судалгааны байгууллагынхан улсын төсвийн хэрэглэгдэхүүнүүдийн талаар мэддэг ч, жендэрийн ойлголтуудын талаар заавал мэддэг байх албагүй. Хэрвээ тэд жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийн үүсэл санаачлагын талаар судалгаа хийх гэж байгаа бол тэд хүйсээр ангилсан статистик мэдээлэл болон цаг ашиглалтын тоон мэдээллийг өөрсдийн хэрэглэгдэхүүнтэй хэрхэн уялдуулах талаар мэдлэгтэй болох шаардлагатай. Та оролцогчдын мэдлэг, ур чадварын түвшингийн талаар мэдээлэлтэй болохын тулд хэрэгцээг судлах бага хэмжээний үнэлгээг холбогдох хүмүүсээс ярилцлага авах, эсвэл сургалтанд оролцох зорилтот бүлгийнхэнээс богино хэмжээний асуулга авах замаар хийж болох юм.

## *3. Сургалтын зорилгыг тодорхойлох*

Сургалтын хэрэгцээг судалсан үнэлгээн дээрээ тулгуурлан сургалтын зорилго, зорилтыг тодорхойлно. Сургалтанд оролцогчдын хувьд жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийн тухай ойлголт нь цоо шинэ зүйл байвал сургалтын гол зорилго нь мэдлэг мэдээлэл олгох, ойлголт өгөхөд чиглэгдэх нь зүйтэй. Хэрвээ оролцогчид жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийн ойлголт, хэрэглэгдэхүүнүүдийн талаар хэдийнээ мэдлэгтэй бол сургалтын зорилго нь жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийн дүн шинжилгээ хийх эсвэл ажлынхаа онцлог, зорилгод нийцүүлэн тохиромжтой хэрэглэгдэхүүнүүдийг ашиглах ур чадвар олгоход чиглэгдэх болно.

## *4. Сургалтын үргэлжлэх хугацааг сонгох*

Зорилтот бүлэг, сургалтын зорилго, зорилтоос хамааран сургалтын үргэлжлэх хугацааг тодорхойлно. Улс орон бүрийн хувьд төсвийн төлөвлөлт тодорхой мөчлөгийн дагуу явагддаг бөгөөд сургалтыг энэ мөчлөгүүдтэй уялдуулан төлөвлөвөл үр дүнтэй. Төсөв Парламентэд өргөн баригдахаас хэдхэн өдрийн өмнө сургалт зохион байгуулахаар төлөвлөх нь тохиромжтой биш байдаг.

## *5. Сургалт зохион байгуулах газрыг сонгох*

Сургалтыг хаана зохион байгуулах нь сургалт амжилттай болоход ихээхэн нөлөөлдөг. Оролцогчдын хувьд сургалтандаа тогтвортой оролцож, сургалтын агуулгад анхаарах боломжтой байх нь илүү тохиромжтой. Хэрвээ оролцогчид сургалт болж байгаа газар хоноглохоор бол оройдоо ярилцлага зохион байгуулах, бие даан судлах материал өгөх, кино үзүүлэх зэргээр нэмэлт арга хэмжээ зохион байгуулж болно. Мөн оролцогчид сургалтын үед тав тухтай байх нөхцлийг хангах, бас тэдэнд дурсагдан үлдэхүйц арга хэмжээ байхаар зохион байгуулахад анхаарвал зохино.

## *6. Сургалтын хичээлийн сэдвүүдийг сонгох*

Сургалтын хичээлийн сэдвүүдийг сонгохдоо сургалтын хэрэгцээг тодорхойлох үнэлгээний үр дүн, зорилго, зорилт, үргэлжлэх хугацаа зэргийг харгалзах шаардлагатай. Нэг удаагийн сургалтаар хэт олон хичээлийн сэдвүүдийг хамруулахыг хичээх хэрэггүй. Оролцогчдод тухайн



сэдвийг ярилцах, дасгал ажиллахад хангалттай хугацаа байхаар төлөвлөх нь зүйтэй. Хэрвээ та өөрийн сайн мэдэхгүй асуудал, жишээ нь төсвийн үйл явц, төсвийн баримт бичгүүд гэх мэт сэдвүүдийг сонгохоор шийдсэн бол тухайн хичээлийг мэргэжлийн хүн урьж заалгах эсвэл энэ асуудлаар мэргэшсэн хэн нэгэнтэй хамтран хичээлээ явуулах боломжтой.

### *7. Заах хичээлийн дарааллыг зөв тодорхойлох*

Сургалтын хөтөлбөрөө боловсруулахдаа сургалтын хүрээнд хамрах хичээлийн сэдвүүдээ ямар дараалалтайгаар байрлуулахаа сайтар бодох хэрэгтэй. Хичээл хоорондын уялдааг хангахын зэрэгцээ зарим хичээлүүдийн үндэслэлийг гаргахад анхаарах шаардлагатай. Хэрвээ та жендэрийн асуудлыг макро эдийн засгийн загвартай уялдуулах асуудлаар ярилцлага өрнүүлэх гэж байгаа бол цаг ашиглалтын тоо мэдээлэл цуглуулах, өртөг тооцох, нормчлох асуудлаарх хичээлийг өмнө нь оруулахаар төлөвлөх нь зүйтэй.

### *8. Сургалтын арга хэрэгслийг сонгох*

Сургалтын үргэлжлэх хугацаанаас хамааран сургалтын дараах аргуудаас аль болох олон хэлбэрийг ашиглахыг хичээх хэрэгтэй. Тухайлбал,

- Сургагч багшийн лекц (PowerPoint дээр бэлтгэсэн лекц болон прожектор ашиглах гэх мэт)
- Унших материал өгөх, кино үзүүлэх
- Бүлгээр ярилцах, дасгал ажиллуулах, тохиолдлын жишээн дээр ажиллах, дүрийн тоглолт хийлгэх, багаар ажиллуулах (ихэвчлэн гурваас зургаан хүнээс бүрдсэн бүлгүүдэд богино хугацаанд гүйцэтгэх даалгавар өгч ажиллуулах)
- Оролцогчдоор танилцуулга хийлгэх

Эдгээр аргуудыг ашиглах нь олон талын ашигтай. Бүлгийн ярилцлага нь жишээлбэл, тодорхой сэдвийн хүрээнд нэгдсэн ойлголттой болоход тустай, харин лекц, унших материал өгөх нь мэдлэг мэдээллийг дамжуулахад тусална. Дасгал ажиллуулах, тохиолдлын жишээ болон дүрийн тоглолт нь хэдийгээр нилээд их цаг хугацаа шаарддаг ч оролцогчдыг татан оролцуулах, шинээр олж авсан мэдлэг мэдээлэл ашиглахад тусална. Ер нь нэг өдрийн сургалт хийхдээ ч оролцогчдыг өдрийн туршид сургалтандаа сонирхолтой байлгах үүднээс нэгээс хоёр дасгал ажлыг оруулан төлөвлөх нь зүйтэй.

### *9. Дасгал ажлуудыг боловсруулах*

Тус сургалтын гарын авлагад олон хэлбэрийн дасгал ажлууд багтсан бөгөөд та жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийн сургалт зохион байгуулахдаа ашиглах боломжтой. Гэвч эдгээр дасгал ажлууд нь зөвхөн санал болгож байгаа хувилбарууд бөгөөд та сургалтын болон өөрийн зорилгодоо нийцүүлэн өөрчлөх боломжтой төдийгүй, өөрөө цоо шинэ дасгал ажил зохион оруулах ч боломжтой.

### *10. Тараах материал, унших материалуудыг бэлтгэх*

Сургалтанд оролцогчдод зарим мэдээллийн хүрээнд тодорхой тараах материалуудыг хувилж олшруулан өгөх хэрэгтэй. Түүнчлэн жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийн асуудлаарх өөр бусад гарын авлагууд болон интернетээр хайлт хийн мэдээлэл олох боломжтой бөгөөд бусад орнуудын жишээнүүдийг тараах материалдаа ашиглах нь зүйтэй. Энэ сургалтын гарын авлагын төгсгөлд унших нэмэлт материалууд болон веб сайтуудын жагсаалтыг оруулсан болно.

### *11. Сургалтыг эхлүүлэх*

Сургалт эхлэхэд оролцогчдыг өөрсдийгөө танилцуулахыг хүсч болно. Хэрвээ та олон өдрийн

сургалт хийхээр төлөвлөж байгаа бол оролцогчид тав тухтай байх, сонирхолтой уур амьсгал бүрдүүлэх үүднээс тэдний хоорондоо танилцах танилцуулгыг сонирхолтой хийх нь чухал ач холбогдолтой. Өөрсдийгөө танилцуулахыг хүсэх “Нууц хүсэл” нэртэй дасгал ажил нь ихэвчлэн нүүр хагалах зорилгоор ашиглахад хамгийн тохиромжтой байдаг бөгөөд жендэрийн асуудлаар ярилцах ярилцлагыг эхлүүлэхэд дөхөмтэй байж болох юм.

### **Оролцогчид өөрсдийгөө танилцуулах жишээ:**

Оролцогч бүр өөрийн хамтрагчаа сонгож хувь хүний хувьд холбоотой гэж үзсэн нэр, нас, боловсролын байдал гэх мэт мэдээллүүдээ сонгосон хамтрагчтайгаа хуваалцана. Дараа нь хамтрагчаасаа дараах асуултуудыг асууна. Үүнд:

- Та хийдэг ажлаа хэрхэн дүрслэн тодорхойлох вэ?
- Энэ сургалтанд оролцох болсон шалтгаан тань юу вэ?
- Энэ сургалтанд оролцсоноор эрхэлсэн ажилдаа хэрэг болох ямар зүйлийг сурна гэж хүлээж байгаа вэ?
- Таны эрхэлсэн ажлын ямар чиглэлд энэ сургалт илүү тохиромжтой гэж та бодож байна вэ?

Хамтрагчдад “Нууц хүслийн тухай” дараах асуултад үнэнчээр хариулахыг хичээхийг анхааруулна. “Та хийхийг үргэлж хүсдэг ч эрэгтэй эсвэл эмэгтэй хүн болж төрснийхөө улмаас хийж чаддаггүй зүйл байдаг уу?” Ингээд оролцогч бүр өөрийн хамтрагчийн хариултыг тараан өгсөн картан дээр тэмдэглэнэ. Төгсгөлд нь нийт оролцогчдын дунд хамтрагчийнхаа тухай болон түүний нууц хүслийн талаар товчхон танилцуулна.

Ихэнх тохиолдолд, хүмүүс жендэрийг зөвхөн эмэгтэйчүүдийн асуудал гэхчлэн өөр өөрсдийн ойлголтын хүрээнд буруу тодорхойлдог. Тиймээс, сургалтынхаа эхэнд жендэрийн үндсэн ойлголтыг танилцуулж, жендэрийн асуудал нь эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн аль алинд хамааралтай ойлголт гэдгийг тайлбарлах нь зүйтэй. Жендэрийн ойлголт болон жендэрийн дүн шинжилгээний хэрэглэгдэхүүнүүдийн талаар хэр зэрэг дэлгэрэнгүй тайлбарлах эсэх нь оролцогчид хэн байхаас ихээхэн хамаарна.

### *12. Үнэлгээ*

Сургалт бүрийн дараа үргэлжилсэн хугацаанаас хамааран оролцогчдоор үнэлгээний хүснэгтийг бөглүүлэх нь зүйтэй. Хэрвээ маш богино хугацааны (нэг өдрийн) сургалт зохион байгуулсан бол оролцогчдоор хоёр өнгийн картуудаас сонгон авч нэг дээр нь “өнөөдөр би юу сурав”, нөгөө дээр нь “өнөөдөр юу орхигдсон бэ” гэсэн асуултад хариулахыг хүснэ. Нэгээс илүү өдрийн сургалтуудын хувьд, оролцогчдоор үнэлгээний хуудас бөглүүлэх нь зүйтэй. Энэ нь оролцогчдын зүгээс сургалтын талаар илүү тодорхой үнэлгээ өгөх боломжийг олгоно. Оролцогчдын бөглөсөн үнэлгээнд анхааралтай дүн шинжилгээ хийж, үнэтэй саналуудыг анхааралдаа авах нь зүйтэй. Дараагийн сургалтын үед сайжруулах боломжтой олон зүйлсийг энэхүү үнэлгээнээс олж авдаг.



# 1

## Модуль 1

---

### **ЖЕНДЭРИЙН МЭДРЭМЖТЭЙ ТӨСӨВЛӨЛТ: ҮНДСЭН ОЙЛГОЛТ, ЗОРИЛГО, ҮЙЛ ЯВЦ**

Хичээл 1. Жендэрийн тэгш байдал ба жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлт

Хичээл 2. Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийн үйл явц

---

**МОДУЛЬ 1.****ЖЕНДЭРИЙН МЭДРЭМЖТЭЙ ТӨСӨВЛӨЛТ: ҮНДСЭН ОЙЛГОЛТ, ЗОРИЛГО, ҮЙЛ ЯВЦ**

Модуль нэг нь 1) Жендэрийн тэгш байдал ба жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлт, 2) Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийн үйл явц гэсэн хоёр хичээлтэй.

**ХИЧЭЭЛ 1.****ЖЕНДЭРИЙН ТЭГШ БАЙДАЛ БА ЖЕНДЭРИЙН МЭДРЭМЖТЭЙ ТӨСӨВЛӨЛТ**

<b>ХИЧЭЭЛИЙН АГУУЛГА</b>	
<b>Зорилго</b>	- Жендэр, жендэрийн тэгш байдал, түүнийг хангах арга замын талаар үндсэн ойлголттой болох - Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийн хэрэгцээ, ач холбогдлыг ойлгох
<b>Үндсэн ойлголтууд</b>	Хүйс ба жендэр, жендэрийн тэгш байдал Жендэрийн хэвшмэл ойлголт, жендэрийн ялгаатай хэрэгцээ Эмэгтэйчүүд хөгжилд, Жендэр ба Хөгжил хандлагууд Жендэрийн тэгш байдлын үзэл баримтлалыг бодлого төлөвлөлт, үйл ажиллагаанд тусгах стратеги (Gender mainstreaming) Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийн хэрэгцээ, эрх зүйн орчин Төсөв, төсвийн үйл явцын тухай Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлт, түүний зорилго Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлт ба ЖМ (Gender mainstreaming) Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийн ач холбогдол, үр нөлөө
<b>Аргачлал</b>	Лекц: PowerPoint танилцуулга, тараах материал, бүлгийн ажил
<b>Тараах материал</b>	Нэр томъёоны товч тайлбар Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийн санаачлагын жишээ
<b>Сургалтын хэрэглэгдэхүүн</b>	Мультимедиа проектор, Флипчарт, үзэг
<b>Хугацаа</b>	Нийт- 60 мин Танилцах – 5 мин PowerPoint танилцуулга – 20 мин Асуулт хариулт – 10 мин Дасгал ажил – 20 мин Дүгнэлт – 5 мин

**Унших материал:**

- Жендэрийн нэр томъёоны тайлбар толь, ЖҮХ, Жендэрийн консорциум, 2012
- Симон дө Бовуар. Дайвар хүйстэн. 2010
- Жендэр. Үндсэн ойлголтууд. 2013
- Жендэрийн тэгш байдлын үзэл баримтлалыг бодлого төлөвлөлт, үйл ажиллагаанаад тусгах нь сургагч багшид зориулсан гарын авлага, ЖҮХ, АХБ, 2014

**ХИЧЭЭЛИЙН УДИРДАМЖ****Хичээлийг удирдан явуулах зөвлөмж:**

1. Сургалтын эхэнд жендэрийн үндсэн ойлголтыг танилцуулж, жендэрийн асуудал нь эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн аль алинд хамааралтай ойлголт гэдгийг тайлбарлах нь зүйтэй. Мөн төсөвлөлт гэдэг нь хязгаарлагдмал хөрөнгийг онцгой шаардлагатай чиглэлүүдэд үр дүнтэй хуваарилах тухай асуудал гэдгийг онцлон тэмдэглэх нь зүйтэй. Үүндээ суурь мэдээлэлд байгаа тодорхойлолт, тайлбаруудыг ашиглана.

2. Үндсэн мэдээлэл өгсний дараа өрхийн төсвийн хүрээг тогтоох дасгал ажлыг бүлгийн ажлын зааварчлагын дагуу хийнэ.

3. Эцэст нь хичээлийг сургалтанд оролцогсдын оролцоотой дүгнэнэ.

### Лекцийн гол санаа:

Жендэр, жендэрийн тэгш байдал нь тэгш боломж бололцоо, сонголтын хүрээнд яригддаг бөгөөд эмэгтэй эрэгтэй хүмүүсийн, нийгмийн бүлгүүдийн ялгаатай хэрэгцээг бодлого төлөвлөлт, үйл ажиллагаанд анхаарч тусгах замаар хэрэгждэг.

Жендэрийн тэгш байдлыг хангах чиглэлээр дэлхий дахинд Жендэр ба Хөгжил хандлагыг баримталж, жендэрийн тэгш байдлын үзэл баримтлалыг бодлого төлөвлөлт, үйл ажиллагаанд тусгах стратегийг хэрэгжүүлж байна. Энэ стратеги нь бүх салбар, байгууллагад хэрэгжих ёстой.

Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлт нь дээрх стратегийн хамгийн гол бүрэлдэхүүн хэсэг нь юм. ЖМТ нь эцсийн дүндээ санхүүгийн нөөцийг оновчтой, үр өгөөжтэй хуваарилан зарцуулах, жендэрийн тэгш байдлыг хангах үйл ажиллагааг бодитой болгох зорилготой.

### Бүлгийн ажлын зааварчлага: Өрхийн төсөв"

Сургалтанд оролцогчдыг 2 бүлэгт хуваан хөдөөгийн болон хотын дундаж орлоготой өрхүүдийн төсвийг гаргах даалгавар өгнө. Нэг бүлгийн гишүүд хотын, нөгөө бүлгийн гишүүд хөдөөгийн өрхийн гишүүдийн дүрд тоглон, тэдний байр сууринаас хэлэлцэн өөр өөрсдийн хэрэгцээг өрхийн төсөвт тусгуулахыг чармайж өрхийн нэгдсэн төсвийг гаргана. Бүлгийн ажлын хугацаа дуусмагц тэднийг хийсэн ажлаа танилцуулахыг урина.

Танилцуулгын дараа сургагч багш дараах асуултуудыг тавьж хэлэлцэнэ.

- Өрхийн төсвийг хийхдээ шийдвэрээ яаж гаргасан бэ? хэн гаргасан бэ?
- Өрхийн төсөв хэнд илүү ашигтай болсон байна вэ?
- Ямар төрлийн зардлыг хамгийн чухал гэж, аль зардлыг чухал биш гэж үзсэн бэ?
- Өрхийн төсөв жендэрийн мэдрэмжтэй болсон уу?
- Хэн үүнийг сайжруулах боломжтой вэ?
- Улсын төсвийн үйл явц, өрхийн төсөв хоёрт нийтлэг зүйл юу байна вэ?
- Улсын төсөв өрхийн орлого, зарлагад нөлөөлөх үү? Жишээ нь эрүүл мэндийн зардал, түлш, цахилгааны үнэ гэх мэт.

### СУУРЬ МЭДЭЭЛЭЛ

Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийг хэрэгжүүлэхийн тулд:

- Хүйс ба жендэр
- Жендэрийн тэгш эрх, жендэрийн тэгш байдал
- Жендэрийн хэвшмэл ойлголт (стереотип)
- Жендэрийн практик ба стратеги хэрэгцээ
- Эмэгтэйчүүд хөгжилд болон Жендэр ба хөгжилд хандлага
- Жендэрийн тэгш байдлын үзэл баримтлалыг бодлого төлөвлөлт, үйл ажиллагаанд тусгах
- Чадавхи хөгжүүлэх, оролцоог хангах зэрэг олон улсын хэмжээнд хэрэглэж байгаа ойлголтуудыг зөв ойлгож, хэрэглэж сурах шаардлагатай.

**Хүйс нь** эмэгтэй эрэгтэй хүмүүсийн насан туршид нь үл өөрчлөгдөх биологийн ялгааг илэрхийлдэг бол жендэр нь эмэгтэй эрэгтэй хүмүүсийн нийгэмших явцад бүрэлдэн тогтдог, тэдэнд нийгмийн зүгээс хамаатуулан ойлгож буй шинж чанар, оноож буй үүрэг хариуцлага, байр суурийг илэрхийлдэг.

**Жендэр нь** нийгэм соёл бүрт харилцан адилгүйгээс гадна цаг хугацааны туршид хувьсан өөрчлөгдөж байдаг. Жендэр нь нийгмийн анги давхраа, нас, арьс өнгө, яс үндэс, шашин шүтлэг, газарзүй, эдийн засаг, улс төр, соёлын орчин гэх зэрэг олон үзүүлэлттэй харилцан хамааралтай бөгөөд хүмүүсийн хүлээсэн үүрэг хариуцлага, тулгарч буй саад бэрхшээл, хүртэж буй боломж бололцоог нь дүгнэн шинжлэх, бодлого төлөвлөлтөд харгалзаж үзэх боломжийг олгодог.

Эмэгтэй, эрэгтэй хүмүүс нийгэмдээ болон хувийн амьдралын хүрээндээ эн тэгш үнэлэгдэж, тэгш эрх мэдэл, оролцоотой байхыг **жендэрийн тэгш байдал** гэдэг. Тэгш байдлыг хангана гэдэг нь эмэгтэй эрэгтэй хүмүүст тэдэнд байгаа боломж бололцоо, нөлөөлж буй нөхцөл байдлаас үл хамааран адил тэгш хандах биш, харин нөхцөл байдал, боломж бололцоог нь адил тэгш болгоно гэсэн үг юм.

**Жендэрийн тэгш эрх** гэдэг нь эмэгтэй, эрэгтэй хүмүүсийг хоёуланд нь ялгаварлалгүй байх үйл явцыг хэлдэг.

Эмэгтэй эрэгтэй хүмүүсийн, тодорхой бүлгүүдийн шинж төрх, ялгаа, гүйцэтгэх үүргийн тухайд нийгэм соёлын нөлөөгөөр төлөвшин тогтсон хялбаршуулсан ойлголт, төсөөллийг **жендэрийн хэвшмэл ойлголт (стереотип)** гэж нэрлэдэг. Жендэрийн хэвшмэл ойлголт нийгэм соёл бүрт харилцан адилгүйгээс гадна цаг хугацааны явцад өөрчлөгддөг боловч эрэгтэйчүүдийг нийгмийн хүрээнд бүтээлч хөдөлмөр эрхлэгч, өрх гэрийн тэжээгч, харин эмэгтэйчүүдийг тэднээс хараат, голдуу өрх гэрийн хүрээнд хөдөлмөрлөгч гэж үзэх хандлагыг хадгалж бэхжүүлсэн түгээмэл шинжтэй байдаг. Жендэрийн хэвшмэл ойлголт нь эмэгтэй эрэгтэй хүмүүсийн талаарх бодит бус үнэлэмжийг нийгэмд төлөвшүүлж, тэдний хэрэгцээ, боломж бололцоог бодлого төлөвлөлтөд харгалзан үзэхэд, мэдлэг чадварыг үнэлэхэд саад болж байдаг. Мөн жендэрийн хэвшмэл ойлголт нь аль нэг хүйсэд, эсвэл хүн амын аль нэг бүлэгт шударга бус хандахын, аливаа шударга бус байдлыг зөвтгөхийн үндэс болж байдаг. Иймээс жендэрийн хэвшмэл ойлголтоос татгалзсанаар эмэгтэй эрэгтэй хүмүүсийн ялгаатай нөхцөл байдлыг, түүнээс үүдсэн ялгаатай хэрэгцээг олж харах боломж бүрддэг.

Эмэгтэй эрэгтэй хүмүүст тэгш боломжийг бодитойгоор олгохын тулд тэдний амьдралын нөхцөл байдал, тэдэнд байгаа бодит боломж, тулгарах асуудлаас нь үүдэн гарч буй ялгаатай хэрэгцээг нь хангахыг зорих ёстой. Эмэгтэй эрэгтэй хүмүүсийн энэ ялгаатай хэрэгцээг **жендэрийн практик ба стратеги хэрэгцээ** гэж ангилдаг. Жендэрийн практик буюу бодит хэрэгцээ нь эмэгтэй эрэгтэй хүмүүсийн жендэрийн үүргээс үүсэн гардаг, Жишээлбэл: усны хангамж, эрүүл мэндийн үйлчилгээ, хөдөлмөр эрхлэлт зэрэг амьдралын нөхцлийн тулгамдсан асуудалтай холбоотой хэрэгцээг энд нэрлэж болно. Ийм хэрэгцээг шуурхай практик арга хэмжээгээр богино хугацаанд хангах боломжтой байдаг. Харин стратеги хэрэгцээ нь эрэгтэй эмэгтэй хүмүүсийн гэр бүл, орон нутагтаа болон нийгэмдээ эзэлж буй ялгаатай байр суурьтай холбоотой, хүмүүс өөрсдөө илэрхийлэн гаргахад хэцүү, жендэрийн хэвшмэл ойлголтоос үүдсэн хүчтэй эсэргүүцэлтэй тулгарч байдаг.

Иймээс эрэгтэй хүмүүсийн жендэрийн стратеги хэрэгцээг жендэрийн дүн шинжилгээгээр илрүүлэх, түүнийг хүлээн зөвшөөрөх, хангах урт хугацааны өргөн хүрээтэй бодлого төлөвлөлтийг хийх нь төрийн үүрэг байдаг. Жишээлбэл тэгш боломж, тэгш эрхийг нь хангахад чиглэсэн хууль тогтоомж, түүний хэрэгжилт нь жендэрийн стратеги хэрэгцээнд голчлон чиглэдэг. Эмэгтэй эрэгтэй хүмүүсийн жендэрийн стратеги хэрэгцээг улс орны, салбарын, орон нутгийн хөгжлийн урт хугацааны бодлогод тусган төлөвлөж, хэрэгжүүлснээр нийгэм дэх жендэрийн тэгш бус байдлыг арилгах, ялгаварлан гадуурхлыг устгах боломжтой.


Жендэрийн ялгаатай хэрэгцээг хангах замаар эмэгтэй эрэгтэй хүмүүст тэгш боломж бололцоог, адил сонголтыг бий болгох нь "Жендэр ба хөгжил" хандлагын мөн чанар юм. 1980-аад оноос өмнө тэгш байдлыг хангах бодлого, үйл ажиллагаанд зонхилж байсан **"Эмэгтэйчүүд ба хөгжил"**, **"Эмэгтэйчүүд Хөгжилд"** хандлагууд нь эмэгтэйчүүдийг онцгойлон үзэж, тэднийг хөгжлийн үйл ажиллагаанд оролцуулахад анхаарч байсан бол **"Жендэр ба Хөгжил"** хандлага

нь эмэгтэйчүүдийг бүлгийнх нь хувьд онцгойлон үзэхэд бус, эмэгтэй эрэгтэй хүмүүсийн хооронд тухайн нийгэм цаг үед төлөвшсөн харилцаанд, түүнийг өөрчлөхөд голлон анхаардаг. Хөгжлийн аливаа үйл ажиллагаанд жендэрийн тэгш байдлын үзэл баримтлалыг нэгтгэж, охид хөвгүүдийн, эмэгтэй эрэгтэй хүмүүсийн хөгжлийн ялгаатай хэрэгцээг таньж мэдэх, түүнийг хангахад зорих нь Жендэр ба Хөгжил хандлагын мөн чанар юм.

**Жендэрийн тэгш байдлын үзэл баримтлалыг бодлого төлөвлөлт, үйл ажиллагаанд тусгах**

(Gender mainstreaming) гэдэг нь бүх хүрээ, түвшний аливаа бодлого, үйл ажиллагаа, түүний дотор хууль тогтоомж, төсөл хөтөлбөрийн эмэгтэй эрэгтэй хүмүүст ялгаатай нөлөөлөх байдлыг анхааран тооцохыг хэлнэ. Энэ нь мөн эмэгтэй эрэгтэй хүмүүсийг хоёр цул бүлэг гэж үзэх бус, тэдний доторх янз бүрийн бүлгүүдийн хэрэгцээ болон мэдлэг туршлагыг эн тэнцүү үнэлж, анхаарахад чиглэдэг. Жендэрийн тэгш байдлын үзэл баримтлалыг үйл ажиллагаанд тусгах нь хоёр талт үйл явц юм. Нэгдүгээрт энэ нь жендэрийн тэгш байдлын үзэл баримтлалыг бодлогод нэгтгэх зорилгоор хөгжлийн бодлогын асуудал, хамрах хүрээг шинэчлэн тодорхойлох, хоёрдугаарт, жендэрийн тэгш байдлын үзэл баримтлалыг өнөөгийн бодлого хөтөлбөр, төсвийн үйл явцад тусган оруулах явдал юм.

Жендэрийн тэгш байдлын үзэл баримтлалыг бодлого төлөвлөлт, үйл ажиллагаанд тусгахдаа дараах үе шатуудыг бүрэн хамрахад анхаарна.



**Зураг 1.** Жендэрийн тэгш байдлын үзэл баримтлалыг бодлого төлөвлөлт, үйл ажиллагаанд тусгах үе шатууд

Жендэрийн төсөвлөлт бол Жендэрийн тэгш байдлын үзэл баримтлалыг бодлого төлөвлөлт, үйл ажиллагаанд тусгах стратегийн амин чухал, салшгүй хэсэг нь юм.

Үндэсний болон олон улсын эрх зүй, бодлогын баримт бичгүүд	Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийн талаарх агуулга
Монгол улсын Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль (2011)	Жендэрийн Мэдрэмжтэй Төсөвлөлт (ЖМТ)-ийн арга зүйг бүх түвшинд нэвтрүүлэх
Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийг хэрэгжүүлэх Засгийн газрын дунд хугацааны үндсэн чиглэл 2013	Жендэрийн мэдрэмжтэй төсөв зохиох арга зүйг улсын нэгдсэн болон орон нутгийн төсвийг боловсруулах, батлах үйл явцад нэвтрүүлэх
Бээжингийн Үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр 1995 Бээжин+5 баримт бичиг, Хөгжлийн санхүүжилтийн асуудлаарх Дохагийн тунхаглал (2008)	Жендэрийн агуулга, үзэл санааг бодлого, хөтөлбөрийн төсвийн шийдвэртэй уялдуулах, эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн тэгш байдлыг хангахад чиглэсэн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд хангалттай төсөв хуваарилах



**Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийг товчоор төсвийн бүхий л үйл явцад жендэрийн тэгш байдлын үзэл баримтлалыг тусгах хэмээн тодорхойлж болно.** Энэ нь үндэсний, салбарын, орон нутгийн болон байгууллагын төсөвт жендэрийн үнэлгээ хийх, төсвийн үйл явцад жендэрийн үзэл баримтлалыг тусгах, улмаар төсвийг жендэрийн тэгш байдлыг хангах зорилгод нийцүүлэн сайжруулах цогц үйл явц юм. Төсвийг жендэрийн мэдрэмжтэй болгох ажил дангаараа хийгдэж буй мэт харагдавч энэ нь үнэн хэрэгтээ дээрх стратегийн бүх элементийг агуулсан байдаг.

Жендэрийн мэдрэмжтэй төсвийг эмэгтэй, эрэгтэй хүмүүст зориулсан тусдаа төсөв, жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийг салбар бүрт санхүүгийн нөөцийг эмэгтэй эрэгтэй хүмүүст тэгш хуваарилах явдал гэж буруу ойлгох нь түгээмэл байдгийг анхаарах хэрэгтэй.

Төсвийн баримт бичигт тусгасан тоонууд өнгөндөө жендэрийн хувьд ялгаварласан зүйлгүй, саармаг мэт боловч зардлын нийтлэг хэв шинж болон засгийн газрын орлого бүрдүүлж буй арга зам нь хүн амын янз бүрийн бүлгийн эмэгтэй эрэгтэй хүмүүст ялгаатай байдлаар нөлөөлж байдаг. Ийнхүү ялгаатай нөлөөлж байгаа нь эмэгтэй эрэгтэй хүмүүст байгаа цаг хугацаа, эдийн засгийн, чадавхийн нөөц боломж харилцан адилгүй, тэдэнд өрх гэрийн болон нийгмийн амьдралын хүрээнд тулгарч буй асуудлууд нь ялгаатай байдагтай холбоотой. Мөн эмэгтэй эрэгтэй хүмүүсийн нийгэмд гүйцэтгэх үүргийн талаарх хэвшмэл ойлголт, ажил хөдөлмөрийн хүрээн дэх жендэрийн ялгарал ч мөн нэгэн ижил хуваарилагдсан төсөв эцсийн дүндээ ялгаатай байдлаар нөлөөлөх үндэс болдог. Тиймээс эмэгтэй эрэгтэй хүмүүсийн ялгаатай хэрэгцээг анхаарч үзээгүй аливаа төсөв жендэрийн хувьд харалган байдаг.

Хүснэгт 1. Төсөв ба Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлт

Төсөв	Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлт
Төсөв гэдэг нь төлөвлөсөн зардал, орлогыг жагсаасан санхүүгийн төлөвлөгөө бөгөөд энэ утгаараа Засгийн Газрын бодлогын тэргүүлэх чиглэлүүдийг багтаасан байдаг. Төсөв нь Засгийн газрын хувьд хамгийн чухал бодлогын хэрэгслүүдийн нэг юм.	Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлт гэдэг нь төсвийн бүхий л үйл явцад жендэрийн тэгш байдлын үзэл баримтлалыг тусгах үйл явц юм. ЖМТ нь санхүүгийн нөөцийг илүү оновчтой, үр өгөөжтэй хуваарилах, зарцуулах, нийгэм, орон нутаг, хамт олны дотор байгаа жендэрийн аливаа асуудлыг шийдэх боломжийг бодитой болгодог шинжилгээний чухал хэрэгсэл юм.

ЖМТ гэдэг нь жендэрийн тэгш байдлыг сайжруулахад хувь нэмэр оруулах Засгийн газрын төлөвлөлт, төсвийн үйл явц юм. Салбарын болон орон нутгийн бодлого, төлөвлөлт, төсөвт байгаа жендэрийн гажуудлыг илрүүлэх, түүнийг залруулах арга хэмжээг тусгах нь жендэрийн мэдрэмжтэй төсвийн үйл явцын нэгэн хэсэг байдаг.

*Жендэрийн мэдрэмжтэй төсөв нь:*

- 1) жендэрийн тэгш байдлыг хангахад чиглэсэн, эсхүл нийгэмд чиглэсэн жендэрийн мэдрэмжтэй бодлого төлөвлөлтийг дэмжсэн, тэдгээрийг хэрэгжүүлэх төсөв,
- 2) салбар, байгууллагын жендэрийн мэдрэмжтэй ажиллах чадавхийг дээшлүүлэхэд зориулагдсан тусгайлсан төсөв,
- 3) тодорхой нэг тусгай анхаарал шаардаж буй бүлгийн ялгаатай хэрэгцээг хангахад чиглэсэн үйл ажиллагааны төсөв хэлбэрүүдээр хэрэгжиж байж болно.

ЖМТ нь мөн аливаа бодлого болон нөөц хөрөнгийн хуваарилалт, зарцуулалт нь эмэгтэй эрэгтэй хүмүүст, хөвгүүд охидод хэрхэн ялгаатай байдлаар нөлөөлж байгааг шинжлэх боломж олгодог. ЖМТ нь мөн төсвийн үйл явцыг илүү нээлттэй болгон эмэгтэй эрэгтэй хүмүүсийн, нийгмийн бүлгүүдийн оролцоог сайжруулах, төсвийн мэдээллийг илүү хүртээмжтэй, ойлгомжтой болгох,




төсвийн талаарх эрх зүйн орчныг сайжруулах гэх мэт олон сайн нөлөөтэй. ЖМТ–ийн өөр нэг чухал ач холбогдол нь эдийн засгийг илүү өргөн хүрээтэй харах, дэлхий нийтэд ихэвчлэн эмэгтэйчүүд гүйцэтгэдэг цалин хөлсгүй хөдөлмөрийг харгалзан үзэх боломж олгодогт оршино.

ЖМТ нь санхүүгийн нөөцийг илүү оновчтой, үр өгөөжтэй хуваарилах, зарцуулах, нийгэм, орон нутаг, хамт олны дотор байгаа жендэрийн аливаа асуудлыг шийдэх боломжийг бодитой болгодог гэж ерөнхийд нь дүгнэж болно.

Жендэрийн төсөвлөлт нь төсвийн гүйцэтгэлийг үнэлэхэд ашигладаг “гурван E” хэмээн нэрлэгддэг арвилал (economy), бүтээмж (efficiency), үр ашиг (effectiveness) гэсэн үзүүлэлтүүд дээр тэгш шударга (equity) гэх үзүүлэлтийг нэмэн баяжуулж “дөрвөн E” болгодог бөгөөд “дөрөвдэх E” болох жендэрийн хувьд тэгш шударга байдал нь бусад үзүүлэлтүүдээ улам сайжруулах нөлөөтэй.

Зураг 1.2: Төсвийн гүйцэтгэлийн үзүүлэлтүүд



Эх сурвалж: Sheila Quinn. Gender budgeting: practical implementation. 2009

## ХИЧЭЭЛ 2.

### ЖЕНДЭРИЙН МЭДРЭМЖТЭЙ ТӨСӨВЛӨЛТИЙН ҮЙЛ ЯВЦ

ХИЧЭЭЛИЙН АГУУЛГА	
<b>Зорилго</b>	- Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийн үе шатуудтай танилцах - Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийн үйл явцын талаар ойлгох
<b>Үндсэн ойлголтууд</b>	Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийн зарчмууд Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийн үе шатууд Улсын төсөв ба жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийн үйл явц
<b>Аргачлал</b>	Лекц: PowerPoint танилцуулга, тараах материал, бүлгийн дасгал ажил
<b>Тараах материал</b>	Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийн үйл явцын зураглал – Австрийн болон Өмнөд Африкийн жишээ
<b>Сургалтын хэрэглэгдэхүүн</b>	Мультимедиа проектор, Флипчарт, үзэг
<b>Хугацаа</b>	Нийт- 60 мин PowerPoint танилцуулга – 20 мин Бүлгийн ярилцлага – 15 мин Ярилцлагын тайлан – 10 мин Асуулт хариулт- 10 мин Дүгнэлт – 5 мин

#### Унших материал:

- Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай Монгол улсын хууль, УИХ, 2011
- Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийг хэрэгжүүлэх дунд хугацааны стратеги, ЗГ, 2013
- Монгол улсын төсвийн тухай хууль, УИХ

## ХИЧЭЭЛИЙН УДИРДАМЖ

### Хичээлийг удирдан явуулах зөвлөмж:

1. Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийн үйл явцыг багтаасан лекцээр эхэлнэ.
2. Тэргүүлэх чиглэл тогтоох бүлгийн ажлыг дасгалын зааварчлагын дагуу явуулна.
3. Хичээлийг дүгнэнэ.

### Лекцийн гол санаа:

Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлт нь циклээр тасралтгүй үргэлжлэх үйл явц. Жендэрийн төсөвлөлтийг байгууллагаас эхэлж, орон нутаг, салбарын түвшинд хэрэгжүүлэх замаар улсын төсвийг жендэрийн мэдрэмжтэй болгох боломжтой. Байгууллага, орон нутаг, салбарын төсвийг жендэрийн шинжилгээний үр дүнд тулгуурлан өөрчлөх боломж илүү.

### Дасгалын зааварчлага: Төсвийн зардлын тэргүүлэх чиглэл тогтоох

Сургалтанд оролцогчдыг дан эмэгтэйчүүдээс, мөн дан эрэгтэйчүүдээс бүрдсэн бүлгүүдэд хувааж эмэгтэйчүүдэд монголын эмэгтэйчүүдийн нөхцөл байдлын талаар, эрэгтэйчүүдэд монголын эрэгтэйчүүдийн нөхцөл байдлын талаар эрэгцүүлэн бодож бүлгээрээ ярилцаад дараах зүйлсийг тодорхойлон бичих даалгавар өгнө. Үүнд:

1. Дараа жилийн төсвийн хугацаанд шийдвэрлэх шаардлагатай эн тэргүүнд анхаарах найман тэргүүлэх чиглэлийг тогтооно.
2. Эдгээр найман тэргүүлэх чиглэлийн үйл ажиллагааг салбарын аль яам хариуцахыг бүлгийнхээ хүрээнд ярилцан тодорхойлно.
3. Өөрсдийгөө төсөв хуваарилах эрх бүхий албан тушаалтан хэмээн төсөөлж төсвийн нийт зардлыг салбаруудаар хуваарилна. (нийт дүн 100% байхаар хувиар илэрхийлнэ.)
4. Бүлгийн ажлуудыг танилцуулсны дараа асуулт тавьж ярилцана.

### Чиглүүлэх асуултауд:

- Эмэгтэй эрэгтэй багуудын гаргасан төсөвт ялгаа байна уу?
- Ямар ялгаа байна? Эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд тэргүүлэх чиглэлийг хэр ялгаатай сонгосон байна вэ?
- Ингэж ялгаатай сонгосон шалтгаан нь юу вэ?
- Эмэгтэйчүүд эрэгтэйчүүдийн хэрэгцээ өнөөгийн улсын төсөвт хэдий хэмжээгээр тусгагдаж байна? Хэнийх нь ямар хэрэгцээ орхигдож байна вэ?
- Энэ байдлыг залруулах ямар арга зам, боломж байна вэ?
- Байгууллага, орон нутаг, салбар дахь эмэгтэй эрэгтэй хүмүүсийн ялгаатай хэрэгцээг тодорхойлохын тулд ямар судалгаа үнэлгээ хийх шаардлага харагдаж байна вэ?


## СУУРЬ МЭДЭЭЛЭЛ

Жендэрийн төсөвлөлтийн үйл явц нь жендэрийн тэгш байдлыг хангах чухал арга хэрэгсэл юм. Тиймээс жендэрийн төсөвлөлтийг өргөн утгаар нь жендэрийн хувьд саармаг, мэдрэмжгүй төсвийг жендэрийн мэдрэмжтэй төсөв болгон хувиргах урт удаан хугацааны, хүчин чармайлт, улс төрийн хүсэл зориг шаардсан цогц үйл ажиллагаа гэж тайлбарлаж болно.

Жендэрийн төсөвлөлтийг ерөнхийд нь дараах 3 үндсэн шатаар харуулж болно. Үүнд:

- 1-р шат: Төсвийг жендэрийн тэгш байдлын үзэл баримтлал, хандлагаар шинжлэн үзэх
- 2-р шат: Дээрх жендэрийн шинжилгээнд үндэслэн төсвийг өөрчлөн сайжруулах
- 3-р шат: Жендэрийг төсөвлөлтийн үйл явцыг төсвийн дүн шинжилгээний зүйл анги болгон нэгтгэх

### Зураг 2. Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийн үндсэн үе шат



**I шат:** Эдийн засагч, санхүүгийн ажилтнуудын боловсруулсан төсөв хүмүүст цалин хөлс, бараа үйлчилгээ хэлбэрээр хүрч очихдоо тэдэнд хэрхэн нөлөөлж байгааг хүйсээр ялган шинжилснээр нэгдүгээрт, төсөв эмэгтэй эрэгтэй хүмүүст ялгаатай байдлаар нөлөөлж байгаа эсэхийг илрүүлж, хоёрдугаарт, төсвийн эцсийн хэрэглэгчдийн талаар хүйсээр ангилсан мэдээлэлтэй болдог. Энэ шатанд хийх шинжилгээ нь:

- Төсөв нь жендэрийн ялгаатай хэрэгцээг хэрхэн хангаж байгааг үнэлэх,
- Төсөв эмэгтэй эрэгтэй хүмүүст тэгш нөлөөлөхөд ямар хүчин зүйлс, хязгаарлалт садаа болж байгааг илрүүлэх,
- Төсөв нь жендэрийн тэгш бус байдлыг өөрчилж байгаа эсэхийг, хэдий хэмжээгээр өөрчилж байгааг тодруулах,
- Төсвийн бодлого нь жендэрийн бодлоготой хэр нийцэж байгааг нягтлах,
- Асран халамжлах эдийн засаг дахь эмэгтэй эрэгтэй хүмүүсийн оролцоог төсөвт харгалзан үзэх хэрэгцээг илтгэн харуулах ач холбогдолтой.

**II шат:** Эхний шатанд хийсэн шинжилгээгээр төсвийн хуваарилалт жендэрийн хувьд тэгш шударга биш, өөрөөр хэлбэл эмэгтэй эрэгтэй хүмүүсийн ялгаатай хэрэгцээнд нийцээгүй, жендэрийн тэгш бус байдлыг хадгалах, эсвэл гүнзгийрүүлэх нөлөөтэй байвал байгууллагын, орон нутгийн, салбарын төсвийг өөрчлөн сайжруулах хэрэгцээ гарна. Байгууллага, орон нутаг, салбарын төсвүүд жендэрийн мэдрэмжтэй болсноор улсын төсөв жендэрийн мэдрэмжтэй болох үндэс суурь бүрэлдэнэ. Улсын төсөвт хийх жендэрийн шинжилгээ нь илүүтэй макро эдийн засгийн түвшинд хамаатай бөгөөд үндэсний жендэрийн бодлоготой нийцэж байгаа эсэхэд анхаарна.

**III шат:** Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлт нь төсвийн агуулга төдийгүй төсөв боловсруулах, батлах, түүнийг хэрэгжүүлэх, хянах үйл явц, бүтцийн тухай асуудал юм. Нэг удаагийн дүн шинжилгээ, төсвийн сайжруулалтаар төсөвлөлт жендэрийн мэдрэмжтэй болохгүй. Тиймээс жендэрийг төсвийн хүрээний дүн шинжилгээний үндсэн үзүүлэлт болгон нэвтрүүлэх шаардлагатай. Төсөвт жендэрийн дүн шинжилгээг байнга хийлгэж хэвшүүлэхийн тулд чадавхи бэхжүүлэх, арга зүй эзэмшүүлэхээс гадна холбогдох эрх зүйн орчныг сайжруулах шаардлагатай болдог.

Эхний үе шатны агуулга жендэрийн төсөвлөлтийг хэрэгжүүлж буй түвшин, тухайн улс орон, салбар, орон нутаг, байгууллагад жендэрийн бодлого төлөвлөлт бий эсэх, тэр нь хэр хэрэгжиж байгаа, хүйсээр ангилсан мэдээлэл болон жендэрийн нөхцөл байдлын үнэлгээ хийгдсэн эсэхээс шалтгаалан өргөжиж болно. Тухайлбал, жендэрийн нөхцөл байдлын үнэлгээ хийгдээгүй, өөрөөр хэлбэл эмэгтэй эрэгтэй хүмүүст тулгарч буй асуудал, жендэрийн ялгаварт байдал тодорхой болоогүй тохиолдолд жендэрийн төсөвлөлтийг амжилттай эхлүүлэхийн тулд нөхцөл байдлын жендэрийн дүн шинжилгээ хийнэ. Мөн жендэрийн төсөвлөлтийг хэрэгжүүлэх гэж буй хүмүүс үндэсний жендэрийн бодлого, эрх зүйн орчинтой сайтар танилцсан байх шаардлага тулгарна. Хэрэв танил биш бол судлан үзээд тухайн байгууллага, орон нутаг, салбарт тавигдах жендэрийн тэгш байдлын зорилго, түүний биелэлтийг хэмжих шалгуур үзүүлэлтүүдийг тодорхойлно. Үүнийг хийснээр мөн хүйсээр ангилсан мэдээллийн цаашдын хэрэгцээ тодорхой болно.

Жендэрийн төсөвлөлтийн эдгээр үе шат нь эргэн давтагдах бөгөөд төсвийн үйл явцтай уялдуулан харвал эхний үе шат нь төсвийн үйл явцын эцэст буюу хяналт үнэлгээн дээр эргэн давтагдана. Өөрөөр хэлбэл төсвийн жендэрийн үр нөлөөний үнэлгээг төсвийн хэрэгжилтийн үнэлгээний шатанд хийж дараагийн төсвийн циклд санал өгөх байдлаар үргэлжилнэ. Үүнийг төсвийн нийтлэг үйл явцтай холбон үзвэл дараах байдалтай харагдана.

**Зураг 3.** Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийн үйл явц



Зураг 3-т харуулсан цэнхэр сумаар заасан нь төсвийн үйл явц бөгөөд ногоон сумаар үзүүлсэн нь жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийн үйл явц юм.



# 2

## Модуль 2

### **ТӨСВИЙН БҮТЭЦ, ТӨСӨВЛӨЛТИЙН ҮЙЛ ЯВЦ БА ЖЕНДЭР**

**Хичээл 1.** Монгол улсын төсвийн бүтэц, төсөвлөлтийн үйл явц

**Хичээл 2.** Төсөв цаг ашиглалт, нөхөн үржихүйн эдийн засагт нөлөөлөх нь

**МОДУЛЬ 2.****ТӨСВИЙН БҮТЭЦ, ТӨСӨВЛӨЛТИЙН ҮЙЛ ЯВЦ БА ЖЕНДЭР**

Модуль хоёр нь 1) Монгол улсын төсвийн бүтэц, төсөвлөлтийн үйл явц, 2) Төсөв цаг ашиглалт, нөхөн үржихүйн эдийн засагт нөлөөлөх нь сэдэвт хоёр хичээлтэй.

**ХИЧЭЭЛ 1.****МОНГОЛ УЛСЫН ТӨСВИЙН БҮТЭЦ, ТӨСӨВЛӨЛТИЙН ҮЙЛ ЯВЦ**

<b>ХИЧЭЭЛИЙН АГУУЛГА</b>		
<b>Зорилго</b>	Монгол улсын төсвийн бүтэц, төсөвлөлтийн үйл явц, төсвийн цаглабарын талаар нэгдсэн ойлголтонд хүрэх	
<b>Агуулга ба үндсэн ойлголтууд</b>	Монгол улсын төсвийн бүтэц Төсөвлөлтийн үйл явц Төсвийн цаглабар Монгол улсын төсвийг жендэрийн мэдрэмжтэй болгох боломж	
<b>Аргачлал</b>	Лекц: PowerPoint танилцуулга, тараах материал, бүлгийн дасгал ажил	
<b>Тараах материал</b>	Төсвийн бүтэц Төсвийн үйл явц Төсвийн цагалбар Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл	
<b>Сургалтын хэрэглэгдэхүүн</b>	Мультимедиа проектор, Флипчарт, үзэг	
<b>Хугацаа</b>	Нийт- 60 мин	PowerPoint танилцуулга – 20 мин Бүлгийн ярилцлага – 15 мин Ярилцлагын тайлан – 10 мин Асуулт хариулт- 10 мин Дүгнэлт – 5 мин
<b>Унших материал:</b>		
<ul style="list-style-type: none"> <li>- Монгол улсын Үндсэн хууль, 1992</li> <li>- Монгол улсын нэгдсэн төсвийн тухай хууль</li> <li>- Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, 2010</li> </ul>		

**ХИЧЭЭЛИЙН УДИРДАМЖ****Хичээлийг удирдан явуулах зөвлөмж:**

1. Монгол Улсын Засгийн газрын жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийг нэвтрүүлэх тухай эрх зүйн болон улс төрийн амлалтын талаар тайлбарлаж, оролцогчдод Жендэрийн тэгш байдлыг хангах тухай хууль, Жендэрийн тэгш байдлыг дэмжих тухай Монгол Улсын хуулийг хэрэгжүүлэх 2013-2016 оны дунд хугацааны үндсэн чиглэл, үйл ажиллагааны төлөвлөгөөний холбогдох зүйл заалт, олон улсын өмнө тавьсан зорилтуудыг танилцуулна.
2. Төсвийн үйл явцын зураглалыг бүлгийн ярилцлагын зааварчлагын дагуу хийлгэнэ.
3. Улсын төсвийн үйл явц ба жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийн үе шатуудын уялдааг тайлбарлан хэлэлцүүлнэ.
4. Хичээлээ дүгнэнэ.

**Лекцийн гол санаа:**

Төсвийн төсөвлөлтийн үйл явц нь төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнах гэсэн тодорхой үе

шатуудаар явагддаг хуульчлагдсан төрийн бодлого юм.

Зардлаар болон хөтөлбөрөөр ангилсан төсвийн ялгаанаас үүдэн төсвийн үр ашиг, үр дүнгийн мэдээллийг авах боломж харилцан адилгүй байдаг. Тиймээс илүү үр дүнтэй мэдээллийг авахын тулд төсвийн үйл явцыг жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийн үе шатуудтай уялдуулан ойлгох, улмаар Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийг нэвтрүүлэх хэрэгцээ урган гардаг. Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлт нь санхүүгийн удирдлагын тогтолцоо, бодлого эрх зүйн орчныг ч бас сайжруулахыг шаардана.

### **Бүлгийн ярилцлагын зааварчлага: Төсвийн үйл явцын зураглал**

Сургалтанд оролцогчдыг 4 бүлэгт хуваана. Үүнд: байгууллага, орон нутаг, салбарын болон үндэсний түвшинд төсвийн үйл явцыг зураглаж, үе шат бүрт нь жендэрийн төсөвлөлтийн ямар арга хэмжээг хэн, хэдийд, ямар арга замаар нэгтгэж болохыг бүлгээрээ хэлэлцэн тодорхойлох даалгавар өгнө.

Бүлгүүд ажлаа тайлагнасны дараа бүлэг тус бүрийн ажилласан түвшинд жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийг нэвтрүүлэхэд ямар саад бэрхшээл байгааг, мөн ямар дүрэм журам, тогтолцоог өөрчлөх шаардлагатайг нийтээрээ ярилцана. Үүний дотор төсвийн үйл явцад оролцогчдын жендэрийн тэгш байдлыг хангах тухай асуудлыг хөндөн ярина.

## **СУУРЬ МЭДЭЭЛЭЛ**

Төрийн үүрэг, нийгэм-эдийн засгийн бодлогыг хэрэгжүүлэхэд шаардагдах төвлөрсөн санхүүгийн эх үүсвэрийг бий болгох зорилгоор тухайн жилд төрийн мэдэлд хуримтлуулан хуваарилж, зарцуулах мөнгөн хөрөнгийн орлого, зарлагын тэнцлийг Монгол Улсын нэгдсэн төсөв гэнэ. (Монгол улсын нэгдсэн төсвийн тухай хууль, 3.1, 2002.11.20)

Монгол улсад төсвийг төсвийн шатлалаар, төсвийн захирагчаар, эдийн засгийн ангиллаар, хөтөлбөрөөр, арга хэмжээгээр, санхүүжүүлэх эх үүсвэрээр тус тус ангилдаг. Үүний дотроос эдийн засгийн буюу зардлын нэр төрлөөр хийх ангиллыг түлхүү ашигладаг. Энэхүү ангилалд цалин, үйл ажиллагаа болон засвар үйлчилгээ, тэтгэмж зэрэг зүйлд зарцуулах мөнгөний (орц) хэмжээ, түүнчлэн холбогдох яам, агентлагуудын талаарх мэдээллийг багтаадаг. Гэхдээ энэ нь төсвөөс санхүүжилттэй үйл ажиллагаа, түүнээс гарах гарц, үр ашиг болон хүрсэн үр дүнгийн талаар мэдээлэл агуулдаггүй.

2011 оны 12 дугаар сарын 23-ны өдөр батлагдсан Монгол улсын Төсвийн тухай хуулийн дагуу Засгийн газар 2013 оны төсвийн жилд Хөтөлбөрт суурилсан төсвийн системийг нэвтрүүлж эхлээд байна. Энэ аргачлал нь орц (зарцуулсан мөнгөний хэмжээ), үр дүн (гарц, үр ашиг) хоёрыг холбож, улмаар тавьсан зорилго, зорилтуудын биелэлтийг хянах боломжийг бүрдүүлж байгаа юм. Хөтөлбөрт суурилсан төсвийн аргачлал нь стратегийн төлөвлөлтийг дунд хугацааны болон жилийн төсөв, түүний гүйцэтгэлтэй илүү нягт холбож өгдөг. 2013 онд хөтөлбөрт суурилсан төсөвлөлтийн аргыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд УИХ-аас хэрэгжүүлэх хөтөлбөрүүд болон тэдгээрийн хяналт шинжилгээний шалгуур үзүүлэлтүүдийг Төсвийн тухай хуулийн хамт баталсан байна.

Төсвийн системтэй холбоотой хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Төсвийн тухай хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрддэг. Үүнээс төсвийн тухай хууль нь (2011 оны шинэчилсэн найруулга) төсөв, түүний зарчим, тогтолцоо, бүрэлдэхүүн, ангиллыг тогтоож, төсвийн тусгай шаардлагыг хэрэгжүүлэх, төсвийн харилцаанд оролцогчийн эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлж, төсөв боловсруулах, батлах, зарцуулах, бүртгэх, тайлагнах, хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулахад чиглэсэн.

2010 онд батлагдсан Төсвийн тогтвортой байдлын тухай хууль нь үндэсний баялгийг хүн ам,

нийгмийн бүлэг болон өнөө ба хойч үеийнхэнд шударга, тэнцвэртэй хуваарилах, төсвийн хөрөнгийн хуваарилалт, байршуулалт, хэрэглээ нь эдийн засгийн үр ашигтай, нийгмийн ач холбогдолтой байх төсвийн удирдлагын зарчмыг тодорхойлсон. Тус хуулийн дагуу нэгдсэн төсвийн дунд, урт хугацааны тогтвортой байдлыг хангах зорилго бүхий **Төсвийн тогтворжуулалтын сантай** байх бөгөөд тус сангийн хөрөнгө нь дотоодын нийт бүтээгдэхүүний таван хувиас доошгүй байна.

Монгол Улсын нэгдсэн төсөв нь **улсын төсөв, орон нутгийн төсөв, нийгмийн даатгалын сангийн төсөв, хүний хөгжил сангийн төсвөөс** бүрдэнэ.

**Аймаг, нийслэлийн төсвийн** дээд шатны төсөв нь **улсын төсөв, сум, дүүргийн төсвийн** дээд шатны төсөв нь аймаг, нийслэлийн төсөв байна. Орон нутгийн төсөв нь аймаг, нийслэл, сум, дүүргийн төсвөөс бүрдэнэ. “Хүний хөгжил сангийн төсөв” гэж Хүний хөгжил сангийн тухай хуулийн дагуу бүрдүүлж, зарцуулах, тухайн жилд Улсын Их Хурлаас баталсан төсвийг хэлнэ.

**Зураг 4.** Төсвийн шатлал



2011 онд батлагдсан Төсвийн тухай хуулинд улс, аймаг, нийслэл хот, сум болон дүүргийн түвшинд орлого бүрдүүлэлт, зардлын удирдлага, төсвийн хэрэгжилтийг хангах тухай тодорхойлон зааснаар санхүүгийн төвлөрлийг сааруулах боломж бүрдсэн.

Дээд шатны төсвөөс доод шатны төсөвт дараах хэлбэрээр мөнгөн хөрөнгийг шилжүүлдэг. Үүнд:

- доод шатны төсвийн үндсэн тэнцлийн алдагдлыг санхүүжүүлэхэд зориулан дээд шатны төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг;
- доод шатны төсвийн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд нь зориулж дээд шатны төсвөөс олгох орлогын шилжүүлэг,
- Засгийн газрын хэрэгжүүлэх зарим чиг үүргийг орон нутаг төлөөлөн хэрэгжүүлэхэд зориулж улсын төсвөөс олгох тусгай зориулалтын шилжүүлэг.

Төсвийн тухай хуулийн 2011 оны шинэчилсэн найруулгад Орон нутгийн хөгжлийн нэгдсэн санг импортоос бусад бараа, ажил, үйлчилгээний нэмэгдсэн өртгийн албан татварын орлогын 25 хувь; ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлогын 5 хувь; орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор олгосон дотоодын төрийн бус байгууллагын болон гадаадын албан ёсны тусламж, хандив; болон төвлөрүүлэх хөрөнгөөс бүрдэхийг зааж өгсөн байна.

**Төсвийн үйл явц** нь төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх болон тайлагнах зэрэг хэд хэдэн үе шатаас

<sup>5</sup>Монгол Улсын Үндсэн хууль - "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1992 оны 1 дугаарт нийтлэгдсэн.

<sup>6</sup>Төсвийн тогтвортой байдлын тухай хууль - "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2010 оны 30 дугаарт нийтлэгдсэн.

<sup>7</sup>Төсвийн тухай хууль - "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 20.. оны .. дугаарт нийтлэгдсэн.



бүрддэг. **Төсвийн төлөвлөлтийн үйл явцад** төсвийн төсөл боловсруулан УИХ-д гардуулах болон Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг төлөвлөх, төсөвлөх, УИХ-аар төсвийг батлуулах, түүнчлэн шаардлагатай бол төсөвт нэмэлт өөрчлөлт оруулах, төсөвт тодотгол хийх зэрэг багтдаг.

Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад дараах зарчмуудыг баримтална. Үүнд:


- төсвийн тогтвортой байдал,
- иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх,
- санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх,
- ил тод байдлыг хангасан байх, хариуцлагатай байх.

Төсвийн үйл явц нь үндэсний, аймгийн болон орон нутгийн түвшинд дараах оролцогч талуудыг хамруулна, үүнд: УИХ ба Засгийн газар, Сангийн сайд болон Сангийн яам, Төсвийн захирагч нар болон Төсвийн ерөнхий нягтлан бодогч.

### Төсвийг төлөвлөх, батлах:

Төсвийг төлөвлөх үе шатанд төсвийн оролцогч нар дараах төрлийн баримт бичгүүдийг боловсруулдаг. Үүнд: эдийн засаг, төсвийн таамаглалыг боловсруулан тусгасан дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн ерөнхийлөн захирагчийн жилийн төсвийн хязгаар, улсын төсөв, нийгмийн даатгалын сангийн төсөв, хүний хөгжил сангийн төсөв, болон аймаг, нийслэлийн жилийн төсөв тус тус багтана.

### Зураг: Ерөнхий төсвийн үйл явц



Засгийн газар улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг дөрвөн жилд нэг удаа баталж, жил бүр тодотгох бөгөөд СЯ жил бүрийн 5 дугаар сарын 15-ны дотор тухайн жилд хийгдэх хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн тодотголын төслийг Засгийн газарт хүргүүлнэ. СЯ нь дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд заасан шаардлага, болзошгүй өр төлбөр болон бусад санхүүгийн эрсдлийн үнэлгээний дагуу Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг хянан шалгана. Төсвийн ерөнхийлөн захирагч нар 30.0 тэрбум төгрөгөөс доош нийт өртөг бүхий хөрөнгө оруулалтын төслүүд болон Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгагдаагүй бусад төслүүдийн саналыг СЯ-нд 8 дугаар сарын 15-ны дотор төсвийн саналын хамт хүлээлгэн өгнө.

**Төсвийн хэрэгжилт:** Төсвийн хэрэгжилтийн үе шатанд Төрийн сангийн тогтолцоо нь (Төрийн сан) үндсэн үүргийг гүйцэтгэнэ. Төсвийн тухай хуулийн 2011 оны шинэчилсэн найруулгын 6 дугаар бүлэгт төсвийн хэрэгжилтийн оролцогч талууд, тэдний үүрэг хариуцлагын талаар тусгасан. Төсвийн хэрэгжилтийн үе шатанд оролцогчид Төрийн сангийн нэгдсэн дансыг удирдах замаар төсөвт оролцдог. Санхүүгийн хөрөнгийг Монгол банкинд байрших Төрийн сангийн нэгдсэн дансаар дамжуулан удирдана. Төрийн сангийн тогтолцоо нь төв төрийн сан, аймаг, нийслэлийн

төрийн сан, сум, дүүргийн төрийн сан, төрийн захиргааны төв байгууллагын төрийн сангийн нэгж, төсвийн нягтлан бодогчоос бүрдэнэ. Төсвийн байгууллага нь төвлөрүүлсэн төсвийн орлого болон өөрийн үйл ажиллагааны орлогыг Төрийн сангийн нэгдсэн дансанд саадгүй байршуулах үүрэгтэй.

Төрийн сан дараах нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

- төсвийн хэрэгжилтийг зохион байгуулах, түүнд хяналт тавих;
- төсвийн орлого, зарлагын өдөр тутмын гүйлгээг хийх;
- төсвийн хяналтыг зардлын бүлэглэсэн дүнгээр хэрэгжүүлэх;
- төсвийн зарлагын төлбөрийн дарааллыг тогтоох;
- төсвийн гүйлгээг цахим системээр хэрэгжүүлж хяналт тавих;
- төсвийг бараа, ажил, үйлчилгээ худалдан авах гэрээний бүртгэл болон төлбөрийн даалгавартай харьцуулж төлбөрийн амлалтыг бүртгэх;
- төсвийн орлого, зарлага, хөрөнгө, өр төлбөрийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу холбогдох дансанд бүртгэх, тайлагнах;
- төсвийн сар, улирлын хуваарьт үндэслэн төсвийн байгууллагын бүртгэлийн дансанд санхүүжилтийн болон зарцуулалтын эрх олгох.

Төрийн сан нь аймаг, нийслэлийн төрийн сан болон төрийн захиргааны төв байгууллагын төрийн сангийн нэгжийн үйл ажиллагаанд, аймаг, нийслэлийн төрийн сан нь сум, дүүргийн төрийн сангийн үйл ажиллагаанд санхүүгийн дотоод хяналтыг тус тус хэрэгжүүлнэ.

Бүх шатны төсвийн захирагч төсвийн хэрэгжилтийн талаар дараах үүрэг хүлээнэ. Үүнд:

- хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх;
- батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах;
- төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах;
- төсвийн хуваарийг сар, улирлаар баримталж ажиллах;
- Төсвийн тухай хуулинд заасан эрхийн хүрээнд төсвийн байгууллагын зардлыг санхүүжүүлэх;
- төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэлийн санхүүжилтийг бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны гэрээ, төлбөрийн хуваарийг үндэслэн санхүүжүүлэх;
- хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах.

**Төсвийн тайлагналт:** Төсвийн тайлагналтын үе шатанд төсвийн гүйцэтгэл болон жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу гаргадаг. Төсвийн гүйцэтгэлийн тайлан нь дараах бүрэлдэхүүн хэсгүүдтэй. Үүнд:

- тухайн жилийн төсвийн орлого, зарлагын гүйцэтгэл (нийт дүнгээр, хөтөлбөрөөр, төсвийн захирагчаар, хөрөнгө оруулалтын арга хэмжээ бүрээр);
- татварын зарлагыг хуулийн этгээд, салбар бүрээр, холбогдох эрх зүйн үндэслэлийн хамт;
- тухайн жил худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэл;
- хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүн, түүний танилцуулга (хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан);
- нэмэлт төсвийн гүйцэтгэл, түүний танилцуулга.


Санхүүгийн нэгтгэсэн тайлан нь үйл ажиллагааны үр дүнгийн тайлан, санхүүгийн байдлын тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, санхүүгийн тайлангийн тодруулга гэсэн бүрэлдэхүүн хэсгүүдийг багтаана.

Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланд улс, орон нутгийн төсвийн санхүүгийн тайлан,

төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн санхүүгийн тайлан хамаарна.

Улсын төсвийн үйл явцыг жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийн үе шатуудтай дараах байдлаар уялдуулан харж болно.

**Зураг 5.** Улсын төсвийн үйл явц ба жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийн үе шатуудын уялдаа



**Төсвийн цаглабар**

Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийн зорилго нь улсын төсвийн орлого, зарлагыг жендэрийн хувьд тэгш, шударга байлгахад чиглэнэ. Энэхүү зарчмыг төсвийн үйл явцад тусгахад чиглэсэн үйл ажиллагаа өрнүүлэхийн тулд төсвийн төлөвлөлт, явцын янз бүрийн үе шатууд, түүнчлэн холбогдох цаг хугацааны хуваарийн талаар ойлголттой байх нь чухал.

Дээр дурдсан төлөвлөлт, төсвийн холбогдолтой баримт бичгүүдийг боловсруулах болон батлуулах цаглабар, үйл ажиллагаа болон хариуцах этгээдүүдийг дараах хүснэгтээр харуулав.

Хугацаа	Үйл ажиллагаа	Хариуцах этгээд
<b>Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл</b>		
4 сарын 15-ны дотор	Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг ирэх жилийн эдийн засгийн урьдчилсан тооцоолол дээр үндэслэн боловсруулах	Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага (СЯ)
5 сарын 1-ний дотор	Засгийн газар дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг хэлэлцэн Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх	Засгийн газар
6 сарын 1-ний дотор	Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг хэлэлцэж, батлах	Улсын Их Хурал

Батлагдсанаас хойш ажлын 7 хоногийн дотор	Улсын Их Хурал дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийг хэвлэн нийтлэх	Улсын Их Хурал
---	--	----------------

#### Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд суурилсан жилийн төсвийн хязгаар

6 сарын 10-ны дотор	Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд суурилсан жилийн төсвийн хязгаарын саналаа санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх	Төсвийн ерөнхийлөн захирагчид
6 сарын 20-ны дотор	Төсвийн ерөнхийлөн захирагчийн жилийн төсвийн хязгаарын саналыг нэгтгэн боловсруулж, Засгийн газарт хүргүүлэх	Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага (СЯ)
7 сарын 1-ний дотор	Төсвийн ерөнхийлөн захирагчийн жилийн төсвийн хязгаарын төслийг хэлэлцэн батлах	Засгийн газар
7 сарын 5-ны дотор	Засгийн газрын баталсан жилийн төсвийн хязгаарыг төсвийн удирдамжийн хамт төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэх	Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага (СЯ)

#### Улсын төсөв, Нийгмийн даатгалын сангийн төсөв, Хүний хөгжил сангийн төсөв

7 сарын 25-ны дотор	Жилийн төсвийн төслөө харьяалах төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэх	Төсвийн төвлөрүүлэн захирагчид харьяалагддаг төсвийн шууд захирагчид
8 сарын 1-ний дотор	Жилийн төсвийн төслөө харьяалагдах төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэх	Төсвийн төвлөрүүлэн захирагч, төсвийн төвлөрүүлэн захирагчид харьяалагддаггүй төсвийн шууд захирагчид
8 сарын 15-ны дотор	Жилийн төсвийн саналаа санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад (СЯ) хүргүүлэх	Төсвийн ерөнхийлөн захирагчид
9 сарын 15-ны дотор	Төсвийн тухай хуулийн 8.4.3-т заасан жилийн төсвийн саналыг нэгтгэн боловсруулж, Засгийн газарт өргөн мэдүүлэх	Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага (СЯ)
10 сарын 1-ний дотор	Жилийн төсвийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх	Засгийн газар
10 сарын 15-ны дотор	Жилийн төсвийн төслийн талаарх дүгнэлтийг Улсын Их Хуралд хүргүүлэх	Төрийн аудитын төв байгууллага
11 сарын 15-ны дотор	Жилийн төсвийн төслийг хэлэлцэн батлах	Улсын Их Хурал

#### Аймаг, нийслэлийн жилийн төсөв

11 сарын 25-ны дотор	Тухайн шатны жилийн төсвийн төслийг тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх	Аймаг, нийслэлийн Засаг дарга
12 сарын 5-ны дотор	Тухайн шатны жилийн төсвийн төслийг хэлэлцэн батлах	Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
12 сарын 10-ны дотор	Тухайн шатны жилийн төсвийн төслийг тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх	Сум, дүүргийн Засаг дарга
12 сарын 20-ны дотор	Тухайн шатны жилийн төсвийн төслийг хэлэлцэн батлах	Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
12 сарын 31-ны дотор	Тухайн шатны жилийн батлагдсан төсвийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх	Аймаг, нийслэлийн Засаг дарга

Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийг дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн хамт салбарын яамдын бэлдсэн саналууд дээр суурилан СЯ боловсруулж, Засгийн газар болон УИХ-д өргөн мэдүүлж, улмаар хэлэлцүүлж батлуулдаг. Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийг боловсруулах цаглабар, болон үйл ажиллагааг дараах хүснэгтээр харуулав.

**Хүснэгт:** Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл

Хугацаа	Үйл ажиллагаа	Хариуцах этгээд
4-р сарын 01-ний дотор	Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төслийг боловсруулж, Засгийн газарт хүргүүлэх	Сангийн яам
5-р сарын 01-ний дотор	Төслийг дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нийцүүлэн хянаж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх	Засгийн газар
Хаврын чуулганаар	Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төслийг хэлэлцэн батлах	Улсын Их Хурал

## ХИЧЭЭЛ 2.

### ТӨСӨВ ЦАГ АШИГЛАЛТ, НӨХӨН ҮРЖИХҮЙН ЭДИЙН ЗАСАГТ НӨЛӨӨЛӨХ НЬ

ХИЧЭЭЛИЙН АГУУЛГА	
<b>Зорилго</b>	Төсөв эмэгтэй эрэгтэй хүмүүсийн, охид хөвгүүдийн цаг ашиглалтад, халамжийн эдийн засагт хэрхэн нөлөөлдөг талаар нэгдсэн ойлголт бий болгох
<b>Агуулга ба үндсэн ойлголтууд</b>	Халамжийн эдийн засаг Асран халамжлах ажил Эдийн засгийн уламжлалт болон нөхөн үржихүйн эдийн засгийг багтаасан жендэрийн мэдрэмжтэй загвар Эдийн засаг, төсвийн бодлого, арга хэмжээ цаг ашиглалт, нөхөн үржихүйн эдийн засагт нөлөөлөх нь Цаг ашиглалтын судалгаа
<b>Аргачлал</b>	Лекц: PowerPoint танилцуулга, тараах материал, бүлгийн хэлэлцүүлэг
<b>Тараах материал</b>	Цаг ашиглалтын судалгааны аргачлал
<b>Сургалтын хэрэглэгдэхүүн</b>	Мультимедиа проектор, Флипчарт, үзэг
<b>Хугацаа</b>	Нийт- 60 мин PowerPoint танилцуулга – 20 мин Бүлгийн ярилцлага – 15 мин Ярилцлагын тайлан – 10 мин Асуулт хариулт- 10 мин Дүгнэлт – 5 мин

**Унших материал:**

- Цаг ашиглалтын судалгааны тайлан, ҮСХ, 2011
- Эмэгтэй ажиллагчдын эрх ба жендэрийн тэгш байдлын лавлах, 2011
- Жендэр судлал сэтгүүл Дугаар 1. 2014

## ХИЧЭЭЛИЙН УДИРДАМЖ

### Хичээлийг удирдан явуулах зөвлөмж:

1. Эдийн засгийн уламжлалт загвар болон жендэрийн мэдрэмжтэй загварын талаарх үндсэн ойлголтыг лекцээр өгнө.
2. Цаг ашиглалтад төсөв хэрхэн нөлөөлж байгаа талаарх ярилцлагыг чиглүүлэх асуултуудын хүрээнд өрнүүлнэ.
3. Хичээлийг дүгнэнэ.

### Лекцийн гол санаа:

Эдийн засгийн уламжлалт загварт нөхөн үржихүйн эдийн засгийг тооцдоггүй нь Засгийн газарыг төсөвт төвлөрсөн орлогыг зөвхөн хуваарилахад илүүтэй хандуулж, байгалийн болон нийгмийн хүрээний нөөц баялгийг тэтгэх, хамгаалах асуудлыг бодлогын гадна үлдээхэд хүргэдэг. Эдийн засгийн жендэрийн мэдрэмжтэй загвар нь эдийн засгийн эцсийн үр нөлөөг илүү тодорхой ойлгоход тусалдаг.

### Хэлэлцүүлгийн чиглүүлэх асуултууд:


- Эдийн засгийн бодлого, төсвийн зарцуулалт хот хөдөөгийн айл өрхүүд, эмэгтэй эрэгтэй хүмүүст хэрхэн нөлөөлж байна вэ? Жишээ? Нийгмийн салбарын төсөв хасагдах, замын салбарт хөрөнгө оруулалт хийх, шууд бус татварыг нэмэгдүүлэх гэх зэрэг жишээ өгч асуулыг нарийсган чиглүүлнэ.
- Цаг ашиглалтад төсөв хэрхэн нөлөөлж буйг байгууллага, орон нутаг, салбарын түвшинд хэн хэрхэн хийж болох вэ?

## СУУРЬ МЭДЭЭЛЭЛ

Нийгмийн гишүүдийн үйл ажиллагааны одоогийн болон ирээдүйн ажиллах хүч, бусад хүн амыг халамжлахад чиглэсэн хоол, хувцас, орон байраар хангах зэрэг материаллаг болон нийгмийн шинжтэй үйл ажиллагааны цалин хөлсгүй гүйцэтгэгдэж байдаг хэсгийг халамжийн буюу нөхөн үржихүйн эдийн засаг гэдэг. Бага насны хүүхдүүд, өвчтэй хүмүүс, тахир дутуу хүмүүс болон өндөр настнуудыг асран халамжлах ажлыг өрх гэрийн болон орон нутгийн түвшинд эмэгтэйчүүд голдуу гүйцэтгэдэг. Асран халамжлах ажил нь ажил мэргэжил хэлбэрээр гүйцэтгэгдсэн үедээ доогуур түвшний бага цалинтай ажил байж, гэр орны ажил хэлбэрээр хийгдэх үедээ ямар нэгэн байр суурь, цалин хөлсгүй байдаг. Энэ ажил нь эмэгтэйчүүдийн хувьд гэр орны ажлынх нь үргэлжлэл, нэг хэсэг нь болдог.


Эдийн засгийн уламжлалт загварт (зураг 1.) нөхөн үржихүйн эдийн засгийг тооцоогүй байдаг. Энэ загварт өрхүүдийг үйлдвэрлэгч бус, зөвхөн хэрэглэгч гэж үздэгээс гадна өрхийг нэгж болгохдоо түүний доторх гишүүдийн ажил үүрэг, эрх мэдлийн хуваарилалтыг харгалздаггүй.

Эдийн засгийг ийнхүү уламжлалт загвараар авч үзсэн тохиолдолд засгийн газрын үүрэг нь орлогыг хуваарилах, засгийн газрын төсвийг бүрдүүлэхийн тулд татварыг нэмэгдүүлэх, төсвийн нөөц хангалттай бол татварыг бууруулах үүрэг гүйцэтгэгч болж харагдана. Энэ загвар нь мөн байгалийн болон нийгмийн хүрээний нөөц баялгийг тэтгэх, хамгаалан хөгжүүлэх ажлыг багтаадаггүй. Эдийн засаг бүхэлдээ **хадгаламж+импорт=хөрөнгө оруулалт+экспорт** гэсэн тэгшитгэлээр илэрхийлэгдэнэ. Хэдий эдийн засаг ийм маягаар тэнцвэртэй харагдаж болох ч энэ нь хүн бүр ажилтай эсэх, ядуурал байгаа эсэх, хүний хөгжлийн нөхцөл бүрэлдсэн эсэхийг илэрхийлж чадахгүй юм. Энэ тохиолдолд төсөв нь зөвхөн төрийн санхүүгийн менежментийн арга, эдийн засаг, мөнгөний урсгалд анхаарсан хяналтын хэрэгсэл болж харагдана.

**Зураг 1.** Эдийн засгийн уламжлалт загвар

Жендэр ба хөгжил хандлагыг үндэслэгчдийн нэг Английн эрдэмтэн Диане Элсон нөхөн үржихүйн эдийн засгийг багтаасан эдийн засгийн жендэрийн мэдрэмжтэй загварыг дэвшүүлсэн байдаг (Зураг 2). Энэ загвар нь макро эдийн засгийн сэтгэлгээнд нөхөн үржихүйн буюу халамжийн эдийн засгийг нэгтгэн харуулсан бөгөөд үндэсний нийт бүтээгдэхүүнийг дараах гурван секторын бүтээгдэхүүний нийлбэр гэж үзжээ. Үүнд:

- Хувийн хэвшлийн бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний зах зээл
- Төрийн үйлчилгээний эдийн засаг
- Өрхийн болон орон нутгийн халамжийн эдийн засаг.

**Зураг 2.** Эдийн засгийн жендэрийн мэдрэмжтэй загвар

Эдийн засгийн энэ загварынхаа хүрээнд Д.Элсон дараах бүрэлдхүүн хэсгүүдийг шинжлэн үзэх боломжтой гэжээ. Үүнд:

- Эмэгтэй эрэгтэй эзэнтэй буюу удирдлагатай компаниудад засгийн газрын зарцуулж буй хөрөнгийн харьцааг тооцох,
- Хөрөнгө оруулалт, экспортын нийт дүр зурагт жендэрийн шинжилгээ хийх
- Орлого бүрдүүлэлтэд жендэрийн шинжилгээ хийх,
- Үндэсний орлогын хэдий хэсэг нь өрхүүдэд, жендэрийн ямар дүр зурагтайгаар хүрч байгааг шинжлэх,
- Өрхийн зарлага, хадгаламжийн хэмжээнд жендэрийн шинжилгээ хийх
- Татвар шилжүүлэгт жендэрийн шинжилгээ хийх.

Нөхөн үржихүйн эдийн засаг хэт их ачаалалтай бол эдийн засагт сөргөөр нөлөөлдгийг эдийн засгийн жендэрийн мэдрэмжтэй загвар нь харуулдаг бөгөөд энэ загвараар төсөв нь төрийн үйлчилгээний эдийн засаг төдийгүй хувийн хэвшлийн бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний зах зээл,

өрхийн болон орон нутгийн халамжийн эдийн засагт жендэрийн тэгш байдлыг сайжруулах арга хэрэгсэл болж байна.

Макро эдийн засгийн загварыг жендэрийн хувьд илүү мэдрэмжтэй болгох зарчмын хоёр арга зам байдаг байна. Үүний нэг нь хүн амтай холбоотой бүхий л хэмжигдэхүүнүүдийг хүйсээр ангилал (жишээ нь хөдөлмөр эрхлэлт, цалин хөлс, хэрэглээний ялгаатай байдал, хуримтлалын түвшин). Ийнхүү хүйсээр ангилсан мэдээлэлтэй болох нь эмэгтэй эрэгтэй хүмүүсийн эдийн засгийн хүрээнд дэх нөхцөл байдлыг үнэлэх, бодлогод тусгах боломж олгоно. Хоёрдахь арга зам нь хөлсгүй халамжийн эдийн засгийн асуудлыг төлөөлөх шинэ хэмжигдэхүүн оруулах явдал юм.

### **Эдийн засгийн жендэрийн мэдрэмжтэй загвар**

Жендэрийн асуудлыг макро эдийн засгийн бодлоготой холбох үзэл баримтлал, түүний хүрээ, арга замыг боловсруулах ажлыг олон улсын түвшинд 1993 оноос Манчестерийн их сургууль болон эрдэм шинжилгээний хүрээлэнгүүдтэй хамтран тодорхой ажлын хэсгүүд гарч хийсэн байдаг.

Макро эдийн засгийн хүрээнд жендэрийн холбогдол бүхий асуудлаар үзэл баримтлалын дагуу болон туршилтын журмаар хийгдэж байгаа ажлууд бодлого боловсруулалт, төсөвлөлтөнд нөлөөлж эхэлж байна. Жишээ нь:

- Улс орнууд үндэсний тоо бүртгэлийн системдээ (үндэсний данс, цагийн нөөцийн судалгаа, тоо бүртгэл) эмэгтэйчүүдийн хөлсгүй хөдөлмөрийн үзүүлэлтүүдийг тооцоолон нэвтрүүлж үндэсний хавсралт дансанд тусгах гэж оролдож байна.
- Эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн хэрэгцээ шаардлагыг үндэсний төсөвт тусгах (жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлт, төрийн санхүү) ажил явагдаж байна.
- Бүтцийн зохицуулалт хийх хөтөлбөрт жендэрийн асуудлыг тусгах оролдлого хийгдэж байна.

### **Бүтцийн зохицуулалт**

Бүтцийн зохицуулалт нь төлбөрийн тэнцвэрийг туйлбартай сэргээн тогтоох, инфляцийг бууруулах, нэг хүнд ноогдох орлогыг тогтвортой нэмэгдүүлэх нөхцлийг бүрдүүлэхэд чиглэсэн зах зээлийн баримжаатай эдийн засгийн шинэчлэлийн хүрээний үйл явц юм. Үүний хамгийн анхны үе шат нь тогтворжуулах арга хэмжээнээс эхлэх бөгөөд нийтлэг арга хэмжээний улсын секторын зардлыг багасгах, инфляцийг бууруулахын тулд мөнгөний хатуу бодлого явуулах явдал юм. Үүнтэй зэрэгцэн мезо түвшинд салбарууд болон зах зээлийг шинэчлэх замаар дунд хугацааны янз бүрийн арга хэмжээ хэрэгжүүлнэ. Нийтлэг арга хэмжээнд худалдааг чөлөөтэй болгох, дотоодын санхүүгийн зах зээлд болон барааны зах зээлд төрийн оролцоог багасгах, улсын секторыг түүний дотор татварын тогтолцоо, төрийн зардлын бүтэц, улсын үйлдвэрийн газруудыг өөрчлөн шинэчлэх, хөдөлмөрийн нөөцийн ажил эрхлэх, шилжих талаар тавьсан хязгаарлалтуудыг цуцлах, хадгаламж, хөрөнгө оруулалтын хориг саадыг халах, тогтворжилт, бүтцийн өөрчлөлтийг дэмжих институцийг байгуулж бэхжүүлэх зэрэг арга хэмжээнүүд ордог. Эдгээр арга хэмжээний гол санаа нь шууд хяналтын оронд үнийн хөшүүргийг ашиглан өөрөөр хэлбэл урамшууллын тогтолцоог өөрчлөх замаар нөөцийн хуваарилалтыг өөрчлөх явдал юм. Тиймээс аливаа бүтцийн зохицуулалтын үр нөлөөг үнэлэхдээ хөтөлбөрүүдийг богино, дунд хугацааны элементүүдийг анхааран үзвэл зохино.

Олон улсын туршлагаас харахад макро эдийн засгийн бодлого, ялангуяа санхүүгийн бодлого нь эмэгтэйчүүдийн ажлын ачааллыг нэмэгдүүлж цагийн дарамт учруулах нь элбэг тохиолддог. Тухайлбал төсөвт нийгмийн, эрүүл мэндийн үйлчилгээний зардлыг бууруулах, ашиглалтын хураамжийг нэвтрүүлэх зэрэг төсвийн хүрээний арга хэмжээ нь эмэгтэйчүүдийн гэр орондоо гүйцэтгэх ажлын ачаалал эрс нэмэгддэг байна. Өргөн хэрэглээний барааны үнэ нэмэгдэхэд эмэгтэйчүүд хямд зүйл олохын тулд дэлгүүр рүү олон дахин явах, удаан цагаар явах, зардлаа хэмнэхийн тулд гэртээ хоол хүнс бэлтгэх зэргээр ажил үүрэг нь өөрчлөгддөг. Түүнээс гадна



эмэгтэйчүүд орлого олох, олон нийтийн ажилд илүү их цаг зарцуулах болсноор гэр орны ажлын ачаалал өрхийн залуу охид эмэгтэйчүүдэд ноогдож тэдний сурч боловсрохдоо зарцуулах цаг багасдаг дам нөлөө ч илэрдэг байна.

*Замби улсад нэг хүнд ноогдох эрүүл мэндийн төсвийн бодит зарцуулалт 1985 онд 1983 онтой харьцуулахад 16 хувиар буурсан. Үүний үр дагаварт эрүүл мэндийн төвүүд хаагдахад хүрч, харин иргэд эрүүл мэндийн үйлчилгээ авахын тулд хол газар явж, удаан хугацаанд дараалалд зогсож хүлээх шаардлагатай болсон. Замби эмэгтэйчүүдтэй цаг зарцуулалттай нь холбоотой ярилцахад тэд гэр бүлийн өвчтэй гишүүдийг асрах, үүнд эмнэлэгт хоол хүргэх, асрах зэрэг ажилд ихээхэн цаг зарцуулж, аж ахуйдаа зарцуулдаг цаг бага үлддэг талаар мэдээлсэн байна .*

*Перу улсын жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлт хийх санаачлагын хүрээнд Вилла Эл Салвадор хотын төсвөөс санхүүжиж хэрэгждэг нэгэн томоохон хөтөлбөрт дүн шинжилгээ хийсэн байна. "Аяга сүү" нэртэй хөтөлбөрийн хүрээнд жирэмсэн болон хөхүүл эхчүүд, зургаа хүртэлх насны хүүхдүүдэд өдрийн шаардлагатай сүүг үнэгүй өгдөг. Тус хөтөлбөрийг улсын төвлөрсөн төсвөөс орон нутгийн төсөв рүү хуваарилалт хийх замаар санхүүжүүлдэг. Тус хөтөлбөрийг дэмжих үүднээс эмэгтэйчүүдийн эрхэлж буй цалингүй хөдөлмөр нийт төсвийнх нь 23 хувьтай тэнцэж байна гэсэн тооцоо гарчээ.*

Тиймээс цаг ашиглалтын судалгааг хийж цаг зарцуулалтанд төсвийн нөлөөлөх байдлыг хүйсээр ангилан шинжилдэг. Эмэгтэй эрэгтэй хүмүүс, охид хөвгүүдийн цаг зарцуулалтад төсөв хэрхэн нөлөөлж байгааг шинжлэхийн тулд цаг ашиглалттай холбоотой мэдээллийг цуглуулах, үйл ажиллагааны төрлөөр ангилан шинжлэх, шинжилгээний үр дүнг эдийн засаг, төсвийн бодлогод тусгах ажлуудыг хийнэ. НҮБ-ын Мянганы төслийн Боловсрол ба Жендэрийн Тэгш Байдлын Ажлын Хэсгээс дэд бүтцэд, ялангуяа эрчим хүч, тээвэр, ус хангамж, ариун цэврийн байгууламж гэсэн дэд бүтцийн гурван салбарт хөрөнгө оруулалт хийх нь эмэгтэйчүүд, охидод учруулж буй цагийн дарамтыг багасгаж жендэрийн тэгш байдлыг хангахад нөлөөлөхийг онцлон тэмдэглэжээ.

Монгол улсад цаг ашиглалтын судалгааг Үндэсний статистикийн газраас 2000 оноос хойш 4 жил тутамд хийж байна. Цаг ашиглалтын судалгааг ийнхүү тогтмол давтамжтай хийснээр эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн цаг ашиглалтын байдалд урт богино хугацаанд гарч буй өөрчлөлтийн чиг хандлагыг тодорхойлох, түүнийг эдийн засаг, төсвийн бодлоготой уялдуулан шинжилж урт хугацааны бодлого төлөвлөлтөд тусгах боломж гарч байна. Жишээлбэл, 2010 онд хийсэн цаг ашиглалтын судалгааны дүнгээс үзэхэд эрэгтэйчүүд анхан шатны үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд (204 мин.), харин эмэгтэйчүүд гэрийн ажил, дэлгүүр явах үйл ажиллагаанд (229 мин.) нилээд их цагаа зарцуулж байжээ. 2000 оноос 2011 оны хооронд эмэгтэй эрэгтэй хүмүүсийн анхан шатны үйлдвэрлэлд болон суралцахад зарцуулах цаг багасч, харин албан байгууллагад хөдөлмөр эрхлэх, үр хүүхэд, гэр бүлийн ахмад настан, өвчтэй хүмүүсийг асран халамжлах, нийгэм соёлын үйл ажиллагаанд хамрагдах, олон нийтийн мэдээллийн хэрэгсэл ашиглах, өөрийгөө халамжлах цаг нь нэмэгдсэн байна.





# 3

## МОДУЛЬ 3

---

### ТӨСВИЙН ЖЕНДЭРИЙН ШИНЖИЛГЭЭ

Хичээл 1. Жендэрийн нөхцөл байдлын үнэлгээ

Хичээл 2. Бодлогын ба төсвийн орлого зарлага төлөвлөлтийн  
жендэрийн дүн шинжилгээ

---

**МОДУЛЬ 3.****ТӨСВИЙН ЖЕНДЭРИЙН ШИНЖИЛГЭЭ**

Модуль гурав нь 1) Жендэрийн нөхцөл байдлын үнэлгээ, 2) Бодлогын ба төсвийн (орлого, зарлагын) төлөвлөлтийн жендэрийн дүн шинжилгээ гэсэн хоёр хичээлтэй.

**ХИЧЭЭЛ 1.****ЖЕНДЭРИЙН НӨХЦӨЛ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ**

ХИЧЭЭЛИЙН АГУУЛГА		
<b>Зорилго</b>	- Жендэрийн асуудал, түүнийг хөгжлийн үйл явцад тусгах хэрэгцээний талаар нэгдсэн ойлголттой болох - Сургалтанд оролцогчид өөрсдийн ажиллаж буй (байгууллага, орон нутаг, салбарын хүрээнд, үндэсний) түвшин, хүрээнд жендэрийн ямар асуудал байж болох, түүнийг нарийвчлан шинжлэхийн тулд ямар мэдээлэл хэрэгтэйг ойлгох	
<b>Агуулга ба үндсэн ойлголтууд</b>	Жендэрийн төсөвлөлтийн үзэл баримтлалын хүрээ Жендэрийн нөхцөл байдлын шинжилгээ Бодлогын жендэрийн шинжилгээ болон төсвийн жендэрийн шинжилгээний уялдаа	
<b>Аргачлал</b>	Лекц: PowerPoint танилцуулга, тараах материал, бүлгийн дасгал ажил	
<b>Тараах материал</b>	Үндэсний түвшинд хийгдсэн жендэрийн нөхцөл байдлын үнэлгээний жишээ Орон нутгийн, салбарын түвшинд хийгдсэн жендэрийн нөхцөл байдлын үнэлгээний жишээ	
<b>Сургалтын хэрэглэгдэхүүн</b>	Мультмедиа проектор, Флипчарт, үзэг	
<b>Хугацаа</b>	Нийт- 60 мин	Асуулт хариулт – 5 мин PowerPoint танилцуулга – 10 мин Бүлгийн ярилцлага – 15 мин Бүлгийн ярилцлагын тайлан – 5 мин Цаг ашиглалтын судалгаа - 15 мин Тайлан – 10 мин Дүгнэлт – 5 мин

**Унших материал:**

- Төрийн захиргааны байгууллагуудад жендэрийн төсөвлөлтийг нэвтрүүлэх удирдамж. Вена, 2012 он
- Өөрчлөлтийг түргэсгэх нь: жендэрийн асуудлыг бодлогод тусгах үзэл баримтлал, 2005

**ХИЧЭЭЛИЙН УДИРДАМЖ****Хичээлийг удирдан явуулах зөвлөмж:**

1. Жендэрийн асуудал гэж юуг ойлгож байгааг сургалтанд оролцогчдоос асууж богинохон ярилцлага өрнүүлэх байдлаар хичээлээ эхэлнэ.
2. Төсвийн жендэрийн шинжилгээний хүрээнд хийгддэг жендэрийн нөхцөл байдлын үнэлгээний талаар суурь мэдээллийг ашиглан танилцуулга хийнэ.
3. Тухайн сургалтад оролцогчдын хэрэгцээнээс шалтгаалан дараах бүлгийн ярилцлага, цаг ашиглалтын судалгаа хоёрын аль нэгийг, хэрэгтэй гэж үзвэл хоёуланг нь хийлгэж болно. Сургалтанд оролцогчдын жендэрийн талаарх ойлголт тааруу бол цаг ашиглалтын судалгааг хийлгэх нь тохиромжтой. Энэ тохиолдолд хичээлийн цагийг сунган тохируулж болно.
4. Хичээлээ дүгнэнэ.

**Лекцийн гол санаа:**

Жендэрийн төсөвлөлт хийхийн тулд тухайн байгууллага, орон нутаг, салбар, улсад жендэрийн ямар асуудал байгааг судлан мэдэх, энэ талаар нэгдсэн ойлголттой болох хэрэгтэй.

**Бүлгийн ярилцлагын зааварчлага:**

Сургалтанд оролцогчдыг 3 бүлэгт хувааж тэдний ажлын хэрэгцээнээс шалтгаалан даалгавраа сонгож өгнө. Жишээлбэл олон салбарын төлөөлөгчдөд зориулсан сургалтыг үндэсний түвшинд хийж байгаа бол эрүүл мэнд, хөдөлмөр, хөдөө аж ахуй гэхчлэн гурван салбарыг, хэрэв сургалтыг нэг салбарын ажилтнуудад хийж байгаа бол үндэсний, аймаг/хот, сум/дүүргийн түвшинд гэхчлэн хувааж тухайн түвшин бүрт оршин байгаа жендэрийн асуудлыг хэлэлцүүлнэ. Хэрэв ашиглах судалгаа, мэдээлэл байгаа бол тарааж өгч ажиллуулна.

**Чиглүүлэх асуултууд:**

- Танай салбар, орон нутагт байгаа жендэрийн хамгийн тулгамдсан: асуудлыг гарга
- Эдгээр асуудлын уг шалтгаан нь юу вэ?
- Эдгээр асуудлыг хайхралгүй\шийдэхгүй орхивол ямар үр дагавар гарах вэ?
- Эдгээр асуудлыг шийдэхийн тулд засгийн газар, салбар, орон нутаг ямар арга хэмжээ хэрэгжүүлэх ёстой вэ?

**Дасгалын зааварчлага: Цаг ашиглалтын судалгаа**

Сургалтанд оролцогчдыг эмэгтэйчүүдийн болон эрэгтэйчүүдийн бүлгүүдэд хуваана. Бүлэг тус бүр өөрсдийн хүйсийн хүмүүсийнхээ нэг өдрийн цаг ашиглалтыг ярилцан дундаж байдлаар зураглаж тайлагнана. Тайланг сонссоны дараа багш дараах асуултуудаар хэлэлцүүлэг өдөөнө.

**Чиглүүлэх асуултууд:**

- Эмэгтэй эрэгтэй хүмүүсийн нэг өдрийн цаг ашиглалтаас жендэрийн ямар ялгаа харагдаж байна вэ?
- Энэ ялгаатай байдлаас ямар хэрэгцээ тэдэнд үүдэж байна вэ?
- Эдгээр хэрэгцээг шийдэхийн тулд засгийн газар, салбар, орон нутаг ямар арга хэмжээ хэрэгжүүлэх ёстой вэ?

Анхаарах зүйл: Жендэрийн судалгааны сэдвээр хийсэн дасгал ажлуудын үр дүнг дүгнэн ярилцахдаа асуудлыг шийдэхийн тулд өрх гэрийн доторх хөдөлмөрийн хуваарийг өөрчлөх тухай ярих нь соёлын хувьд зохистой биш, харин тэрхүү ялгаатай хөдөлмөрийн хуваарь болон түүнээс гарах үр дагаврыг Засгийн газрын бодлого арга хэмжээнд харгалзаж тусгах нь гол гэдгийг ойлгуулах хэрэгтэй.

**СУУРЬ МЭДЭЭЛЭЛ**


Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлт нь аливаа бодлого болон нөөц хөрөнгийн хуваарилалт, зарцуулалт нь эмэгтэй эрэгтэй хүмүүст, хөвгүүд охидод хэрхэн ялгаатай байдлаар нөлөөлж байгааг шинжилж,н үр дүнд нь тулгуурлан төсөвлөлтийг жендэрийн мэдрэмжтэй болгон сайжруулах үйл явц юм.

Жендэрийн төсөвлөлтийн хүрээнд хийгдэх шинжилгээнүүд нь эцсийн дүндээ “Төсөвлөлт жендэрийн мэдрэмжтэй байна уу? Өөрөөр хэлбэл төсвийн үйл явц, хуваарилалт, зарцуулалт нь нийгэм дэх эмэгтэй эрэгтэй хүмүүсийн, охид хөвгүүдийн ялгаатай хэрэгцээг хангахад чиглэж, жендэрийн тэгш байдалд эерэгээр нөлөөлж байна уу?” гэсэн асуултанд хариулах ёстой. Гэвч энэ асуултанд хариулахын тулд улс, орон нутаг, салбар, байгууллагад амьдарч, ажиллаж, үйлчилгээ хүртэж байгаа эмэгтэй эрэгтэй хүмүүсийн нөхцөл байдал ямар байгааг, тэдэнд ямар асуудал тулгарч, ямар тулгамдсан хэрэгцээ байгааг мэдэх шаардлагатай. Үүний дараа байгууллага, орон нутаг, салбарын, үндэсний бодлогод тэр хэрэгцээ хангалттай тусгагдсан эсэхийг үнэлэх, хэрэв тусгагдаагүй бол бодлогыг жендэрийн мэдрэмжтэй болгохын тулд **бодлогын жендэрийн**

**дүн шинжилгээ** хийдэг. Үүний эцэст сая гол асуултандаа хүрч ирэх ба төсөв нь жендэрийн мэдрэмжтэй бодлоготойгоо нийцэж, бодлогоо дэмжиж байгаа эсэхийг шинжлэн үздэг.

Эдгээр алхмыг зураглан үзүүлбэл жендэрийн төсөвлөлтийн хүрээ нь дараах байдлаар харагдана.

**Зураг 3. Жендэрийн төсөвлөлтийн үзэл баримтлалын хүрээ**



Хэрэв тухайн байгууллага, орон нутаг, салбар, улс нь жендэрийн нөхцөл байдлын үнэлгээг хангалттай сайн хийсэн, дахин шинэчлэх шаардлагагүй гэж үзвэл шууд бодлогын жендэрийн дүн шинжилгээ хийнэ. Хэрэв бодлого төлөвлөлт жендэрийн мэдрэмжтэй, жишээлбэл салбарын жендэрийн стратеги, үйл ажиллагааны төлөвлөгөө байгаа бол бодлогын жендэрийн дүн шинжилгээ хийх шаардлагагүй, шууд төсвийн жендэрийн дүн шинжилгээнд орж болно. Бодлого төлөвлөлт жендэрийн мэдрэмжтэй болоогүй, энэ чиглэлийн ажил хийгдэж эхлээгүй байгаа бол бодлогын болон төсвийн дүн шинжилгээг нэгэн зэрэг, хамтад нь хийж ч болно.

Жендэрийн тэгш байдлын эрх зүй, бодлогын орчин хөгжсөн Австри зэрэг орнууд төсвийн жендэрийн шинжилгээгээр эхэлсэн гурван үе шат бүхий загварыг гаргасан байдаг. Гэхдээ дэлхийн ихэнх улс орнууд, ялангуяа орон нутгийн түвшинд жендэрийн нөхцөл байдлын үнэлгээ, бодлогын жендэрийн шинжилгээ хийдэг. Энэ нь нэг талаас жендэрийн үндэсний бодлого тэр бүр орон нутгийн түвшинд тодорхой томъёологдоогүй байдгаас, нөгөө талаас орон нутаг бүрийн өвөрмөц нөхцөл, хэрэгцээг үндэсний бодлогод тусгаж чаддаггүйтэй холбоотой. Өмнөд Африкийн эмэгтэйчүүдийн төсвийн санаачлага нь жендэрийн мэдрэмжтэй бодлогын үнэлгээ хийх дараах 5 алхамт аргачлалыг нэвтрүүлсэн байна. Үүнд:

Алхам 1	Холбогдох салбарт эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд, охид, хөвгүүдийн нөхцөл байдлын дүн шинжилгээ
Алхам 2	Жендэрийн асуудлыг тухайн бодлого стратеги ямар түвшинд хөндөж байгааг үнэлэх (үйл ажиллагаа)
Алхам 3	Жендэрийн мэдрэмжтэй бодлогыг хэрэгжүүлэхэд төсвийн хуваарилалт хэр оновчтой байгааг үнэлэх (орц)
Алхам 4	Богино хугацааны гарцуудыг үнэлэх, улмаар нөөцийн зарцуулалт яаж хийгдэж байгаа, түүнчлэн хөтөлбөр, бодлогууд хэрхэн хэрэгжиж байгааг үнэлэх (гарц)
Алхам 5	Урт хугацааны үр дүн болон төсвийн зардал ямар нөлөө үзүүлж болохыг үнэлэх (үр дүн)

Эх сурвалж: Budlender, D.; Hewitt, G.: Engendering Budgets, 2003, х. 90.

Засгийн газрын бодлого хэр жендэрийн мэдрэмжтэй байгааг үнэлж болдог. Энэхүү үнэлгээг хийхийн тулд шаардлагатай тоон мэдээллийг цуглуулсан байх ёстой. Хамгийн гол нь бодлогод үнэлгээ өгөх үйл явц нь нээлттэй, зөвлөгөөний хэлбэрээр явагдах нь чухал.

**Жендэрийн нөхцөл байдлын үнэлгээ нь** жендэрийн дүн шинжилгээний нэг хэлбэр юм. Жендэрийн дүн шинжилгээ гэдэг нь аливаа бодлого, үйл ажиллагааны үр дүн нийгмийн янз бүрийн

бүлгийн эмэгтэй эрэгтэй хүмүүст хэрхэн ялгаатай нөлөөлж буйг үнэлэн судлах үйл явц, нийгэмд болж буй үйл явцын жендэрийн чиг хандлагыг таньж мэдсэний үндсэн дээр мэдлэгт түшиглэсэн, эмэгтэй эрэгтэй хүмүүст, хүн амын янз бүрийн бүлгүүдэд шударга хандсан бодлого төлөвлөлтийг хийх арга зам юм.

Жендэрийн төсөвлөлтийг хийхээр зорьж буй мэргэжилтнүүд, багийнханд энэхүү жендэрийн нөхцөл байдлын үнэлгээ нь тэдний ажил мэргэжил, өдөр тутмын ажил үүргээс хол хөндий мэт сонсогдож болох ч үүнийг хийснээр бас жендэрийн асуудлын талаар нэгдсэн ойлголттой, түүнийг шийдэх хүсэл эрмэлзэлтэй болдогийг анхаарах хэрэгтэй.

*Жендэрийн асуудал нь эмэгтэй эрэгтэй хүмүүсийн гүйцэтгэж буй үүрэг, тэдний хоорондын харилцаатай холбоотой бөгөөд хувь хүнд, эсвэл бүлэгт шударга бус, ялгавартай хандах байдлаар илэрдэг. Жендэрийн асуудал нөөц боломж, үр ашиг, шийдвэр гаргах эрх мэдлийн тэгш бус хуваарилалт хэлбэрээр түгээмэл илэрдэг.*

Жендэрийн дүн шинжилгээнд дараах 10 асуултаас тухайн нөхцөл байдлаас шалтгаалан ашиглаж болно. Үүнд:

1. Хэн юу хийдэг вэ? (үйл ажиллагааны хүрээнд)
2. Түүнийг юугаар яаж хийдэг вэ? (нөөц боломжийн хүрээнд)
3. Хэн юу өмчлөн эзэмшдэг вэ? (хөрөнгө өмчлөлийн хүрээнд)
4. Хэн юу хариуцдаг вэ? (үүрэг хариуцлагын хүрээнд)
5. Хэн ямар эрх эдэлдэг вэ? (эрх мэдлийн хүрээнд)
6. Хэн юу хянадаг вэ? (орлого, зарцуулалтын хүрээнд)
7. Хэн юу шийдвэрлэдэг вэ? (эрх мэдлийн хүрээнд)
8. Хэн юу хүртдэг вэ? (хуваарилалтын хүрээнд)
9. Хэн нь хүртэж хэн нь алдаж байдаг вэ? (дахин хуваарилалтын хүрээнд)
10. Яагаад, ямар учраас? (дүрэм, журам хэм хэмжээ хэвшилийн хүрээнд)

*Жендэрийн дүн шинжилгээ (Gender analysis) гэдэг нь хүйсийн байдалд суурилсан нийгмийн харилцаан дахь ялгаатай байдлыг нээн илрүүлэх, ойлгох, залруулахын тулд мэдээллийг системтэйгээр цуглуулан боловсруулж, шинжлэх үйл явц юм.*

Салбарын хүрээн дэх жендэрийн дүн шинжилгээг сонгож авсан бол тухайн салбарын зорилго, үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг нарийвчлан гаргах хэрэгтэй болно. Тухайлбал эрүүл мэндийн салбарын хувьд эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдэд тохиолддог хамгийн хүнд өвчнүүд юу вэ, аливаа өвчний илрэлд хүйсийн ялгаа байгаа эсэх, тэдгээр өвчнүүдийн гол шалтгаан нь юу вэ, түүнчлэн эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн хувьд адил байгаа эсэх зэрэг асуудлуудыг тодруулах шаардлагатай болно.

Гэхдээ статистик мэдээ бол фото зураг адил юм, өөрөөр хэлбэл тэд өнөөгийн нөхцөл байдлыг тоймлон харуулдаг хэдий ч яагаад нөхцөл байдал ийм байгааг тайлбарладаггүй. Тиймээс "тооны цаана буй утга учир" буюу тоо, баримтанд тусгалаа олсон тэгш бус байдлын шалтгаан нь юу болохыг ойлгох нь маш чухал юм. Тухайлбал аливаа нэг өвчин эмэгтэйчүүдээс илүү эрэгтэйчүүдэд илэрч буй статистик мэдээ байна гэж бодоход энэ нь урьдчилан сэргийлэх эрүүл мэндийн үйлчилгээний үүднээс авч үзвэл хоолны дэглэм, эрхэлдэг ажил, хөдөлгөөн, эсвэл зан үйл эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хувьд өөр өөр байдгаас шалтгаалж болох юм. Боломжит шалтгаан бүрт бодлогын өөр өөр шийдэл шаардлагатай.

Хүйсээр ангилсан, жендэрийн мэдрэмжтэй тоо мэдээлэл ба чанарын судалгаа ЖМТ-д чухал ач холбогдолтой. Үүнгүйгээр жендэрийн дүн шинжилгээ хийх боломжгүй юм.

- **Хүйсээр ангилсан тоо мэдээлэл** эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн цаг ашиглалт, салбарын статистик мэдээлэл, нийгмийн статистик тоо мэдээлэл
- **Жендэрийн холбогдолтой тоо мэдээлэл** жендэрт суурилсан хүчирхийллийн

тохиолдол, мөн зөвхөн нэг хүйст хамааралтай эхийн эндэгдлийн түвшин, түрүү булчирхайн хорт хавдрын тохиолдол зэрэг орно.

Хүйсээр ангилсан тоо мэдээлэл нь үнэн зөв бөгөөд тогтмол давтамжтай, харьцуулж болохуйц хэлбэрээр (нэгэн аргачлалаар) цуглуулагдан боловсруулагдаж, ашиглахад хялбар хэлбэрээр мэдээлэгдэж байх ёстой. Жендэрийн тэгш байдлыг хангах бодлогыг төлөвлөх, үйл явцыг хянан шинжлэхэд ялангуяа цаг ашиглалтын, амьжиргааны түвшний, нөхөн үржихүйн эрүүл мэндийн, жендэрт суурилсан хүчирхийллийн зэрэг судалгааг тодорхой хугацааны давтамжтай явуулах шаардлагатай байдаг.

### **Жендэрийн мэдрэмжтэй тоо мэдээллийг хэрхэн цуглуулах вэ?**

Үүний тулд цаг ашиглалтын болон жендэрт суурилсан хүчирхийллийн судалгаа, шийдвэр гаргах түвшин дэх оролцоо, өмч хөрөнгийн эзэмшилт гэх мэт асуудлаар **бие даасан тусгайлсан судалгаанууд** хийх хэрэгтэй болно. Мөн үндэсний хэмжээнд тогтмол хийгддэг **нийгэм, эдийн засгийн судалгаануудад нэмэлт асуумж оруулах** байдлаар хүйсээр ангилсан тоо мэдээллийг цуглуулах боломжтой.

### **Бие даасан тусгайлсан судалгаанууд хийх нь:**

**Цаг ашиглалтын судалгаа (ЦАС):** Жендэрийн дүн шинжилгээний хамгийн энгийн хэлбэрүүдийн нэг нь нэг өдрийн цаг ашиглалтын судалгаа юм. Энэ судалгаа нь эмэгтэй эрэгтэй хүмүүсийн нэг өдрийн цаг ашиглалт дахь ялгаагаар дамжуулан тэдэнд тулгарч буй асуудал, хөгжлийн хэрэгцээг нь илрүүлэх боломж олгодог. Эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн хөлсгүй оролцож буй хөдөлмөрийн хэмжээ ҮНБ-ний хэдэн хувьтай тэнцэж байгааг ЦАС-г ашиглан гаргаж харуулбал нийгмийн баялгийг бүтээхэд хэн ямар хувь нэмэр оруулж байгааг бодлого боловсруулагч, статистик мэдээллийг хэрэглэгчид олж харан жендэрийн мэдрэмжтэй бодлого төлөвлөлт хийх боломжтой болно.

**Жендэрээс үүдэлтэй буюу жендэрт суурилсан хүчирхийллийн судалгаа:** Жендэрээс үүдэлтэй хүчирхийллийн судалгааг ҮСХ-оос дөрвөн жилд нэг удаа зохион байгуулж байхаар төлөвлөх нь зүйтэй.

Жендэрт суурилсан хүчирхийлэл гэж жендэрээс үүдэлтэйгээр бусдад бие мах бодийн, бэлгийн, сэтгэл санааны гэм хор, эдийн хохирол учруулсан, учруулж болзошгүй үйлдэл, эс үйлдэхүйг хэлнэ.

**Улс орны болон салбар, орон нутаг, байгууллагын жендэрийн байдлын үнэлгээ** нь хүйсээр ангилсан тоон мэдээлэл, жендэрийн мэдрэмжтэй үзүүлэлтүүдэд суурилан гарснаар жендэрийн эрх тэгш байдлыг хангахад чухал хувь нэмэр үзүүлнэ. Монголын жендэрийн байдлын үнэлгээ нь хөрөнгө өмчлөл, эзэмшлийн үзүүлэлтүүд, төсвийн үзүүлэлт, шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцооны зэрэг олон үзүүлэлтийг жендэрийн дүн шинжилгээнд тулгуурлан гаргах боломжтой.

*Монголын жендэрийн байдлын үнэлгээг 2005 онд Азийн хөгжлийн банк, Дэлхийн банкнаас боловсруулан хэвлэж олон нийтийн хүртээл болгосон байна. Уг үнэлгээний баримт бичиг нь ядуурлын асуудлыг жендэрийн мэдрэмжтэйгээр дүн шинжилгээ хийх зорилготойгоор хийгджээ. Үнэлгээний үр дүнд "Бусад олон улстай харьцуулахад Монголд жендэрийн харилцаа харьцангуй тэгш боловч сүүлийн үед явуулсан судалгаа, үндэсний статистикийн тоо баримтад хийсэн жендэрийн дүн шинжилгээнээс үзвэл шилжилтийн үр дагавар эрэгтэйчүүдэд, эмэгтэйчүүдэд ихээхэн ялгаатай тусаж байгаа" нь илэрсэн байна. Мөн үнэлгээний үр дүнд шилжилтийн үед гэр бүл, улс төр, эдийн засаг, нийгэм, соёлын хүрээнд гарсан өөрчлөлт жендэрийн шинэ зөрүү бий болсон гэж дүгнэжээ.*

Жендэрийн Үндэсний Хороо нь хуулийн дагуу жил бүр салбар хороо, зөвлөлүүдийн тайлан



мэдээллийг хэлэлцэн, дүгнэлт гаргаж, Засгийн газар УИХ-д тайлагнах үүрэгтэй. Энэхүү үүргийнхээ дагуу хоёр жилд нэг удаа Улс орны жендэрийн байдлын үнэлгээг хийх боломжтой. ҮСХ нь улс орны жендэрийн үнэлгээний илтгэлд тоон мэдээллээр хангах ажлыг гүйцэтгэнэ.

Үндэсний хэмжээнд тогтмол хийгддэг нийгэм, эдийн засгийн судалгаануудад нэмэлт асуумж оруулах нь

Одоогоор ҮСХ-оос тогтмол хийж байгаа нөхөн үржихүй эрүүл мэндийн, ажиллах хүчний, НДЕГ-аас цалингийн судалгаанууд гэх мэт мэдээллийг хүйсээр ангилан баяжуулах шаардлагатай. Үүнд:

- Засаг захиргааны болон салбаруудын цуглуулж буй тоо мэдээллийг хүйсээр ангилан үзүүлэх боломжтой байхаар өөрчлөх,
- Бүртгэлийн тогтолцоог жендэрийн зориулалтай зардлыг тодорхойлох тусгай кодтой болгон өөрчлөх, хувь хүмүүст хамаатай мэдээллийг хүйсээр ангилсан байдлаар гаргах боломжтой болгох шаардлагатай байна.

## ХИЧЭЭЛ 2.

### БОДЛОГЫН БА ТӨСВИЙН (ОРЛОГО, ЗАРЛАГЫН) ТӨЛӨВЛӨЛТИЙН ЖЕНДЭРИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭ

ХИЧЭЭЛИЙН АГУУЛГА	
<b>Зорилго</b>	<ul style="list-style-type: none"> <li>- Бодлогод жендэрийн шинжилгээ хийх талаар ойлголттой болох</li> <li>- Төсвийн орлого бүрдүүлэлт, зарцуулалт нь нийгмийн янз бүрийн бүлгийн эмэгтэй эрэгтэй хүмүүст ялгаатай нөлөөлдгийг ойлгох</li> <li>- Бодлогод хийсэн жендэрийн шинжилгээний үр дүн болон үндэсний жендэрийн бодлогын зорилтуудыг ашиглан төсвийн баримт бичгүүдэд жендэрийн шинжилгээ хийх талаар ойлголттой болох</li> </ul>
<b>Агуулга ба үндсэн ойлголтууд</b>	Бодлогын жендэрийн мэдрэмж Бодлогын жендэрийн дүн шинжилгээ Төсвийн жендэрийн дүн шинжилгээ Жендэрийн ялгаварлан гадуурхалт Төсвийн орлого Төсвийн зарлага
<b>Аргачлал</b>	Лекц: PowerPoint танилцуулга, тараах материал, бүлгийн дасгал ажил
<b>Тараах материал</b>	<ul style="list-style-type: none"> <li>- Жендэрийн асуудлыг хууль тогтоомжид тусгах удирдамж. Австри улсын Холбооны Засгийн газрын хэрэг эрхлэх газар. 2014</li> <li>- Төрийн захиргааны байгууллагуудад жендэрийн төсөвлөлтийг нэвтрүүлэх удирдамж, Вена 2012 он.</li> </ul>
<b>Сургалтын хэрэглэгдэхүүн</b>	Мультмедиа проектор, Флипчарт, үзэг
<b>Хугацаа</b>	Танилцах – 5 мин PowerPoint танилцуулга – 20 мин Асуулт хариулт – 10 мин Дасгал ажил – 20 мин Дүгнэлт – 5 мин

#### Унших материал:

- Монголын эмэгтэйчүүд: Шилжилтийн үеийн дэвшлийг зураглахуй илтгэл, НҮБЭС, Налини Бөрн, Ойдовын Оюунцэцэг, 2001
- Монголын жендэрийн байдлын үнэлгээ Азийн хөгжлийн банк, Дэлхийн банк, 2005
- Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай НҮБ-ын конвенц

## ХИЧЭЭЛИЙН УДИРДАМЖ

### Хичээлийг удирдан явуулах зөвлөмж:

1. Орон нутгийн төсвийн орлогын эх үүсвэрийн жендэрийн нөлөөллийн талаарх хэлэлцүүлгээр хичээлийг эхлүүлнэ. Хэлэлцүүлэг хийхэд зориулсан чиглүүлэх асуултуудыг ашиглана.
2. Сэдэвтэй холбоотой лекц мэдээлэл өгнө.
3. Зааварчлагын дагуу бүлгийн ажлыг явуулна.
4. Хичээлээ дүгнэнэ.

### Лекцийн гол санаа:

Монгол улсын жендэрийн бодлого нь Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийг хангахад чиглэгдэж байна. Энэ ажлын хүрээнд яам, орон нутаг бүр жендэрийн тэгш байдлыг хангах стратеги, үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх үүрэгтэй. Төсвийн орлого бүрдүүлэлт болон зарцуулалтын аль аль нь эмэгтэй эрэгтэй хүмүүст ялгаатай байдлаар нөлөөлдөг. Төсөвт жендэрийн дүн шинжилгээ хийхдээ орлого, зарлагын аль алиныг харгалзаж үзэх хэрэгтэй.

**Хэлэлцүүлэг:** Орон нутгийн төсвийн орлогын эх үүсвэрийн жендэрийн нөлөө

### Чиглүүлэх асуултууд:

- Хэн ямар татвар төлж байна вэ (эмэгтэй, эрэгтэй, баян,ядуу, хотын,хөдөөгийн гэх зэрэг категоруудыг тус бүрт нь мөн, хосолсон байдлаар авч үзнэ.)
- Хэнд татвар хамгийн их дарамт учруулж байна вэ?
- Зээл тусламж тэтгэлэгийн үр шимийг хэн хүртэж байна вэ? Жендэрийн ялгаатай байдлыг арилгахад хувь нэмэр оруулж байна уу?
- Зээл тусламжийн нөхцөл нь ямар байна вэ? Зээл тусламжийн нөхцөл нь хэнд таатай, хэнд таагүй байна вэ? (хүйс, орлогын түвшин, нас гэх зэргээр задлан авч үзэх)

### Бүлгийн ярилцлагын зааварчлага:

Сургалтанд оролцогчдыг 3-4 бүлэгт хуваан дараах дасгалуудын аль нэгийг хэрэгцээнд нь тохируулан өгнө. (Тухайн баримт бичгүүдийн тодорхой хэсгийг салгаж өгөн ажиллуулна.)

А) Үндэсний түвшинд: Нийгэм эдийн засгийн үндсэн чиглэл, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийг хэрэгжүүлэх дунд хугацааны стратеги, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл –3-т харьцуулсан шинжилгээ хийх

Б) Салбарын түвшинд: Салбарын мастер төлөвлөгөө, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийг хэрэгжүүлэх дунд хугацааны стратеги, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлүүдийг харьцуулан шинжлэх

В) Орон нутгийн түвшинд: Засаг даргын мөрийн хөтөлбөр, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийг хэрэгжүүлэх дунд хугацааны стратеги, ИТХ-аар батлуулах орон нутгийн төсвийн төслийг харьцуулан шинжлэх

### Чиглүүлэх асуултууд:

- Бодлогын зорилго, зорилтууд нь жендэрийн ямар ил болон далд,нуугдмал асуудлуудыг шийдэхэд чиглэсэн байна вэ?
- Санал болгосон үйл ажиллагаа нь эмэгтэй эрэгтэй хүмүүсийн тухайн салбарт хамаатай стратеги болон практик хэрэгцээг хангаж чадахуйц байна уу? Хэрэв тийм бол хэдий хэмжээгээр хангаж чадах вэ? Хэрэв үгүй бол яагаад?
- Тухайн салбарыг үндэсний жендэрийн бодлогод ямар байдлаар авч үзсэн байна вэ?
- Бодлогыг жендэрийн мэдрэмжтэй болгохын тулд хэрхэн сайжруулж болох вэ?
- Төсвийн баримт бичигт бодлогын баримт бичигт тусгасан үйл ажиллагаануудыг хэрэгжүүлэх хангалттай санхүүжилт төсөвлөгдсөн байна уу?

Бүлгийн ажлыг тайлагнаж дүгнэхдээ бодлогын зорилт, шалгуур үзүүлэлтүүдийг жендэрийн мэдрэмжтэй боловсруулан гаргах хэрэгцээ байгааг цохон тэмдэглэнэ.

### СУУРЬ МЭДЭЭЛЭЛ

Жендэрийн нөхцөл байдлын үнэлгээг хийсний дараа тухайн салбарын, орон нутгийн хөгжлийн бодлогод жендэрийн дүн шинжилгээ хийж эмэгтэй эрэгтэй хүмүүсийн, охид хөвгүүдийн, мөн хүн амын бүлгүүдийн (хөгжлийн бэрхшээлтэй, хүүхдээ ганцаараа өсгөж байгаа эцэг эхчүүд, эсвэл аль нэг хүйсийн тодорхой насны бүлгийн, орлогын түвшний гэх мэт үзүүлэлтүүдээр бүлэглэж болно) ялгаатай хэрэгцээ хангалттай хэмжээгээр тусгагдсан байгаа эсэхийг нягтлах шаардлагатай болно.


Монгол улсын жендэрийн бодлого нь өнөөдөр 2011 онд батлагдсан Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийг хангахад чиглэгдэж байна. Энэ ажлын хүрээнд яам, орон нутаг бүр жендэрийн тэгш байдлыг хангах стратеги, үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх үүрэгтэй. Үүнийг аймаг, дүүрэгт жендэрийн асуудал хариуцсан мэргэжилтнийг оролцуулсан жендэрийн салбар зөвлөл, хороод, сум, хороонд засаг даргын тамгын газрын дарга, нийгмийн ажилтнууд хариуцан гүйцэтгэх бөгөөд аймаг, дүүргүүд дараа оны 2 дугаар сарын 10-ны дотор багтаан Жендэрийн үндэсний хорооны ажлын албанд тайлан ирүүлэх үүрэгтэй.

Тиймээс орон нутаг, салбарын жендэрийн төсөвлөлтийн чиглэлээр суралцаж, ажиллаж буй ажилтнууд хариуцсан мэргэжилтнүүдээс уг стратеги болон үйл ажиллагааны төлөвлөгөөг авч хэрэгжилтийн байдалтай танилцан төлөвлөсөн үйл ажиллагааны зардлууд нь төсөвлөгдсөн, хуваариллагдан зарцуулагдаж байгаа эсэхийг нягтална. Жишээлбэл: Монгол улсын байгаль орчны салбарын жендэрийн стратеги 2014 онд боловсруулагдан БОНХ сайдын тушаалаар батлагдсан. Тиймээс БОНХ яамны жилийн төсөвт тухайн жилд гүйцэтгэхээр төлөвлөсөн ажлын санхүүжилт тусгагдсан эсэхийг харьцуулан харна. Хэрэв ийм стратеги, төлөвлөгөө боловсруулагдаагүй бол шаардлагатай мэдээллийн жагсаалтыг гарган цуглуулж шинжилгээ хийнэ. Үүнд:

- Салбарын хууль, эрх зүй, бодлогын голлох баримт бичгүүд,
- Орон нутгийн хөгжлийн бодлогын гол баримт бичгүүд, тухайлбал засаг даргын мөрийн хөтөлбөр
- Тухайн салбарт, орон нутагт хэрэгжиж буй төслийн баримт бичгүүд
- Байгууллагын дотоод дүрэм, журам.

Бодлогод жендэрийн дүн шинжилгээ хийх чиг баримжаа болох ойлголтуудыг дараах зураглалаар өгөв.

### Бодлогын жендэрийн мэдрэмж



Бодлогын баримт бичгүүдэд жендэрийн шинжилгээ хийхдээ дараах зүйлсэд эн тэнцүү анхаарна. Үүнд:

1. Жендэрийн үндэсний бодлогын баримт бичиг дэх зорилго, зорилтуудыг дэмжиж буй эсэх. 2017 хүртэл Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийг хэрэгжүүлэх дунд хугацааны стратеги гол баримт бичиг байна.
2. Өмнөх хичээлээр тодорхойлсон жендэрийн шийдвэл зохих асуудлууд, өөрөөр хэлбэл эмэгтэй эрэгтэй хүмүүсийн жендэрийн практик болон стратеги хэрэгцээ туссан эсэх

Бодлогын баримт бичигт шинжилгээ хийхдээ мөн жендэрийн шууд болон шууд бус ялгаварлал байгаа эсэхэд анхаарна.

***Жендэрийн ялгаварлан гадуурхалт гэж хувь хүнийг аль нэг хүйсэд харьяалагддагаас нь болж амьдралын аль нэг хүрээнд ялгаварлан гадуурхахыг хэлдэг.***

Жендэрийн ялгаварлан гадуурхалт нь жендэрийн үүргийн тухай уламжлалт хэвшмэл ойлголтод суурилдаг бөгөөд хувь хүний хандлагыг тодорхойлоод зогсохгүй нийгмийн амьдралын бүх хүрээнд институтчлэгдсэн байдаг. Хууль дүрэм, зохицуулалт, бодлого болон практик нь эмэгтэй эрэгтэй хүмүүсийг илэрхий ялган үзээгүйгээрээ “саармаг” мэт харагдаж болох ч бодит байдалд тодорхой шинж чанар бүхий хүмүүст тэгш бусаар хандах үр дүнд хүргэж болдог. Хөдөлмөр эрхлэлтийн хүрээнд авч үзвэл ажлын байранд тавигдах шаардлага буюу үзүүлэлтүүд (биеийн өндрийн болон жингийн доод хэмжээ гэх зэрэг) нь аль нэг хүйсэд илт чиглээгүй, хүйсийн хувьд саармаг мэт харагдаж байвч үнэн хэрэгтээ дундаж өндөр нь эрэгтэйчүүдийнхээс доогуур байдаг эмэгтэйчүүдийг далд утгаараа гадуурхаж байдаг. Жендэрт суурилсан ялгаварлан гадуурхалт нь практикт ялгаварлан гадуурхлын арьс өнгө, яс үндэс, махбодийн болон оюун ухааны хувьд хөгжлийн бэрхшээл, нас, гэр бүлийн байдал, эх байх, бэлгийн чиг баримжаа, шашин шүтлэг, амьдралын түвшин болон ДОХ-оор ялгаварлах зэрэг бусад хэлбэрүүдтэй хамт холилдсон байдаг. Хууль, дүрэм журам практик нь эмэгтэй эрэгтэй хүмүүст хандах тэгш бус хандаж, тэдний хооронд илэрхий ялгаа үүсгэж байгаа нь жендэрийн буюу хүйсийн шууд ялгаварлан гадуурхал юм. Харин дүрэм журам практик нь хэдийгээр жендэрийн хувьд саармаг мэт харагдаж байвч бодит байдалд гол төлөв аль нэг хүйсийн хүмүүст таагүй байдал үүсгэж байвал шууд бус ялгаварлан гадуурхал болдог. Шууд бус ялгаварлан гадуурхал нь тэр бүр илэрхий харагддаггүй бөгөөд бодлогын эсхүл хуулийн заалтын de facto үр нөлөөг шинжилсний дараа л илэрдэг. Жишээлбэл, эмэгтэй ажилтны жирэмсний болон хүүхдээ төрүүлсний дараах хугацааны цалинг ажил олгогч хариуцахаар зохицуулсан байдал нь хүүхэд төрүүлэх насны болон жирэмсэн эмэгтэйчүүдийг ажилд авах дургүй байх хандлагын үндэс болдог.

Бодлогын жендэрийн дүн шинжилгээг хийснээр тухайн байгууллага, орон нутаг, салбарын бодлогыг жендэрийн мэдрэмжтэй болгохын тулд ямар зорилго тавих, түүнийг ямар шалгуур үзүүлэлтээр хэмжихийг тодорхойлох боломжтой болдог. Энэ тухай Модуль 4-т дэлгэрэнгүй үзнэ.


**Бодлогод жендэрийн шинжилгээ хийхдээ дараах зүйлсийг анхаарах хэрэгтэй.** Үүнд:

- Жендэр бол салбар хоорондын асуудал юм. Тиймээс аль нэг салбар дахь жендэрийн тэгш байдлыг хангахад чиглэсэн бодлого төлөвлөлт нь бусад салбарын бодлоготой мөн уялдаж байх ёстой. Жишээ нь, хөвгүүдийн багшийн мэргэжил эзэмшихээр суралцахыг тэтгэлгээр дэмжихдээ мөн байгалийн ухаан, уул уурхай, дэд бүтэц, инженерийн мэргэжлээр суралцах охидыг тэнцүү тооны тэтгэлгээр дэмжих шаардлагатай.
- Жендэртэй төдийлөн холбогдолгүй бодлого төлөвлөлт нь айл өрхүүдэд хүрэхдээ

жендэрийн асуудлыг гүнзгийрүүлэх үр дагавартай байж болдог. Жишээ нь Монгол улсад бага боловсролд хамрагдах насыг 6 болгосноор хөдөөгийн малчин өрхүүд хүүхдээ сумын төвд сургахын тулд хуваагдан амьдарч эмэгтэйчүүд нь сумын төвд хүүхдээ асран, эрэгтэйчүүд нь хөдөө малаа маллах нь түгээмэл болсон. Энэ нь улмаар өрх гэрийн ажлын ачаалал, цаг ашиглалтад ихээхэн нөлөөлж, эрэгтэйчүүдийн сэтгэл санаа болон эрүүл мэндийн эрсдлийг ихэсгэсэн.

**Төсөвт жендэрийн дүн шинжилгээ хийхдээ** орлого, зарлагын аль алиныг харгалзаж үзэх хэрэгтэй. Учир нь төсвийн орлого бүрдүүлэлт болон зарцуулалтын аль аль нь эмэгтэй эрэгтэй хүмүүст ялгаатай байдлаар нөлөөлдөг тул тэгш бус байдлыг гүнзгийрүүлэхэд нөлөөлж байж болох юм. (Төсвийн орлого Сангийн яамны 2014 оны төсвийн орлого зарцуулалтын талаарх танилцуулгыг ашиглан төсвийн орлого, зарцуулалтын бүрэлдхүүн, хэмжээг тайлбарлана.)

### ЭДИЙН ЗАСАГ ДАХЬ ЗАСГИЙН ГАЗРЫН ОРОЛЦОО



Эх сурвалж: <http://mof.gov.mn/wp-content/uploads/2013/12/2014-tosov-comics-last-4.pdf>

Төсвийн хуваарилалтыг бодлогын тэргүүлэх чиглэлүүдтэй уялдуулах болон байгаа нөөцийг салбарын яамдад зөв хуваарилахын тулд Монгол улс дунд хугацааны төсвийн хүрээний арга зүйг нэвтрүүлж эхлээд байна. Дунд хугацааны төсвийн хүрээ нь 3 жилийг хамрах бөгөөд бодлогыг хэрэгжүүлэхэд шаардагдах одоогийн болон дунд хугацааны зардлын тооцооноос бүрддэг. Энэхүү тооцооллыг жил бүр хийдэг бөгөөд ингэснээр бодлогын тэргүүлэх чиглэлүүдэд гарсан өөрчлөлтийг тусгах боломжтой.

Улсын төсвийн зарим зүйл ангиудад дүн шинжилгээг хийж болох төсвийн орлого, зарлагын зарим хэлбэрийг үзье.


**Орлого:** Төсвийн орлогыг бүрдүүлэлтэд жендэрийн дүн шинжилгээг хийхийн тулд төсвийн орлогын дараах зүйл ангийг авч үзэж болно. Үүнд:

- Татварын орлого, тухайлбал, шууд татвар (орлогын албан татвар), шууд бус татвар (НӨАТ, гаалийн болон онцгой албан татвар), татварын хөнгөлөлтүүд
- Хэрэглээний төлбөр, хөрөнгийн татвар болон орлого, өв залгамжлалд ноогдуулах хүү зэрэг төсвийн орлого
- Хандивлагчдийн зээл тусламж, тусгай болон тусламжийн сан

Төсвийн орлогын жендэрийн дүн шинжилгээг хийхэд харгалзан үзэхэд дөхөм төрөл нь Хүн амын орлогын албан татвар (ХАОАТ) байж болно. Гэхдээ татварын албанд татвар төлөгчид эрэгтэй,

эмэгтэй хэн болохыг харуулсан хүйсээр ангилсан тоо мэдээлэл хангалтгүй байж болох юм.

**Зураг 1.** Засгийн газрын төсвийн орлогын бүтэц



**Зарлага:** Төсвийн зарлагын хүрээнд жендэрийн дүн шинжилгээ хийх нь төсвийн орлогод хийх шинжилгээтэй харьцуулахад арай хялбар, мэдээллийн олдоц сайтай байдаг. Төсвийн зарлагын зүйл ангийн хүрээнд жендэрийн дүн шинжилгээнд дараах аргуудыг ашиглаж болно. Үүнд:

1. Эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн хэрэгцээг хангахад чиглэсэн төсвийн зардалд дүн шинжилгээ хийх. Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн тусгайлсан хэрэгцээнд тухайлбал, төрсөн болон жирэмсэн эмэгтэйчүүд үзүүлэх эмнэлэгийн үйлчилгээ, зөвхөн эрэгтэйчүүдийн түрүү булчирхайг оношлох үйлчилгээ, хөтөлбөрийн санхүүжилтийг судлаж болно.

2. Хөдөлмөр эрхлэлтийн салбарт зарцуулж байгаа хөрөнгийг эрэгтэй, эмэгтэй хүмүүс тэгш хүртэж байгааг судлах. Мэргэжлийн болон дахин сургалт, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байр бий болгоход өгч буй зээлд хамрагсадын хүйсийн байдал

3. Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авч буй үйл явц, ажил, үйлчилгээний жендэрийн нөлөөллийн судалгаа хийх. Боловсролын салбарт зарцуулж буй хөрөнгийн үр шимийг болон эрүүл мэндийн анхан шатны үйлчилгээ хүртэгчид, хөдөө аж ахуйн салбарт үзүүлж буй дэмжлэг туслалцааг хүртэгчид (ноолуур, ноос, мах, улаанбуудайн үйлдвэрлэлд өгч буй засгийн газрын тусламж).

Төсвийн зарлагын дүн шинжилгээ хийхдээ зөвхөн эрэгтэй эсвэл эмэгтэй хүмүүст зориулсан зүйл ангид нь анхаарахаас гадна төсөв бүхэлдээ жендэрийн хувьд ямар нөлөөлөл үзүүлж болох вэ гэдэгт анхаарах нь илүү чухал.



# 4

## МОДУЛЬ 4

### ЖЕНДЭРИЙН МЭДРЭМЖТЭЙ ТӨСВИЙН ХЭРЭГЖИЛТ

Хичээл 1. Жендэрийн тэгш байдлын зорилт, шалгуур үзүүлэлтүүд

Хичээл 2. Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийг зохион байгуулах алхамууд



**МОДУЛЬ 4.****ЖЕНДЭРИЙН МЭДРЭМЖТЭЙ ТӨСВИЙН ХЭРЭГЖИЛТ**

Модуль дөрөв нь 1) Жендэрийн тэгш байдлын зорилт, шалгуур үзүүлэлтүүд, 2) Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийг зохион байгуулах алхамууд гэсэн хоёр хичээлтэй.

**ХИЧЭЭЛ 1.****ЖЕНДЭРИЙН ТЭГШ БАЙДЛЫН ЗОРИЛТ, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД**

ХИЧЭЭЛИЙН АГУУЛГА		
<b>Зорилго</b>	Жендэрийн тэгш байдлыг хангах зорилтууд хэрхэн тодорхойлогддог, шалгуур үзүүлэлтүүдээр тэдгээрийг хэмжихийг ойлгох	
<b>Агуулга ба үндсэн ойлголтууд</b>	Жендэрийн тэгш байдлын зорилтууд ба шалгуур үзүүлэлтүүд Бодлого ба төсвийн хамаарал	
<b>Аргачлал</b>	Лекц: PowerPoint танилцуулга, тараах материал, бүлгийн дасгал ажил	
<b>Тараах материал</b>	Байгаль орчны салбарын жендэрийн стратеги Байгаль орчны салбарын тухайн оны төсвийн төсөл Австри улсын жендэрийн тэгш байдлыг хангахад өгөгдсөн төсвийн зарцуулалтын хамаарал	
<b>Сургалтын хэрэглэгдэхүүн</b>	Мультимедиа проектор, Флипчарт, үзэг	
<b>Хугацаа</b>	Нийт- 60 мин	Танилцах – 5 мин PowerPoint танилцуулга – 20 мин Асуулт хариулт – 10 мин Дасгал ажил – 20 мин Дүгнэлт – 5 мин

**Унших материал:**

- Жендэрийн үндэсний хөтөлбөр, 2007
- Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн дунд хугацааны хэрэгжилтийг хангах стратеги, 2013
- Байгаль орчны салбарын жендэрийн стратеги. 2014

**ХИЧЭЭЛИЙН УДИРДАМЖ****Хичээлийг удирдан явуулах зөвлөмж:**

1. Бодлого болон төсвийн хамаарал нь жендэрийн тэгш байдлыг хангах бодлогын зорилготой хэрхэн уялдаж байгаа болон түүнтэй хэрхэн уялдуулах талаарх суурь мэдээллийг ашиглан лекцээр хичээлээ эхэлнэ.
2. Байгаль орчны салбарын жендэрийн стратегийг ашиглан байгаль орчны салбарын төсвийн төсөлд жендэрийн үнэлгээ хийх бүлгийн ажил хийлгэнэ.
3. Хичээлээ дүгнэнэ.

**Лекцийн гол санаа:**

Жендэрийн төсөвлөлтийн үйл явцыг тодорхойлоход жендэрийн тэгш байдлын зорилтууд болон холбогдох шалгуур үзүүлэлтүүдийг боловсруулах нь чухал. Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийн үйл явц нь жендэрийн тэгш байдлын зорилтуудаас эхэлнэ.

Жендэрийн төсөвлөлт нь жендэрийн тэгш байдлыг хангах зорилтууд, шалгуур үзүүлэлтийг удирдлага болгодог. Жендэрийн тэгш байдлыг хангах зорилтуудыг тодорхойлохдоо жендэрийн



дүн шинжилгээ, бодит мэдээлэл судалгаанд тулгуурласан байх ёстой. Шалгуур үзүүлэлтүүдийг тухайн боловсруулсан зорилтууддаа хүрсэн эсэхийг хэмжих зорилгоор хэрэглэдэг.

### Бүлгийн ажлын зааварчлага:

Оролцогчдыг 2-3 бүлэгт хуваан байгаль орчны салбарийн төсвийн төслийг тус салбарын жендэрийн стратегийн зорилт, төлөвлөсөн үйл ажиллагаануудтай харьцуулан үнэлэх даалгавар өгнө. Сургалтанд оролцогчдын төлөөллөөс шалтгаалан тус стратегийн 1,2,3-р зорилтуудыг төсвийн төслийн холбогдох хэсэгтэй хамт салган өгнө.


### Чиглүүлэх асуултууд:

- Жендэрийн стратегид төлөвлөсөн үйл ажиллагааг хэрэгжүүлэх төсөв төсөвлөгдсөн байна уу?
- Төсөвлөгдсөн бол хэмжээ нь хангалттай байна уу?
- Төсөвлөгдөөгүй бол энэ нь ямар шалтгаантай байж болох вэ?
- Дараа жилийн төсөвт тусгах арга зам юу вэ?

### СУУРЬ МЭДЭЭЛЭЛ

ЖМТ-ийг өргөн хүрээгээр үр дүнтэй хэрэгжүүлэх ажил нь жендэрийн тэгш байдлын зорилтуудыг зөв тодорхойлохоос эхэлдэг. Зорилтуудыг тодорхойлох нь Жендэрийн төлөвлөлтийг хэрэгжүүлэхэд бэрхшээлтэй ажил байдаг. Монгол улсын хувьд яам, салбарын, орон нутгийн жендэрийн зорилтоо тодорхойлохдоо Жендэрийн эрх тэгш байдлыг хэрэгжүүлэх тухай хуулийг хэрэгжүүлэх засгийн газрын дунд хугацааны стратеги болон олон улсын гэрээ конвенцын хүрэнд монгол улсын хүлээсэн үүргийг удирдлага болгоно.

### Зураг 1. Бодлого болон Төсвийн хамаарал



Жендэрийн төсвийн хэрэгжилт нь жендэрийн тэгш байдлыг хангах зорилтууд, түүний шалгуур үзүүлэлтийг удирдлага болгоно. Жендэрийн тэгш байдлыг хангах зорилтуудыг тодорхойлохдоо жендэрийн дүн шинжилгээ, бодит мэдээлэл судалгаанд тулгуурласан байх ёстой. Шалгуур үзүүлэлтүүдийг тухайн боловсруулсан зорилтууддаа хүрсэн эсэхийг хэмжих зорилгоор хэрэглэдэг. Эдгээр шалгуур үзүүлэлтүүд нь Засгийн газраас баримталж буй шалгуур үзүүлэлтүүдийг боловсруулахад тавигдах шаардлагад нийцэж байх ёстой.

### Зураг 2. Жендэрийн тэгш байдлыг хангах бодлого

## ЖЕНДЭРИЙН ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ БОДЛОГЫН ЗОРИЛТУУД, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Ерөнхий зорилго	<i>Ерөнхий зорилтууд нь олон улсын болон үндэсний хөгжлийн зорилтуудад үндэслэгдэн боловсруулагдсан байдаг.</i>
Салбарын, орон нутгийн байгууллагын онцлогийг тусгасан тодорхой зорилтууд	<i>Салбарын, орон нутгийн, байгууллагын зорилтууд нь ерөнхий зорилгоос урган гардаг.</i>
Тодорхой зорилтуудын шалгуур үзүүлэлтүүд	<i>Салбарын, орон нутгийн, байгууллагын тодорхой зорилтуудаас шалгуур үзүүлэлтүүдийг боловсруулах боломжтой.</i>

**Чанарын болон тоо хэмжээний хэмжигдэхүүнүүд**

Чанарын судалгаа нь нийгмийн үзэгдэл, юмсын учир шалтгаан, гарал үүсэл, шийдвэрлэх арга замын олон хүчин зүйлийн уялдаа холбоонд нь судалдаг.

Засгийн газрын жендэрийн тэгш байдлыг хангах үйл ажиллагаанд төсөв ямар хэмжээнд нийцсэн эсэхийг үнэлэхийн тулд төсвийн төсөл боловсруулах, хэлэлцэн батлах, хэрэгжүүлэх буюу зарцуулах, үнэлэх буюу хяналт тавих үе шатанд анхаарвал зохих жендэрийн асуудлууд, шалгуур үзүүлэлтүүдийг нягтална. Шалгуур үзүүлэлтүүд нь өнгөрсөн хугацаанд юу хийгдэв, юу орхигдов, бид хаана явж байна вэ? одоо анхаарал юунд хандаж байна вэ? Гэсэн асуултуудад хариулах чиг баримжаа болдог.

### Жендэрийн тэгш байдлыг хангахад өгөгдсөн төсвийн зарцуулалтын хамаарал (Австри улс)

Австри улс нь төрийн захиргааны байгууллагуудад жендэрийн төсөвлөлтийг нэвтрүүлэхэд зориулсан удирдамжтай. Энэхүү удирдамжинд Жендэрийн тэгш байдлыг хангахад өгөгдсөн төсвийн зарцуулалтын хамаарлыг хэрхэн тооцохыг заасан байна. Үүнд дараах гурван бүлэгт төсвийн зүйл анги буюу зардлуудыг задлан шинжилдэг байна. Үүнд:

**А бүлэг:** Тэгш байдлыг хангахтай шууд холбоотой төсвийн зүйл анги буюу зардлууд. Үүнд: жендэрийн тэгш байдлыг хангах зорилгоор эмэгтэй,эрэгтэйчүүдийн тодорхой нэг бүлгийг дэмжих арга хэмжээ, ажил болон гэр бүлдээ анхаарах асуудлыг зохицуулах үйл ажиллагааг дэмжихэд чиглэсэн арга хэмжээ (үүнд: эмэгтэйчүүдийн эрхийн төлөөх цөөнхийн үйл ажиллагааг дэмжих арга хэмжээ, эмэгтэйчүүдэд зориулсан эрүүл мэндийн төвийн үйл ажиллагаа болон жендэрийн агуулга, үзэл санаа, тэгш байдлыг хангах үйл ажиллагааг хэрэгжүүлэгч судалгааны хорооны үйл ажиллагааг дэмжих төрийн сан). Иймэрхүү төсвийн зүйл ангиудад дүн шинжилгээ хийх шаардлагагүй.

**Б бүлэг:** Жендэрийн тэгш байдлыг хангахтай холбоотой эсвэл холбоотой байж болох төсвийн зүйл анги буюу зардлууд. Үүнд: хувь хүмүүст үзүүлэх шууд дэмжлэг (жишээ нь сургалтын төлбөрийн тэтгэлэг гэх мэт), албан байгууллагад үзүүлэх дэмжлэг (Жишээ нь, холбооны түвшний байгууллагуудад хуваарилах хуваарилалт). Б бүлэгт нарийвчилсан дүн шинжилгээ хийх хэрэгтэй.

**В бүлэг:** Жендэрийн тэгш байдлыг хангахтай (шууд) хамааралгүй төсвийн зүйл анги буюу зардлууд. Гэхдээ энэ бүлгийг жендэрийн тэгш байдлын бодитой нөлөөлөл байгаа тохиолдолд жендэрийн төвийг сахисан байдал байнга байдаг гэдэг үүднээс тайлбарлах нь зүйтэй. Зарим тохиолдолд тэгш байдалд үзүүлэх үр нөлөө шууд бус байх нь бий. Европын Холбооны шүлхий өвчинтэй тэмцэхэд хуваарилсан хөрөнгийн хуваарилалтыг жендэрийн тэгш байдлыг хангахтай шууд хамаарал байхгүй зарлага гэж дүгнэж болно. Гэхдээ уг дүгнэлтийг ойлгомжтой үндэслэлээр нотлохгүй бол жендэрийн нуугдмал нөлөөллүүдийг орхигдуулах талтай.

Төсвийн зарцуулалтын нөлөөллийн дүн шинжилгээ нь жендэрийн төсөвлөлтийн үйл явцын гол бүрэлдэхүүн хэсэг юм. Энэ дүн шинжилгээгээр төсвийн зарцуулалтын бүх хэлбэрийг өөр өөр өнцгөөс шинжилж болдог. Дүн шинжилгээний асуултуудыг тухайн нөхцөл байдал, салбарын онцлог, тухайлбал жендэрийн тэгш байдлын ямар зорилтуудыг тодорхойлсон зэргийг харгалзан боловсруулдаг. Жендэрийн тэгш байдлын зорилт, шалгуур үзүүлэлтүүдийг хэрхэн боловсруулснаас төсвийн жендэрийн тэгш байдлыг хангахад нөлөөлөх байдлын үнэлгээ зөв хийгдэх эсэх нь, улмаар жендэрийн аудитын үр дүн ихээхэн шалтгаалдаг.

### Салбарын түвшинд

Салбарын яамдууд эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, салбарын төсвийн хязгаар болон Сангийн яамны төсөв хэрхэн боловсруулах зааврыг хүлээн авсаны дараа салбарын яам тус бүрийн төсөв хариуцсан алба хэлтсүүд тухайн салбарын бодлоготой уялдуулах тэргүүлэх чиглэлүүдэд тодорхойлдог.

Салбарын яамд өөрсдийн салбарын бодлого, тэргүүлэх чиглэлийн хүрээнд төсвийн саналыг боловсруулж Сангийн яаманд танилцуулах үүрэгтэй. Эдгээр яамд нь салбарын бодлого боловсруулж, төсвийн тооцооллыг хийхдээ тухайн салбартай холбоотой жендэрийн үүднээс дүн шинжилгээ хийсэн судалгааны үр дүнг ашиглах шаардлагатай. Тэд төсвийн санал боловсруулах заавар зөвлөмжийн дагуу төсвийн төслөө зохиож, салбарын жендэрийн төсвийн мэдэгдлийг бэлтгэн гаргадаг.

ЖМТ-ийн хүрээнд төсвийн хөтөлбөрт суурилсан төлөвлөлтийн (ТХСТ) аргыг хэрэглэхийг илүү санал болгодог. ТХСТ-ийг нэвтрүүлсэнээр төсвийн төлөвлөлт болон хяналт шинжилгээ, үнэлгээнд жендэрийн эрх тэгш байдлын үзэл баримтлалыг системтэйгээр уялдуулах боломжийг нээж байгаа юм. Хөтөлбөрүүд дараах элементүүдээс бүрдэнэ.

### Хүснэгт 1. Хөтөлбөрийн төсвийн бүрэлдэхүүн хэсгүүд

Хөтөлбөрийн төсвийн бүрэлдэхүүн хэсгүүд	Тодорхойлолт
Хөтөлбөр	Нэгдсэн нэг зорилгод чиглэсэн өөр хоорондоо уялдаа бүхий үйл ажиллагааны нэгдлийг хөтөлбөр гэнэ.
Дэд хөтөлбөр	Хөгжлийн тэргүүлэх чиглэлийн бодлогын болон үйл ажиллагааны зорилтын дор хэрэгжиж буй бүлэг төсөл/үйл ажиллагаа.
Төсөл/Үйл ажиллагаа	Дэд төслийн хүрээнд тодорхой хугацааны туршид хэрэгжих ажил. Хөгжлийн төсөл.

Эх сурвалж: Хөтөлбөрт суурилсан төсвийн гарын авлага, Кени улс, х. 15

**Хүснэгт 2. Хөтөлбөрт суурилсан төсөв ба ЖМТ уялдаа**

Гол анхаарах зүйл	Жендэрийн асуудал	Шаардлагатай өгөгдөл/ мэдээлэл
<b>Орц</b> (Үйл ажиллагааны буюу хөтөлбөрийн ангилалд тусгасны дагуу хуваарилж, зарцуулах хөрөнгө)	Жендэрийн эрх тэгш байдал болон бусад зорилтуудад хүрэхэд орц хангалттай юу?	Хүйсээр ангилсан мэдээлэл Гарц болон үр дүнгийн зорилтууд, шалгуур үзүүлэлтүүд (эдгээрийг холбогдох статистик мэдээллийн эх үүсвэрийг тодорхой болгох замаар сайжруулах шаардлагатай) Жендэрийн харилцааны тухай ойлголт (Төрийн албан хаагчид болон иргэний нийгэм хоорондоо харилцан санал бодлоо солилцох нь нэгдсэн ойлголтыг бий болгох нэгэн арга зам юм. Хэрвээ асуултуудын хариулт нь ҮГҮЙ гэж байвал жендэрийн тэгш бус оролцоог арилгахын тулд бүх дөрвөн хэсэгт хийх өөрчлөлтүүдийг тодорхойлно.)
<b>Үйл ажиллагаа</b> (Төлөвлөж, хэрэгжүүлэх үйлчилгээ, тухайлбал, эрүүл мэндийн үйлчилгээ, аж ахуйн нэгжүүдэд үзүүлэх дэмжлэг, нийгмийн халамж үйлчилгээ г.м)	Үйл ажиллагаанууд нь эрэгтэй, эмэгтэй хүмүүсийг тэгш хамарч байна уу? Үйл ажиллагаанууд нь жендэрийн тэгш эрх болон бусад зорилтуудад хүрэхэд тохиромжтой байна уу?	
<b>Гарц</b> (Төлөвлөж, хэрэгжүүлэх үйл ажиллагааны ашиглалт, тухайлбал, эмчлүүлсэн өвчтнүүд, дэмжлэг авсан аж ахуйн нэгжүүд, нэмэгдсэн орлого г.м)	Эрэгтэй, эмэгтэй хүмүүст гарцуудыг шударгаар хуваарилсан байна уу? Жендэрийн эрх тэгш байдал болон бусад зорилтуудад хүрэхэд гарцууд тохиромжтой байна уу?	
<b>Үр дүн</b> (Өргөн хүрээний зорилтыг биелүүлэх төлөвлөсөн болон бодитоор хүрсэн үр дүн, тухайлбал эрүүл иргэд, өрсөлдөөнт зах зээл, ядуурал буурах г.м)	Үр дүн нь жендэрийн эрх тэгш байдал болон бусад зорилтуудыг дэмжиж байна уу?	


Эх сурвалж: Elson, 2002, adapted from Quinn, Sheila: Жендэрийн төсөвлөлт: бодитоор хэрэгжүүлэх нь, 2009.

**Орон нутгийн түвшинд**

Орон нутаг гэдэг нь хөрөнгө мөнгө төвлөрүүлэн, түүнийг хуваарилаж буй засаг захиргааны анхан шатны нэгж юм. Төсвийн төсөл боловсруулах, санал хүргүүлэх үйл явц нь аймаг нийслэл, сум, дүүргийн төсвийн байгууллагууд төсвийн төсөл боловсруулахаас эхэлдэг. Байгууллага бүрийн төсвийн төсөл боловсруулах албан тушаалтан өөр өөр байдаг. Тухайлбал сумын түвшинд харуулъя.

Сум нь тодорхой хэмжээний захиран зарцуулах төсөвтэй, өөрийн удирдлагатай засаг захиргаа, нутаг дэвсгэрийн үндсэн нэгж юм. Сумын засаг дарга нь улсын төсвөөс санхүүждэг байгууллагуудын төсвийн зарцуулалтанд хяналт тавих үүрэгтэй. Гэхдээ хохирлыг нөхөн төлүүлэх эрх мэдэл байхгүй. Сумын төсөв хянах үйл явцад иргэд оролцох боломжтой ч тэдний саналыг тусгах механизм байхгүй. Сумын ИТХ-ын төсвийг ИТХ-ын Тэргүүлэгчдийн н.б.д, сумын ЗДТГ-ын төсвийг ЗДТГ-ын дарга, сумын Засаг даргын орлогч буюу Төрийн сангийн төлөөлөгч, нягтлан бодогч, төсвийн байгууллагын төсвийг Ерөнхий менежер, нягтлан бодогч нар боловсруулж байна.

Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийн хүрээнд хамгийн эхэнд төсвийн төсөл боловсруулж буй эдгээр албан тушаалтангуудад жендэрийн ойлголт, мэдээлэл өгөх нь төсвийн санал боловсруулах үйл явцад жендэрийн тэгш байдлыг хангах зорилтыг тусгахад нөлөө үзүүлнэ.


**Зураг 1.** Сумын төсвийн санал хүргүүлэх үйл явц

Аймаг, сумын түвшинд төсвийн байгууллага бүр үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөөндөө тулгуурлан төсвийн зарцуулалтын тэргүүлэх чиглэлийг тусган төсвийн тооцоогоо хийж, дээд шатны байгууллагатаа хүргүүлж байна. Төсвийн жендэрийн дүн шинжилгээг “Хэтийн төлөвлөгөө”-нд уялдуулан хийх нь чухал.

#### **Хэтийн төлөвлөгөөнд:**

1. УИХ-аас баталсан ерөнхий төсвийн хүрээнд хийдэг 3 жилийн төлөвлөгөө
  2. Засаг даргын 4 жилийн үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр
  3. Аймаг, сумын урт (6 жилээс дээш) болон дунд (3-5 жил) хугацааны хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөө
- Сум төсвийн төслөө жил бүрийн 6-7 дугаар сарын хооронд хүргэдэг. Аймаг 8 дугаар сарын 15-ны дотор Сангийн яамд хүргүүлдэг. Орон нутгийн төсвийг хэлэлцэн батлах үе нь 12 сарын эхэнд ИТХ-аар баталснаар эхэлдэг. Төсвийг нэг удаа нээлттэй хэлэлцүүлээд баталдаг байна. Монгол улсын төсвийн жил 1 дүгээр сарын 1-ээс 12 дугаар сарын 31-ний хооронд үргэлжилдэг. Энэ хугацаанд байгууллага, сум, аймаг төсвийн зарлагыг «Бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээ» болон «Үр дүнгийн гэрээ»-ний дагуу зарцуулж байна. Орон нутгийн түвшинд бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээ болон үр дүнгийн гэрээнд жендэрийн асуудлыг хэрхэн тусган, хэрэгжүүлж байгааг харах хэрэгтэй.

**Зураг 2.** Бүтээгдэхүүн нийлүүлэх болон үр дүнгийн гэрээ байгуулах үйл явц



Байгууллагын хувьд ЖМТ-ийг хэрэгжүүлэх үйл явц нь дараах нөхцөл байдлаар хамаарна. Үүнд:

- Жендэрийн тэгш байдлыг хангахад шаардагдахуйц байгууллагын дотоод бодлого, нөхцөл
- Байгууллагын бүтээгдэхүүн, үйлчилгээний агуулга дах жендэрийн мэдрэмжтэй байдал, хандлага.

**Жендэрийн тэгш байдлыг хангахад шаардагдахуйц байгууллагын дотоод бодлого, нөхцөл.**

Байгууллага ЖМТ-ийг хэрэгжүүлэхэд нэн тэргүүнд тухайн байгууллагын зорилго, жендэрийн тэгш байдлын статус, төсөв, байгууллага дахь эмэгтэй, эрэгтэй хүмүүсийг чадавхижуулах байдал, шаардлагатай мэдлэг, мэдээлэл байгаа эсэх. Байгууллага нь жендэрийн тэгш байдлыг хангахад шаардагдахуйц байгууллагын дотоод бодлого, нөхцөл байдлаа тодорхойлохын тулд эхний шатанд суурь мэдээлэл дээр тулгуурлан дараагийн алхамаа тодорхойлно. Цуглуулсан суурь мэдээллээ нөхцөл байдлын тайланд ашиглан, байгууллагын жендэрийн бодлого, стратегийн чиглэлээ тодорхойлох, хэмжигдэхүйц, хэрэгжихүйц зорилтуудыг дэвшүүлэх, ахиц дэвшил, өөрчлөлт гарч байгаа эсэхийг хянах, үнэлгээ өгөхөд ашиглана. Байгууллагын дотоод бодлого, стратеги, бүтцийг жендэрийн мэдрэмжтэй болгоход цогц үйл ажиллагаа шаардлагатай. Үүнийг дэмжих төсөв байна уу? гэдэг нь чухал.

Байгууллагын бүтээгдэхүүн, үйлчилгээний агуулга дахь жендэрийн мэдрэмжтэй байдал. Аливаа нэг байгууллагын үйл ажиллагаа нь нийгэмд ямар нэгэн байдлаар нөлөө үзүүлдэг. Тэгэхээр байгууллагын үйл ажиллагаа нийгэмд ямар нөлөө үзүүлж байгааг хэрхэн мэдэх вэ? Үүнд хамгийн энгийн эхлэл нь Хэрэглэгчдийн үнэлгээний судалгааг жендэрийн мэдрэмжтэй хийснээр (энэ нь үр ашиг хүртэгчдээс авах жендэрийн үнэлгээний нэг хэлбэр болно) тухайн байгууллага өөрийн үйлчилгээ, бүтээгдэхүүн нь чухам ямар замаар олон нийтэд нөлөөлж байгааг тодорхойлж, үнэлгээ өгч болдог. Иймд судалгаандаа зориулсан төсөв байна уу? гэдгийг анхаарах хэрэгтэй.

1. Байгууллагын соёл, түүний хүрээнд яригдах жендэрийн гол асуудлууд:арилга байгууламж, ажлын орчин, тавилга, шагнал урамшуулал, ажилтнуудын хувцаслалт, хоорондоо болон хэрэглэгчидтэй харьцаж буй байдал, компаний уриа, эрхэм зорилго, үйл ажиллагааны тунхаглал нь аль нэг хүйсийг, хүн амын аль нэг бүлгийг шууд ба шууд бусаар гадуурхаж байгаа эсэх,

\*Хэрэглэгчдийн үнэлгээний картны судалгаа гэдэг нь байгууллагын ил тод байдал, хариуцлага тайлагналыг дээшлүүлэх арга хэрэгсэл бөгөөд иргэдтэй харилцах, санал авах нэг механизм юм. Энэ арга зүйг Энэтхэг улсын Бангалор хотын Олон нийттэй харилцах төв боловсруулсан байдаг бөгөөд дэлхийн олон улсанд үүнийг өөрийн нөхцөл байдалд нийцүүлэн хөгжүүлж байна.а

2. Байгууллагын ажилтнуудын тунхагладаг үнэт зүйлс аль нэг хүйсийн, хүн амын бүлгийн үнэт зүйлтэй зөрчилдөж, шууд ба шууд бусаар ялгаварлан гадуурхаж байгаа эсэх,

3. Ажилтнууд ухамсарлаж ойлголгүй, дадсан маягаараа биелүүлдэг, “бичигдээгүй хууль” маягтай хэм хэмжээ, дадал нь аль нэг хүйсийг, хүн амын аль нэг бүлгийг шууд ба шууд бусаар ялгаварлаж байгаа эсэх.

## ХИЧЭЭЛ 2.

### ЖЕНДЭРИЙН МЭДРЭМЖТЭЙ ТӨСӨВЛӨЛТИЙГ ЗОХИОН БАЙГУУЛАХ АЛХАМУУД

ХИЧЭЭЛИЙН АГУУЛГА		
<b>Зорилго</b>	ЖМТ-ийг зохион байгуулах алхамуудтай танилцах	
<b>Агуулга ба үндсэн ойлголтууд</b>	Төсвийн янз бүрийн түвшний оролцогчид, тэдний үүрэг оролцоо Жендэрийн мэдрэмжтэй төсвийг зохион байгуулах алхамууд, чадавхи бүрдүүлэлт	
<b>Аргачлал</b>	Лекц: PowerPoint танилцуулга, тараах материал, бүлгийн дасгал ажил	
<b>Тараах материал</b>	ЖМТ-ийг хэрэгжүүлэх алхамууд Төсвийн тухай хуулийн 6-р бүлэг	
<b>Сургалтын хэрэглэгдэхүүн</b>	Мультимедиа проектор, Флипчарт, үзэг	
<b>Хугацаа</b>	Нийт- 60 мин	Танилцах – 5 мин PowerPoint танилцуулга – 20 мин Ярилцлага – 10 мин Дасгал ажил – 20 мин Дүгнэлт – 5 мин

#### Унших материал:

- Төсвийн тухай хууль, 2011
- Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, 2010

## ХИЧЭЭЛИЙН УДИРДАМЖ

### Хичээлийг удирдан явуулах зөвлөмж:

1. ЖМТ-ийг зохион байгуулах алхамуудыг лекцээр танилцуулна.
2. Оролцогчдын үүрэг оролцоо, тэдний чадавхийг бүрдүүлэх асуудлаар ярилцлага өрнүүлнэ.
3. Бүлгийн ажлыг зааварчлагын дагуу зохион байгуулна. Зайлшгүй харгалзан үзүүлэх асуудлуудын хүрээнд чадавхи бэхжүүлэхтэй холбоотой санал гарч ирсэн тохиолдолд түүнийг нь дэлгэрүүлэн ярилцана.
4. Хичээлээ дүгнэнэ.

### Лекцийн гол санаа:

ЖМТ, түүний хэрэгжилтийг зохион байгуулах үйл явц нь санаачлагчид, хэрэгжилтэд оролцогчдын нөөц бололцоог илүү үр өгөөжтэй болгоход чиглэдэг. ЖМТ-ийг зохион байгуулах үүргийг хуулиар төрийн байгууллагууд хүлээсэн боловч түүнийг дэмжихэд иргэний нийгмийн болон олон улсын байгууллагуудын дэмжлэг оролцоо чухал нөлөөтэй. ЖМТ нь тасралтгүй үргэлжлэх үйл явц учир түүний хэрэгжилтийг зохион байгуулахад чадавхи бэхжүүлэх нь хамгийн чухал, эн тэргүүний алхам юм.

Бүлгийн ажлын зааварчлага: Төсвийн янз бүрийн түвшний оролцогчид, тэдний үүрэг, жендэрийн тэгш байдлыг хангахад зайлшгүй харгалзан үзэх асуудлууд

1. Оролцогчдыг бүлэг болгон хуваана.
2. Үндэсний, аймгийн, орон нутгийн түвшинд төсвийн үйл явцын гол оролцогч талуудыг тэдгээрийн холбогдох үйл ажиллагааны хамт жагсаана.
3. Жендэрийн үзэл баримтлалыг хослуулан хэрэглэхэд зайлшгүй харгалзан үзэх асуудлуудыг талаар ярилцана уу. Эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийг унших. Жендэрийн холбогдолтой асуудлыг тусгаж болох бүх хэсгүүдийг тодорхойлох. Үүнд өгүүлбэрийн бичилтийг өөрчлөх, эсвэл төсвийн загварыг өөрчлөх байж болно. Жендэрийн үзэл баримтлалыг тусгах талаар санал боловсруулах.
4. Жендэрийн үзэл баримтлалын зүгээс өөрчлөн шинэчлэх шаардлагатай төсвийн бусад журам, загварын талаар бодох.
5. Үр дүнг үзүүлэнгийн цаасан дээр тэмдэглэх.
6. Үр дүнг бүгдэд танилцуулна уу.

Оролцогч тал/Түвшин	Үйл ажиллагаа	Зайлшгүй харгалзан үзэх асуудлууд

## СУУРЬ МЭДЭЭЛЭЛ

Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийн санаачлагыг зохион байгуулахад хэн голлох үүрэгтэй оролцох, хэрхэн хэрэгжүүлэх вэ гэдэгт анхаарах хэрэгтэй болно.

Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийн санаачлагч УИХ, Засгийн газар, Ерөнхийлөгчийн тамгын газар, Иргэний нийгмийн байгууллагын аль нь ч байж болно. Монголд одоогоор ЖМТ-ийг санаачлагч нь Жендэрийн Үндэсний Хороо бөгөөд Сангийн яам ЖМТ-ийн хэрэгжилтийг удирдлагаар ханган, тус яамны Төсвийн бодлого зохицуулалтын газар, түүний жендэрийн мэргэжилтэн үйл ажиллагааг нь хариуцаж байна.

### Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийг зохион байгуулах

Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийг зохион байгуулахдаа ЖМТ-ийг нэмэлт үйл ажиллагаа гэж үзэж болохгүй. Жилийн төсвийн тооцоолол, тайлагнах маягт гэх мэт төсөв зохиох жишиг удирдамж зааврыг жендэрийн асуудлыг тусгах замаар өөрчлөх хэрэгтэй. Ингэснээр жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлт нь төсөв боловсруулах энгийн төсвийн тогтсон журмын нэг хэсэг болно.

Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтөд өөр өөр талуудыг оролцуулах боломжтой. Тэдгээр нь өөрийн гэсэн үүрэг оролцоотой байж өөр өөр төрлийн үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Төсвийн тухай хуулийн төсвийн хэрэгжилтийн оролцогч талууд, тэдний үүрэг хариуцлагын талаар тусгасан. Төсвийн хэрэгжилтийн үе шатанд Төрийн сангийн тогтолцоо (Төрийн сан) үндсэн үүргийг гүйцэтгэнэ. Төрийн сангийн тогтолцоо нь төв төрийн сан, аймаг, нийслэлийн төрийн сан, сум, дүүргийн төрийн сан, төрийн захиргааны төв байгууллагын төрийн сангийн нэгж, төсвийн нягтлан бодогчоос бүрдэнэ. Төв төрийн сан нь аймаг, нийслэлийн төрийн сан болон төрийн захиргааны төв байгууллагын төрийн сангийн нэгжийн үйл ажиллагаанд, аймаг, нийслэлийн төрийн сан нь сум, дүүргийн төрийн сангийн үйл ажиллагаанд санхүүгийн дотоод хяналтыг тус тус хэрэгжүүлнэ. Төрийн сан нь төсвийн хэрэгжилтийг зохион байгуулах, төсвийн орлого, зарлагын өдөр тутмын гүйлгээг хийх, төсвийн зарлагын төлбөрийн дарааллыг тогтоох гэх мэт чиг үүргийг хэрэгжүүлнэ. (Төсвийн тухай хуулийн 2011 оны шинэчилсэн найруулга, Зүйл 37.1).

Бүх шатны төсвийн захирагч төсвийн хэрэгжилтийн талаар дараах үүрэг хүлээнэ. Үүнд: хуулийн



дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх; батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах; төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах; төсвийн сар, улирлын хуваарийг баримталж ажиллах; Төсвийн тухай хуулинд заасан эрхийн хүрээнд төсвийн байгууллагын зардлыг санхүүжүүлэх; төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэлийн санхүүжилтийг бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны гэрээ, төлбөрийн хуваарийг үндэслэн санхүүжүүлэх; хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах зэрэг тус тус багтана (Төсвийн тухай хуулийн 2011 оны шинэчилсэн найруулга, Зүйл 41.2).

### **Хэрэгжилтэнд гол оролцогчид:**

Сангийн яам нь жендэрийн мэдрэмжтэй төсөв хийхэд хамгийн чухал, гол үүргийг гүйцэтгэдэг. Тус яам нь өөрийн чиг үүргийн хүрээнд төсвийн санал боловсруулах заавар зөвлөмжинд өөрчлөлт оруулах, салбарын яамдын төсвийн төслийг хянадаг. Мөн жендэрийн төсвийн мэдэгдлийн загварыг батлаж, түүнийг хэвлэн нийтлүүлэх ажлыг зохион байгуулах боломжтой.

Статистикийн мэргэжилтнүүд жендэрийн төсвийн дүн шинжилгээ хийхэд чухал үүрэгтэй бөгөөд жендэрийн мэдрэмжтэй төлөвлөлт, төсвийг зохиоход хүйсээр ангилсан үнэн зөв тоо мэдээлэл, жендэрийн холбоотой статистик мэдээлэл нь чухал ач холбогдолтой. Зарим тохиолдолд дээрх мэдээллийг цуглуулахын тулд одоогоор ашиглаж байгаа санал асуулгын маягтыг жендэрийн мэдрэмжтэй байдлаар дахин боловсруулах шаардлагатай болдог. Эсвэл шинээр судалгаа авах, мэдээлэл цуглуулах хэрэгцээ гардаг, тухайлбал, цаг ашиглалтын судалгаагаар цаг зарцуулалтын талаарх тоо мэдээллийг авах гм.

Жендэрийн тэгш байдлыг хангах үндэсний хороо нь засгийн газрын хэрэгжүүлж буй бүх төсөл, хөтөлбөрт жендэрийн асуудлыг хөндөж тусгах үндсэн чиг үүрэгтэй. Тус хороо нь жендэрийн мэдрэмжтэй төсвийн хэрэгжилтийн явцад хяналт тавихуйц чадавхитай байх шаардлагатай. Мөн салбарын яамдад хөрөнгө оруулалтын төсвөө хэрхэн боловсруулах, зардлаа хэрэгцээ шаардлагад нийцүүлэн хэрхэн хуваарилах талаар удирдамж, заавар хүргүүлнэ.

Улсын их хурлын гишүүд төсвийн төслийг улсын их хуралд танилцуулсаны дараа батлах үүрэгтэй. Тэд төсвийн саналыг жендэрийн мэдрэмжтэй байлгах талаас шүүн хэлэлцэж, нэмэлт өөрчлөлт оруулахыг санал болгох боломжтой. Энэ үйл явцад оролцох хамгийн чухал хороод бол УИХ-ын Төсвийн байнгын хороо болон Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороод юм. Түүнчлэн УИХ дахь Эмэгтэйчүүдийн бүлэг нь жендэрийн тэгш байдлыг хангахуйц төсөв боолвсруулахад нөлөөлж, сурталчлах сүлжээ болдог.

Судлаачид жендэрийн мэдрэмжтэй төсвийн төрөл бүрийн арга хэрэгслүүдийг ашиглан төсвийн зарцуулалтын нөлөөллийн байдалд дүн шинжилгээ хийх эсвэл төсвийн зарцуулалтын таамаглалыг боловсруулах боломжтой. Судалгааны үр дүнг өргөн хүрээнд түгээж, нөлөөлөл болон сурталчилгааны зорилгоор ашиглах шаардлагатай.

Иргэний нийгмийн байгууллагууд эмзэг ядуу иргэдийг дэмжсэн, ядуурлыг бууруулахад чиглэсэн, жендэрийн тэгш байдлыг хангахуйц төсөв боловсруулахыг уриалж, сурталчлах ажлыг хэрэгжүүлэх боломжтой. Туршлагаас харахад төрийн бус байгууллагуудын оролцоо илүү идэвхитэй, хүчтэй байдаг улс орнуудад жендэрийн мэдрэмжтэй төсвийн санаачлага илүү үр дүнд хүрсэн байдаг.

Хэвлэл мэдээллийнхэн жендэрийн тэгш байдлыг хангах төсвийн холбогдолтой шийдвэрүүдийн талаар нийтэд мэдээлэх замаар ил тод, хариуцлагатай байдлыг бий болгох нөхцлийг бүрдүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэх боломжтой.

Хандивлагчид жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтөд жендэрийн мэдрэмжтэй төсөв хийх үйл ажиллагаанд санхүүгийн болон техник арга зүйн дэмжлэг үзүүлэх үүрэг гүйцэтгэдэг. Хэрэв

жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлт нь дундаас урт хугацааны үйл явц бол үр дүнг тогтвортой байлгахын тулд үйл ажиллагааг урт хугацаагаар дэмжих нь чухал.

ЖМТ-ийг хэрэгжүүлэхэд хэд хэдэн алхамуудыг хийх шаардлагатай болдог. Үүнийг хүснэгт 1-ээс харна уу.

### Хүснэгт 1. Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийг хэрэгжүүлэх алхамууд

Алхамууд	Анхаарах зүйл
Бодлого боловсруулагчид болон Сангийн яамны төлөвлөлт, төсвийн мэргэжилтнүүд болон салбар яамдын төсвийн газрын мэргэжилтнүүдэд мэдлэг ойлголт өгөх	Жендэрийн мэдрэмжтэй олон төрлийн төсвийн санаачлагын туршлагуудаас харахад мэдлэг олгох, ухуулах ажил нь гол хүчин зүйл болдог бөгөөд тухайн санаачлагын тогтвортой байдлыг хангадаг байна. Ухуулга сурталчилгааны ажлын зорилго нь шийдвэр гаргагчдад нөлөөлөх явдал юм.
Чадавхжуулах сургалтыг үе шаттай хийх	Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтөд оролцогч талууд эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд болон охид, хөвгүүдийн онцлогын бодит ялгааг гаргах ур чадвар, чадавхитай байх хэрэгтэй. Эдгээрийг сургалтаар эзэмшиж, бэхжүүлдэг системтэй болох нь чухал.
Жендэрийн мэдрэмжтэй мэдээлэл цуглуулах, орлого, зарлагын жендэрийн нөлөөлөлд дүн шинжилгээ хийх	Жендэрийн мэдрэмжтэй мэдээлэл нь жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийн суурь болдог. Засгийн газрын орлого бий болгох арга зам, төсвийн зардалын хэв шинж нь ихэвчлэн эмэгтэйчүүдэд эрэгтэйчүүдийг бодвол хүртээмж багатай, цаашлаад сөрөг нөлөө үзүүлдэг.
Төсвийн шийдвэр гаргах явцад оролцох эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн тэгш оролцоог хангах	Эмэгтэй, эрэгтэй хүмүүс нийгэмд хүлээх үүрэг, хариуцлагаасаа хамаарч ихэвчлэн ялгаатай хэрэгцээ, шаардлагатай байдаг. Төсвийн шийдвэр гаргах явцад илүү олон эмэгтэйчүүд оролцох тусам эмэгтэйчүүдийн хэрэгцээ, шаардлагыг төрийн хөрөнгө оруулалтад тусгах магадлал өсөх боломжтой.

**Бодлого боловсруулагчид болон Сангийн яамны төлөвлөлт, төсвийн мэргэжилтнүүд болон салбар яамдын төсвийн газрын мэргэжилтнүүдэд мэдлэг, ойлголт өгөх.** ЖМТ нь зөвхөн төсөв зохиох бус бодлого боловсруулах, төлөвлөх асуудал юм. Иймээс бодлого боловсруулагчдад жендэрийн асуудлаар мэдлэг мэдээлэл өгөх, жендэрийн асуудалд дүн шинжилгээ хийж, уг асуудлыг төсөвт тусгах ур чадварыг эзэмшүүлэх нь чухал.

Төсвийг төлөвлөх, боловсруулах үүрэгтэй мэргэжилтнүүдэд тэдний хийж буй ажил нь эмэгтэй, эрэгтэй хүмүүст өөр өөр нөлөө үзүүлж болох талаар ойлгуулах хэрэгтэй. Уг ухуулж ойлгуулах ажил нь хүмүүсийн хандлагыг өөрчлөх болон асуудлыг шинжлэн үзэх шинэ аргуудад суралцуулахад чиглэгдэх ёстой.

Жендэрийн мэдрэмжтэй олон төрлийн төсвийн санаачлагын туршлагуудаас харахад ухуулга сурталчилгааны ажил гол хүчин зүйл болдог бөгөөд тухайн санаачлагын тогтвортой байдлыг хангадаг байна. Ухуулга сурталчилгааны ажлын зорилго нь шийдвэр гаргагчдад нөлөөлөх явдал юм.

### Юу хийх вэ?

- ЖМТ-ийг санаачлагч нь эхний ээлжинд салбарын болон орон нутгийн төлөвлөлтийн нэгжүүдэд жендэрийн эрх тэгш байдлын үзэл баримтлал, дүн шинжилгээг төсвийн төлөвлөлт, бодлогот тусгах чадавхийг бий болгох. Сангийн яам болон төрийн сангийн албан хаагчдад жендэрийн талаарх зөв ойлголт өгөх.

**Чадавхижуулах сургалтыг үе шаттай хийх.** Дан ганц мэдлэг мэдээлэл өгөх, ухуулан ойлгуулах үйл ажиллагаа нь хангалттай биш юм. Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтөд оролцогч талууд эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд болон охид, хөвгүүдийн онцлогын бодит ялгааг гаргах ур чадвар, чадавхитай байх хэрэгтэй. Эдгээрийг байнгын сургалтаар эзэмшиж, бэхжүүлдэг системтэй болох нь чухал.

**Жендэрийн мэдрэмжтэй мэдээлэл цуглуулах , орлого, зарлагын жендэрийн нөлөөлөлд дүн шинжилгээ хийх.** ЖМТ-ийг үндэсний, салбарын, орон нутгийн, байгууллагын түвшинд хэрэгжүүлж эхлэхдээ төсөвт жендэрийн дүн шинжилгээ хийхээсээ өмнө

1. Төсвийн орлого, зарлагын аль алиныг нь судлах уу, эсвэл зөвхөн зарлагыг судлахаа тодорхойлох хэрэгтэй. Тухайлбал,

- Төсвийн орлого бүрдүүлэлтийг шинжлэх гэж байгаа бол татвар, хэрэглээний төлбөр болон хандивлагчдийн тусламж зэрэг төсвийн орлогын эс үүсвэрийг алиныг нь судлах вэ гэдгээ тогтоох.
- Зарлага талаас нь шинжлэх бол төсвийн ямар зүйл ангиудыг түүнд багтааж болохыг тодорхойлох ёстой.

2. Дүн шинжилгээнд ашиглах тоо мэдээний хамрах цаг хугацааг зааж өгөх ёстой.

3. Төсвийг гүйцэтгэлээр, төлөвлөлтөөр, дунд хугацааны зарлагын ерөнхий хүрээгээр зэрэг аль үе шатанд шинжлэх вэ гэдгээ шийдэх хэрэгтэй.

Хүйсээр ангилсан, жендэрийн мэдрэмжтэй хангалттай мэдээлэлгүйгээр бол ач холбогдолтой дүн шинжилгээ хийх боломжгүй юм. (Энэ талаар Модуль 3-т тусгасан.) Туршлага дээр үндэслэсэн олон судалгаануудаас харахад засгийн газрын орлого бүрдүүлэх арга зам, төсвийн зардалын хэв шинж нь ихэвчлэн эмэгтэйчүүдэд эрэгтэйчүүдийг бодвол хүртээмж багатай, цаашлаад сөрөг нөлөө үзүүлдэг. Энэ нь ихэнхдээ санаатай биш байдаг ч макро эдийн засгийн бодлого боловсруулахад гардаг жендэрийн харалган байдлын үр нөлөө юм. Төсвийн зарцуулалтын нөлөөллийн байдалд дүн шинжилгээ хийх нь төрийн санхүүжилтийн жендэрийн нөлөөллийг ил болгож болно. Төсвийн зарцуулалтад хийх жендэрийн үнэлгээгээр төрийн санхүүжилтийн жендэржсэн нөлөөллийг тодорхойлох боломжтой.

**Төсвийн шийдвэр гаргах явцад оролцох эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн тэгш оролцоог хангах.**

*Энэтхэгт явуулсан Панчаятын (орон нутгийн захиргааны зөвлөл) судалгаагаар панчаятын удирдлагыг эмэгтэй хүн барьж байх үед ундны усны хангамжийг онцлох хандлагатай байдаг бол удирдлагыг эрэгтэй хүн барьж байх үед усжуулалтын системд анхаарал хандуулах хандлагатай байхыг тогтоожээ. Энэтхэгийн орон нутгийн захиргаанд эмэгтэй гишүүдэд суудал хадгалсан нь хөрөнгө оруулалтын шийдвэрт чухал нөлөөлөл үзүүлсэн бөгөөд эмэгтэйчүүдийн чухал гэж үзэх асуудлуудыг (жишээ нь цаг хэмнэх дэд бүтэц) дэмжихэд тус болсон.*





# 5

## МОДУЛЬ 5

### ТӨСВИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ ТАВИХ БА ЖЕНДЭРИЙН ТӨСӨВЛӨЛТИЙГ ХӨГЖҮҮЛЭХ

Хичээл 1. Төсвийн үр ашгийн (зардлын) хүрээний шинжилгээ ба үр ашиг хүртэгчдийн жендэрийн үнэлгээ

Хичээл 2. Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийг хөгжүүлэх нь

**МОДУЛЬ 5.****ТӨСВИЙН ХЭРЭГЖИЛТЭНД ХЯНАЛТ ТАВИХ БА  
ЖЕНДЭРИЙН ТӨСӨВЛӨЛТИЙГ ХӨГЖҮҮЛЭХ**

Модуль тав нь 1) Төсвийн үр ашгийн (зардлын) хүрээний жендэрийн мэдрэмжтэй дүн шинжилгээ ба төсвийн үр ашиг хүртэгчдийн жендэрийн үнэлгээ, 2) Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийг хөгжүүлэх нь сэдэвт хоёр хичээлтэй.

**ХИЧЭЭЛ 1.****ТӨСВИЙН ҮР АШГИЙН (ЗАРДЛЫН) ХҮРЭЭНИЙ ЖЕНДЭРИЙН МЭДРЭМЖТЭЙ ДҮН ШИНЖИЛГЭЭ БА ТӨСВИЙН ҮР АШИГ ХҮРТЭГЧДИЙН ЖЕНДЭРИЙН ҮНЭЛГЭЭ**

ХИЧЭЭЛИЙН АГУУЛГА		
<b>Зорилго</b>	Төсвийн үр ашгийн хүрээний жендэрийн мэдрэмжтэй дүн шинжилгээ болон төсвийн үр ашиг хүртэгчдийн жендэрийн үнэлгээний арга хэрэгсэлтэй танилцах	
<b>Агуулга ба үндсэн ойлголтууд</b>	Улсын төсвийн зардлын хүрээний жендэрийн мэдрэмжтэй дүн шинжилгээ Төсвийн үр ашиг хүртэгчдийн жендэрийн үнэлгээний арга хэрэгсэл	
<b>Аргачлал</b>	Лекц: PowerPoint танилцуулга, тараах материал, бүлгийн дасгал ажил	
<b>Тараах материал</b>	Төсвийн зардлын хүрээний жендэрийн мэдрэмжтэй дүн шинжилгээний алхмууд	
<b>Сургалтын хэрэглэгдэхүүн</b>	Мультмедиа проектор, Флипчарт, үзэг	
<b>Хугацаа</b>	Нийт- 60 мин	Хэлэлцүүлэг – 15 мин PowerPoint танилцуулга – 20 мин Дасгал ажил – 20 мин Дүгнэлт – 5 мин

**Унших материал:**

- Төрийн захиргааны байгууллагуудад жендэрийн төсөвлөлтийг нэвтрүүлэх удирдамж, Вена 2012.

**ХИЧЭЭЛИЙН УДИРДАМЖ****Хичээлийг удирдан явуулах зөвлөмж:**

1. Төсвийн үр ашгийн хүрээний жендэрийн дүн шинжилгээний талаар зааврын дагуу хэлэлцүүлэг өрнүүлнэ.
2. Төсвийн үр ашгийн хүрээний жендэрийн дүн шинжилгээ, үр ашиг хүртэгчдийн жендэрийн мэдрэмжтэй судалгааны талаар лекцээр танилцуулна.
3. Зааварчлагын дагуу бүлгийн ажлыг зохион байгуулна.
4. Хичээлээ дүгнэнэ.

**Лекцийн гол санаа:** Төсвийн үр ашгийн хүрээний жендэрийн дүн шинжилгээ нь төсвийн хуваарилалт эмэгтэй эрэгтэй хүмүүсийн ялгаатай хэрэгцээг хангахад чиглэж байгаа эсэхийг олж илрүүлэхэд туслах санхүүгийн шинжтэй арга хэрэгсэл юм. Төсвийн хөрөнгийг орон нутгийн болон иргэдийн эрэлт, хэрэгцээнд нийцүүлэн үр ашигтайгаар зарцуулж байгаа эсэхийг үр ашиг хүртэгчээс авах жендэрийн үнэлгээгээр олж мэдэх боломжтой.

**Хэлэлцүүлгийн зааварчлага:** Төсвийн үр ашгийн хүрээний жендэрийн дүн шинжилгээг Монгол улсад төсвийн зарцуулалтын ямар хүрээ, чиглэлээр эн тэргүүнд хийх шаардлагатайг хэлэлцэх. (Энэ хэлэлцүүлгийг сургалтанд оролцогчдын хэрэгцээнд тохируулан үндэсний болон орон нутгийн

түвшний, эсвэл аль нэг салбарын төсвийн зарцуулалтын хүрээнд хийж болно.)

### **Бүлгийн ажлын зааварчлага:**

Төсвийн үр ашиг хүртэгчдээс жендэрийн мэдрэмжтэй үнэлгээ авах судалгааны төлөвлөгөөг гаргаж асуултуудыг хэлэлцэн тодорхойлох. Энэ дасгалыг гүйцэтгэхийн тулд сургалтанд оролцогчдыг 3 багт хуваан тодорхой сэдвүүдийг (төрийн үйлчилгээний аль нэг чиглэл, барилга байгууламж, дэд бүтэц гэх мэт) өгнө. (Сэдвийг тодорхойлоход өмнөх хэлэлцүүлгийн явцад гарсан санааг ашиглаж болно)

### **Чиглүүлэх асуултууд:**

- Тухайн үйлчилгээ ямар зорилгоор, хэнд чиглэж байна вэ?
- Зорилтот бүлэгт ямар хүмүүс орж байна вэ? (газар зүйн байршил, сууцны нөхцөл, орлогын түвшин, хүйс, нас, эрүүл мэндийн байдал гэх мэт )
- Эрэгтэй эмэгтэй хүмүүст энэ үйлчилгээтэй холбоотой ямар ялгаатай хэрэгцээ байгаа вэ?
- Судалгааг хаана, хэнээс, хэдэн хүнээс, хэзээ, хэн авах вэ? Тоон судалгаа, чанарын судалгааг хослуулах шаардлагатай юу?
- Ганцаарчилсан ярилцлага, бүлгийн ярилцлагын аль нь тохиромжтой вэ?
- Ярилцлагад ямар асуултуудыг ашиглах вэ?
- Хүйсээр ангилсан ямар тоон мэдээлэл хэрэгтэй вэ?
- Судалгаанд шаардагдах зардлыг ойролцоогоор гаргана уу? Энэ зардлыг төсөвт яаж тусгах вэ?

**Дүгнэлт:** Хичээлээс авсан гол ойлголтыг дасгал ажлын үр дүнгийн хамт нэгтгэн дүгнэх

## **СУУРЬ МЭДЭЭЛЭЛ**

Жендэрийн төсөвлөлт хэдий хэмжээнд хийгдэж байгааг шалгах судалгаа шинжилгээний хэд хэдэн арга бий. Үүнд төсвийн үр ашгийн (зардлын) хүрээний дүн шинжилгээ ба ашиг хүртэгчдийн жендэрийн үнэлгээг дурьдаж болно. Мөн модуль 2-т үзсэн цаг ашиглалтын байдалд гарч буй өөрчлөлтийн судалгааг мөн төсвийн жендэрийн үр нөлөөг эргэн хянахад ашиглаж болно.

Төсөвлөлтөд хийх хяналт үнэлгээний тогтолцоонд жендэрийн агуулга үзэл санааг нэвтрүүлнэ гэдэг нь шинжилгээний шинэ арга, шалгуур үзүүлэлтийг нэвтрүүлэхээс гадна өмнө нь хэрэглэж хэвшсэн шинжилгээ, үнэлгээг жендэрийн мэдрэмжтэй болгон баяжуулна гэсэн үг юм. Үүний нэг жишээ нь улсын төсвийн зардлын хүрээний дүн шинжилгээг жендэрийн мэдрэмжтэй болгох явдал юм.

**Улсын төсвийн зардлын хүрээний жендэрийн мэдрэмжтэй дүн шинжилгээ** (үр ашгийн хүрээний дүн шинжилгээ гэж бас нэрлэдэг) нь тодорхой нэг салбарын хүрээнд хүн амын янз бүрийн бүлгүүдэд улсын төсвийн зарцуулалтын үр ашиг хэрхэн хуваарилагдаж байгааг хэмжих төсвийн санхүүжилтийн стандарт арга хэрэгсэл юм. Гэхдээ энэ арга зорилтот бүлгийн хүн амыг орлогын хэмжээ эсвэл хот, хөдөөгөөр ялгах нь элбэг тохиолддог ч хүйсээр бараг ангилж үздэггүй. Тиймээс энэ шинжилгээнд хүйсийн дүн шинжилгээний ялгааг төдийлөн харгалздаггүй байна.

Улсын төсвийн зардлын хүрээний дүн шинжилгээг хүйсээр ялган хийснээр эмэгтэй эрэгтэй хүмүүсийн хүртэж буй үр ашигт ялгаа байгаа эсэхийг үнэлж чадна. Үүний тулд дараах алхмуудыг хэрэгжүүлнэ. Үүнд:

1. Аливаа үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай нэгж цэвэр зардлыг тооцох. Нэгж зардлыг тооцохдоо тухайн үйлчилгээг үзүүлэхэд хуваарилсан албан ёсоор мэдээлсэн нийт зардлыг (үйлчилгээний хураамж гэх мэт өрхүүд хувиараа гаргаж буй зардлуудыг хасна) үйлчилгээг хүртэж буй нийт нэгжийн тоонд хуваана.
2. Нэгж зардлыг үйлчилгээг хүртэгч хэмээн тодорхойлсон (өрхийн орлого, зардлын судалгаа, амьжиргааны түвшний судалгаа г.м) өрхүүдээр тооцдог бөгөөд түүнийг өрхөд

ногдож буй гишүүдийн тоогоор үржүүлдэг.

3. Үр ашгийн хүрээний нэгдсэн тооцооллыг орлогын хэмжээ, хот, хөдөө, эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд гэх мэт хувьсагч бүхий бүлгүүдээр хийнэ.

Энэ дүн шинжилгээг хэрэглэгчдийг нь тодорхойлж болох боловсрол, эрүүл мэнд, усан хангамж, ариун цэврийн байгууламжийн салбаруудад түлхүү хийдэг. Харин хамгаалалт, том хэмжээний дэд бүтэц, гудамжны гэрэлтүүлэг гэх мэт олон нийтэд чиглэсэн үйлчилгээ үзүүлдэг салбаруудад тус дүн шинжилгээг хийх боломжгүй байдаг. Түүнчлэн, шууд орлогын дахин хуваарилалт, нийгмийн даатгал, төрийн алба, хөдөө аж ахуйн үйлчилгээ зэрэг чиглэлд ашигладаг. Нийт төсвийн 1/3-д үр ашгийн хүрээний дүн шинжилгээний аргыг ашиглах боломжтой гэж үздэг байна.

*Кот-д'Ивуар улсын боловсролын салбарыг хамруулсан үр ашгийн хүрээний хүйсээр ангилсан шинжилгээгээр тухайн салбарт зарцуулж буй төсвийн үр ашгийг боловсролын бага түвшинд охид 30.5%, харин хөвгүүд 69.5% хувь хүртэж байгаа нь харагджээ. Мөн орлогын бүлгүүдийг харьцуулж үзсэнээр боловсролын салбарт төрөөс хуваарилж буй төсвийн зарцуулалтын үр ашгийг хөдөө орон нутгийнхан илүү хүртсэн байна. Дээд боловсролын түвшинд хийсэн шинжилгээ нь мөн орлого багатай өрхийн охид дээд боловсролд төрөөс зарцуулж буй төсвийн үр ашгийг огт хүртдэггүй, харин хамгийн их орлоготой өрхүүдийн охид төрөөс олгож буй боловсролын тэтгэлэг, хөнгөлөлтийг хүртэж буй эмэгтэйчүүдийн 87.1%-ийг эзэлж байгаа нь харагджээ.*

Энэ шинжилгээний үр дүнгээс жишээ нь дээд боловсролд зарцуулж буй төсвийн тодорхой хэсгийг анхан болон дунд шатны боловсрол уруу шилжүүлж, улмаар эмэгтэйчүүдэд (түүнчлэн хүн амын бага орлоготой бүлгүүдэд) ногдож буй хэмжээг сайжруулах бодлогын шийдвэр гаргаж болно. Энэ шинжилгээ нь жендэрийн нөхцөл байдлын үнэлгээ хийгдсэн, бодлогын зорилтууд болон шалгуур үзүүлэлтүүд хангалттай сайн тодорхойлогдсон тохиолдолд хяналтын сайн арга хэрэгсэл болж чадна. Энэ аргыг жендэрийн тэгш бус байдлыг үүсгэж буй суурь хүчин зүйлс, жишээлбэл дээрх тохиолдолд охидоо сургах эцэг эхчүүдийн хандлага өөрчлөгдөж байгаа эсэхийг тодруулсан чанарын судалгааны үр дүнтэй хослуулан хэрэглэвэл төсвийн дараагийн циклийн бодлого төлөвлөлтөд илүү сайн хувь нэмэр оруулж чадна.

Дээрх шинжилгээг үндэсний түвшинд мэргэжлийн байгууллага, олон төрлийн мэдээлэл ашиглан хийж болох ч энэ нь орон нутгийн түвшинд ийм шинжилгээг хийж болохгүй гэсэн үг биш юм.

**Анхаарах зүйл:** Эрүүл мэндийн салбарын төсвийн зарцуулалтыг авч үзвэл жирэмслэлт, хүүхэд төрүүлэхтэй холбоотой зардлууд эмэгтэйчүүдэд хуваарилагддаг учраас эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс илүү үр шим хүртэж буй мэт харагддаг. Нөхөн үржихүйн асуудлыг эмэгтэйчүүдэд зориулан хуваасан хөрөнгө гэж үзэх биш, харин нийгмийн өмч гэж тодорхойлох ёстой бөгөөд ингэснээр дээрх төрлийн зардлууд нь тухайн нийгэм бүхлээрээ хүртэж байгаа үр шим гэж үзэх ёстойг Австри улсын төрийн захиргааны байгууллагуудад жендэрийн төсөвлөлтийг нэвтрүүлэх удирдамжид тэмдэглэжээ.

Төсвийн зарцуулалтын нөлөөллийн дүн шинжилгээгээр төсвийн зарцуулалтын бүх хэлбэрийг өөр өөр өнцгөөс шинжилж болдог. Дүн шинжилгээний асуултуудыг тухайн нөхцөл байдал, салбарын онцлог, тухайлбал жендэрийн тэгш байдлын ямар зорилтуудыг тодорхойлсон зэргийг харгалзан боловсруулдаг. Берлин хотын олон нийтэд зориулсан спортын байгууламжийн ашиглалтын байдалд хүйсээр ангилсан шинжилгээ хийсэн нэгэн жишээ байна.



### Олон нийтэд зориулсан спортын байгууламжийн ашиглалтын байдалд хийсэн хүйсээр ангилсан тохиолдлын дүн шинжилгээ (Герман улс, Берлин хот)

Берлин хотын дүүргийн зөвлөлөөс спортын клубууд болон олон нийтэд зориулан спортын барилга байгууламжийг барьж, үйл ажиллагаа явуулж байна. Спортын барилга байгууламжаар хангах үйл ажиллагаа нь тухайн дүүргийн төсвийн 56 зүйл ангийн нэг нь бөгөөд тохиолдлын энэхүү дүн шинжилгээнд хамрагдсан.

**Нөхцөл байдал:** Берлин хотод төрийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд жендэрийн асуудлыг тусгахдаа мэргэжлийн дэмжлэг авдаг. 2004 оноос хойш жил бүрийн мужийн болон Берлин хотын дүүргүүдийн төсөвт тусгагдсан шинэ бүтээгдэхүүн болон төсвийн зүйл ангиудад дүн шинжилгээ хийсэн.

**Асуултууд:** Спортын байгууламж барихад жил бүр төсөвлөгдсөн 4.1 сая еврогоос чухам хэн үр шимийг хүртсэн бэ? Спортын байгууламжийг барихад зарцуулсан хөрөнгийн эмэгтэй, эрэгтэй хүмүүст ноогдох хувь ямар байна вэ? Дараагийн хөрөнгө оруулалтыг ямар спортын байгууламжид зарцуулах вэ?

Жендэрийн тэгш байдлын зорилтууд: Спортын байгууламжийг ашиглахад ижил тэгш эрхтэй байх буюу спортын байгууламжууд эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн хэрэгцээ сонирхолд тэгш байдлаар тохирсон байхад анхаарах, эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн хувьд төсвийн зүйл ангийг тэгш хуваарилах.

**Арга зүйн хэрэглэгдэхүүнүүд:** Хөрөнгө оруулалтын шийдвэр гаргах үйл явц нь байгаа хөрөнгө нөөцийг хэрхэн дахин хуваарилах боломжийг олгоно. Үндсэн асуулт нь спорт заал эсвэл спортын задгай талбайд хөрөнгө оруулах уу мөн тухайн байгууламж ямар спортын зориулалттай байх вэ зэрэг асуултууд байсан. Спортын клубуудын статистик мэдээ мөн одоо байгаа спортын барилга байгууламжийн ашиглалтад хийсэн дүн шинжилгээ зэрэг нь жендэрийн хуваарилалтыг спортын төрлүүдээр хийх боломжийг олгосон. Мөн спортын төрөл бүрээр зардалыг тооцох боломжтой тоо мэдээлэлтэй байсан. Эдгээр мэдээллийн тусламжтайгаар спортын барилга байгууламжийн ашиглалтын талаар хүйсээр ангилсан тохиолдлын дүн шинжилгээг явуулах боломжтой болсон.

Дүн шинжилгээний үр дүнд тулгуурлан ямар арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн бэ? Дараагийн санхүүгийн жилд тус дүүрэг эмэгтэйчүүд давамгайлан оролцдог спортын төрөлд хөрөнгө оруулалтаа нэмэгдүүлж, спорт заал барьж байгуулсан. Уг шийдвэрийн үр дүнд өмнө нь зарцуулж байсантай ижил хэмжээний хөрөнгөөр илүү олон хүн үр шим хүртэх боломжтой спортын байгууламжийг байгуулж, хөтөлбөрүүдийг санхүүжүүлсэн. Учир нь сонгосон спортын төрөл нь нэг хүнд ноогдох зардалыг бууруулсан үр дүнг үзүүлсэн.

Жендэрийн төсөвлөлтийг хэрэгжүүлснээр ямар үр дүнд хүрсэн бэ? Тоо мэдээлэлд хийсэн үнэлгээ нь нөөцийг илүү тэгш, үр дүнтэй зарцуулах боломжийг олгосон.

**Хүснэгт:** Лихтенберг дүүргийн хүйсээр ангилсан тохиолдлын дүн шинжилгээ


Спортын төрөл	Долоо хоногт үйлчлүүлэгсдийн тоо	Хуваарилалт/ тоогоор		Хуваарилалт/ хувиар		Нэг бүтээгдэхүүнд оногдох нийт төсөв	Хуваарилалт/ бүтээгдэхүүний төсвөөр	
		Эм	Эр	Эм	Эр		Эм	Эр
Аэробик	650	620	30	87	13	60.112	52.297	7.815
Сагсан бөмбөг	604	144	460	24	76	115.559	27.513	88.086
Хөл бөмбөг	5.965	309	5.656	3	97	827.691	27.314	800.377
Гимнастик	2.333	1799	534	80	20	279.750	223.800	55.950
Өндөр настай хүмүүст зориулсан спорт	22	22	0	100	0	1.156	1.156	0
Хөнгөн атлетик	159	134	25	84	16	19.652	16.468	3.184
Нийт дүн	24.734	9.402	15.333	38	62	4.131.517	1.582.371	2.549.146

Эх сурвалж: Берлин хотын Лихтенберг дүүргийн захиргаа (2004 он)

Төсвийн мөнгийг иргэдийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн, тэдний чанарын шаардлагын дагуу зарцуулж байгаа эсэхийг бодлого болон төсөв боловсруулагчид мэдэж, үйл ажиллагаандаа тусгах өөр нэг арга нь **төсвийн үр ашиг хүртэгчдээс авах жендэрийн үнэлгээ** юм. Үүнийг заримдаа ашиг хүртэгчдийн жендэрийн ялгавартай судалгаа гэж нэрлэдэг. Энэ үнэлгээний зорилго нь төрийн үйлчилгээ, дэд бүтцийн талаар иргэдийн бодол, хандлагыг тандаж, нийгмийн янз бүрийн бүлгийн, эсвэл тухайн үйлчилгээг хүртэж буй зорилтот бүлгийн эмэгтэй эрэгтэй хүмүүсийн санал бодол, дуу хоолойг сонсож, төсвийн үйл явцад тэдний ялгаатай хэрэгцээг адил тэгш тусгах явдал юм. Төсвийн үр ашиг нийгмийн хүрээнд тавьсан тэргүүлэх зорилтуудтай уялдаж байгаа эсэхийг энэ үнэлгээ бодитой харуулдаг.

Дээрх 2 төрлийн судалгаа шинжилгээг тохиолдлын бус тогтмол давтамжтай хийж төсөвлөлтийн хяналт шинжилгээ, үнэлгээний арга хэрэгсэл болгон төсвийн хяналтын тогтолцоонд нэвтрүүлж албажуулах нь чухал (Зураг 1).

**Зураг 1.** Төсвийн хяналт



Энэ ажлыг жендэрийн салбар зөвлөл хороод ЖҮХ, түүний ажлын албатай хамтран зохион байгуулна. Жишээлбэл боловсролын салбарт төсвийн зардалтай холбогдуулан дараах асуудлаар жендэрийн мэдрэмжтэй үнэлгээ хийж болно. Үүнд:

- Төсвийн зарлага охид, хөвгүүдийн сургуульд хамрагдалтын түвшинд нөлөөлж байгаа эсэх
- Охид, хөвгүүдийн боловсролын чанар дээшилсэн эсэх
- Төсвийн урсгалыг харуулсан диаграмм зохиох, асуултын жагсаалт зохиох, түүнийг хянах, агуулгын хүрээг задлан шинжлэх.

**ХИЧЭЭЛ 2.****ЖЕНДЭРИЙН МЭДРЭМЖТЭЙ ТӨСӨВЛӨЛТИЙГ ХӨГЖҮҮЛЭХ НЬ**

ХИЧЭЭЛИЙН АГУУЛГА	
<b>Зорилго</b>	Төсвийг сайжруулах, эрх зүйн орчныг хөгжүүлэх, төсвийн тайлан мэдэгдэл, статистик, шалгуур үзүүлэлтүүдийг хөгжүүлэх, тайлагналтыг сайжруулах хэрэгцээ, түүнд нөлөөлөх хүчин зүйлсийг ойлгох
<b>Агуулга ба үндсэн ойлголтууд</b>	Жендэрийн төсөвлөлтийг хөгжүүлэхэд нөлөөлөх хүчин зүйлс Иргэний нийгмийн байгууллагуудын манлайлал ЖМТ-ийг хүрээнд хийх нөлөөлөл сурталчилгаа
<b>Аргачлал</b>	Лекц: PowerPoint танилцуулга, тараах материал, бүлгийн дасгал ажил
<b>Тараах материал</b>	ЖМТ-ийг хөгжүүлэхэд нөлөөлөх хүчин зүйлс
<b>Сургалтын хэрэглэгдэхүүн</b>	Мультимедиа проектор, Флипчарт, үзэг
<b>Хугацаа</b>	Нийт- 60 мин Танилцах – 5 мин PowerPoint танилцуулга – 20 мин Асуулт хариулт – 10 мин Дасгал ажил – 20 мин Дүгнэлт – 5 мин

**Унших материал:**

- Төрийн захиргааны байгууллагуудад жендэрийн төсөвлөлтийг нэвтрүүлэх удирдамж, Вена 2012.
- Жендэрийн асуудлыг хууль тогтоомжид тусгах удирдамж. Австри улсын Холбооны Засгийн газрын хэрэг эрхлэх газар.
- Шилэн дансны тухай хууль, 2013
- Иргэд төсвөө хянана сүлжээний сайт
- Sheila Quinn. Gender budgeting: practical implementation. Handbook. 2009

**ХИЧЭЭЛИЙН УДИРДАМЖ**

1. Хичээлийг удирдан явуулах зөвлөмж: ЖМТ-ийг хөгжүүлэхэд нөлөөлөх хүчин зүйлсийн талаарх суурь мэдээллийг танилцуулна.
2. Зааварчлагын дагуу бүлгээр ажиллана. Бүлгээр ажиллуулахдаа оролцогчдын төлөөллийг харгалзан аль нэг салбар, эсвэл орон нутгийг сонгоно.
3. Чиглүүлэх асуултуудыг ашиглан ярилцлагыг өрнүүлнэ.
4. Хичээлээ дүгнэнэ.

**Лекцийн гол санаа:**

ЖМТ нь тасралтгүй үргэлжлэх цогц арга хэмжээ юм. Тиймээс тухайн үеийн нөхцөл байдал, хэрэгцээ, бодлогын зорилгод нийцүүлэн хөгжүүлж байх шаардлагатай болдог. ЖМТ-ийг хөгжүүлэх нь байгууллагын түвшин дэх зохицуулалт, өөрчлөлтүүдийг хийх, хэвшүүлэхээс эхэлнэ.

**Бүлгийн ажлын зааварчлага:**

Сургалтанд оролцогчдыг 3 бүлэгт хувааж 1) салбарын, аймаг, хотын, сум, дүүргийн түвшинд жендэрийн төсөвлөлтийг хэрэгжүүлэхэд тулгарах бэрхшээлийг илрүүлэх, 2) тэдгээр бэрхшээлийг даван туулах стратегийг тодорхойлох даалгавар өгнө.

**Чиглүүлэх асуултууд:**

- Эрх зүйн орчинтой холбоотой ямар бэрхшээл тулгарах вэ?
- Ямар зохицуулалт шаардлагатай вэ?
- Байгууллагын бүтэц, зохион байгуулалттай холбоотой ямар бэрхшээл тулгарах вэ?
- Хүний нөөцийн чадвар, мэдлэг мэдээлэлтэй холбоотой ямар бэрхшээл тулгарах вэ?

- Мэдээллийн ашиглалт, хүртээмж, ил тод байдалтай холбоотой ямар бэрхшээл тулгарах вэ?
- Хамтын ажиллагаа, иргэд, олон нийтийг оролцуулахтай холбоотой ямар асуудал тулгарах вэ?

Анхаарах зүйл: Эдгээр асуудлаар ярилцахдаа төсвийн үйл явцын үе шатуудыг харгалзан үзэж аль шатанд ямар асуудал илүүтэй тулгарахыг тодруулахад анхаарна.

## СУУРЬ МЭДЭЭЛЭЛ

Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлт нь нэг удаагийн арга хэмжээ биш, тасралтгүй үргэлжлэх цогц арга хэмжээ гэдгийг бид өмнөх хичээлүүдээс ойлгосон. Жендэрийн төсөвлөлтийн бүх нөхцөлд тохирох бэлэн жор байхгүй, мөн чанар, ач холбогдлыг нь ойлгож ухаарсны үндсэн дээр нөхцөл байдал, хэрэгцээ зорилгодоо тохируулан арга хэрэгслээ сонгох замаар хийдэг.

Жендэрийн төсөвлөлтийг амжилттай хэрэгжүүлэхэд дараах хүчин зүйлс тулгын гурван чулуу болно. (Зураг).

**Зураг 1.** Жендэрийн төсөвлөлтийг хөгжүүлэхэд нөлөөлөх үндсэн хүчин зүйлс



Засгийн газрын яам, агентлаг, бусад байгууллагуудын хүрээнд жендэрийн төсөвлөлт нь янз бүрийн түвшинд ажиллаж буй төрийн албан хаагчдын үүрэх ёстой хариуцлага юм. Тодорхой салбаруудын хувьд жендэр нь үндсэн бус, туслах асуудлуудын нэг учраас ЖМТ нь нэмэлт ажил болж ажлын ачааллыг нь нэмэгдүүлэх хандлагатай гэж ойлгогддог. Үүнийг анхаарч төрийн албан хаагчдын жендэрийн төсөвлөлтийн чиглэлээр гүйцэтгэх ажлыг ажлын байрны тодорхойлолт, гүйцэтгэлийн үнэлгээнд оруулах зохицуулалтыг цаг тухайд нь хийх нь жендэрийн төсөвлөлтийг тогтвортой хөгжүүлэх үндэс болно. Жишээ нь доорх хүснэгтэд үзүүлсэн санхүүгийн хяналт шинжилгээний тогтолцоог жендэрийн төсөвлөлтийн хүрээнд хөгжүүлэн сайжруулах шаардлага тулгарна.

### Санхүүгийн хяналт-шинжилгээний тогтолцоо

Энэхүү тогтолцоо нь санхүүгийн байдлыг өргөн хүрээнд авч үздэг ба богино болон урт хугацааны санхүүгийн үүргээ биелүүлэх, мөн санхүүгийн байдалд нөлөөлж буй хүчин зүйлийг тодорхойлох чадварыг хэмждэг байна. Энэ нь санхүү, эдийн засаг, зохион байгуулалт, орчны олон улс төрийн хандлагыг үнэлэхийн тулд шалгуур үзүүлэлтүүд боловсруулан ашигладаг.

#### Шалгуур үзүүлэлтийн бүлэг

Санхүүгийн хүчин зүйлс	Орчны хүчин зүйлс	Зохион байгуулалтын хүчин зүйлс
1. Орлого 2. Зарлага 3. Үйл ажиллагааны байдал 4. Өрийн бүтэц 5. Үндсэн үйлдвэрийн байдал	1. Нийгмийн бүлгийн хэрэгцээ ба нөөц 2. Эдийн засгийн гадаад байдал 3. Засгийн газрын хоорондын харилцаатай холбоотой саад бэрхшээл 4. Байгалийн гамшиг, түүнээс хамгаалах нь 5. Улс төрийн соёл	1. Удирдлагын практик ба хууль тогтоох бодлого

Эх сурвалж: Төрийн албаны зөвлөл, НҮБ, Нийгмийн аудит, 2005

ЖМТ нь жендэрийн тэгш байдлын үзэл баримтлалыг бодлого төлөвлөлт, үйл ажиллагаанд тусгах үйл явцын (Gender mainstreaming) нэгэн хэлбэр, бүрэлдэхүүн хэсэг болохын хувьд байгууллагын түвшин дэх өөрчлөлтийг эн тэргүүнд шаарддаг. Швед, Норвеги зэрэг орнуудад жендэрийн төсөвлөлтийг хэрэгжүүлсэн туршлагаас үзэхэд удирдах ажилтнууд жендэрийн төсөвлөлтийг дэмжиж, байгууллагын зорилго, өдөр тутмын үйл ажиллагааны нэгэн хэсэг болгож, удирдах түвшний яриа хэлэлцээнд байнга дурьдаж байх нь чухал болох нь харагдсан байна.

ЖМТ нь бүх хүрээ түвшинд иргэдийн иргэний нийгмийн байгууллагуудын, мөн жендэрийн асуудал хариуцсан төрийн байгууллага, мэргэжилтнүүд, шинжээчдийн оролцоо, хамтын ажиллагааны үр дүнд хэрэгжинэ. ЖМТ-ийн дэлхий дахины туршлагаас харахад иргэний нийгмийн байгууллагууд энэ үйл явцад манлайлах үүрэг гүйцэтгэсэн байдаг.

Иргэний нийгмийн байгууллагууд нь дараах үүргийг гүйцэтгэсэн байдаг. Үүнд:

- Жендэрийн төсөвлөлтийн үр ашгийг томъёолон гаргаж ирэх,
- Жендэрийн дүн шинжилгээний арга хэрэгслүүдийг ашиглаж сурталчлах
- Олон нийтэд жендэрийн төсөвлөлтийн талаарх мэдлэг мэдээллийг түгээх
- Шаардлагатай лобби, ухуулгын ажлыг хийх
- Төрийн байгууллагуудад сургалт хийх, зөвлөгөө өгөх
- Ном, гарын авлага хэвлэн гаргах
- Сүүдрийн илтгэл бичих болон бусад хяналтын үйл ажиллагаанд оролцох.

Жишээ нь Австрали улсад 1980-аад онд эхэлсэн жендэрийн төсөвлөлтийн үйл ажиллагаанд эмэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн байгууллагууд гол үүрэг гүйцэтгэсэн байдаг. Холбооны муж улсын, газар нутгийн (территорийн) засгийн газрууд нь засгийн газрын төсөвт хийсэн дүн шинжилгээнд суурилсан эмэгтэйчүүдийн төсвийн мэдэгдлийг гаргах туршлагыг нэвтрүүлсэн байна. Олон улсын туршлагаас харахад төрийн бус байгууллагуудын оролцоо илүү идэвхитэй, хүчтэй байдаг улс орнуудад жендэрийн мэдрэмжтэй төсвийн санаачлага илүү үр дүнд хүрсэн байдаг.

Үндэсний болон салбарын, орон нутгийн түвшинд жендэрийн төсөвлөлтийн чиглэлээр ажиллах хүмүүс, байгууллагууд эвсэл, сүлжээ, түншлэл байгуулж болохоос гадна төсвийн чиглэлээр ажиллаж буй эвсэл, сүлжээ, түншлэлүүд (жишээ нь, "Иргэд төсвөө хянана" сүлжээ) жендэрийн төсөвлөлтийг зорилгоо болгон авна. Жендэрийн төсвийн санаачлага, жишээлбэл төрийн тодорхой ажил, үйлчилгээнд үр ашиг хүртэгчдийн жендэрийн мэдрэмжтэй үнэлгээ хийх санаачлагыг иргэд, иргэний нийгмийн байгууллагууд гаргаж болно. Ийм саналыг хүлээж авах, ажлын төлөвлөгөөнд оруулах механизмыг байгууллагын түвшинд бий болгох хэрэгтэй.

Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийн хэрэгжилтийн үр дүнг тогтвортой байлгахын тулд оролцогч талуудын үйл ажиллагааг урт хугацаагаар дэмжих нь чухал. ЖМТ-ийн үйл явцад оролцогч талууд нь өөрийн гэсэн үүрэг оролцоотой байж өөр өөр төрлийн үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Гэхдээ жендэрийн төсвийн хүрээнд хэн хэрхэн оролцох нь улс орны онцлогоос шалтгаалаад ялгаатай байдгийг анхаарах хэрэгтэй.

Жендэрийн асуудал хариуцсан байгууллага, мэргэжилтэн, шинжээчид нь жендэрийн дүн шинжилгээний чадавхи бүрдүүлэх, хүйсээр ангилсан мэдээллийн хэрэгцээг тодорхойлох, жендэрийн зорилго зорилт, шалгуур үзүүлэлтүүдийг боловсруулах, жендэрийн бодлого төлөвлөлтийг боловсруулахад мэргэжил, арга зүйгээр дэмжинэ.

Олон улсын байгууллагууд, хандивлагчид ЖМТ-ийн үйл ажиллагааг дэмжих, зарим тохиолдолд санаачлан хэрэгжүүлэгч байж болдог. Засгийн газартай хамтран ажиллах үйл ажиллагааныхаа хүрээнд дор хаяж дараах чиглэлээр дэмжлэг үзүүлэх боломжтой. Үүнд:

- тэд зээл тусламжийн жендэрийн үр нөлөөг сайжруулахад анхаарч мэдээллийн солилцоог өргөжүүлэх,
- төслийн сонголт хийх үйл явцад жендэрийн үр нөлөөг тооцох арга зүйг нэвтрүүлэх,
- ИНБ-аас хэрэгжүүлж буй ЖМТ-ийн санаачлагыг дэмжих боломжтой.

- Жендэрийн төсөвлөлтийг хөгжүүлэхэд эрх зүйн хүрээнд дараах асуудалд анхаарах хэрэгтэй гэж судлаачид үзсэн байна. Үүнд:
- Төсвийн эрх зүйн орчныг бололвсронгуй болгох хүрээнд жендэрийн төсөвлөлтийг нэвтрүүлэх ажлыг үндэсний түвшинд хийх,
- Төсвийн хүрээнд хийж буй аливаа шинэчлэлтэй жендэрийн төсөвлөлтийг уялдуулах
- Жендэрийн мэдрэмжтэй тайлагнал, мэдэгдэл гаргах

Жендэрийн төсөвлөлтийн эрх зүйн орчин сайн хөгжсөн цөөн улсын нэг болох Австрийн үндсэн хуулинд жендэрийн төсөвлөлтийг хэрэгжүүлэх заалт орсон байна. Эрх зүйн орчныг үндэсний түвшинд хөгжүүлэхдээ жендэрийн төсөвлөлтийг байгууллага, орон нутгийн түвшнээс эхлэн хийх боломжийг бүрдүүлэх нь чухал. Мөн үндэсний түвшинд жендэрийн төсөвлөлтийн чиглэлээр гарах эрх зүй, бодлогын баримт бичигт жендэрийн төсөвлөлтөд шаардлагатай салбар хоорондын мэдээллийн уялдааг хангах, статистикийн болон бодлого боловсруулагчдын үйл ажиллагааг илүү уялдуулах хэрэгцээг анхаарна.

*Итали улсад үндэсний түвшинд жендэрийн төсөвлөлт хэрэгжиж эхлээгүй ч 12 муж, 9 хотын захиргааг нэгтгэсэн жендэрийн төсөвлөлтийн арга туршлагаа хуваалцах, жендэрийн төсөвлөлтийг дэмжих сүлжээ бий болсон байна.*

Жендэрийн төсөвлөлтийг хөгжүүлэх, төсвийн үйл явцад амжилттай нэвтрүүлэхэд өмнөх хичээлүүдэд үзсэн хүйсээр ангилсан мэдээлэл, цаг ашиглалтад төсвийн нөлөөлөх байдлын судалгаа зэрэг жендэрийн дүн шинжилгээний аргуудаас гадна төсвийн орлого бүрдүүлэлтэд, тухайлбал татвар хуваарилалтад хүйсээр ангилсан шинжилгээ хийх, жендэрийн төсөвлөлтийн жендэрийн тэгш байдалд нөлөөлсөн байдлыг шинжлэх, жендэрийн мэдрэмжтэй төсвийн мэдэгдэл боловсруулах аргуудыг хэрэглэж болно. Эдгээр аргууд нь жендэрийн төсөвлөлтийг хэрэгжүүлж эхэлсний дараа, хэд хэдэн жилийн тогтвортой үйл ажиллагааны үр дүнд хэрэгжинэ.

**Монгол улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Тусгаар тогтнолын талбай, Засгийн газрын XI байр, 610-612 тоот**

**Утас: (976-51)-264874, (976-51)-264876, (976-11)-328526,**

**Факс: (976-11)-331213,**

**Шуудангийн хаяг: УБ-46, 1080**

**Цахим хуудас: [www.gender.gov.mn](http://www.gender.gov.mn)**

**Цахим шуудан: [secretariat@gender.gov.mn](mailto:secretariat@gender.gov.mn)**

**[www.facebook.com/gender.gov.mn](https://www.facebook.com/gender.gov.mn)**

## ХАВСРАЛТУУД

## НЭР ТОМЬЁНЫ ТОВЧ ТАЙЛБАР ТОЛЬ

Нэр томьёо	Тайлбар
Жендэр	Жендэр гэдэг нь эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн биологийн ялгаа ба нийгмийн үүргийн ялган салгаж ойлгохын тулд хэрэглэх болсон, тэдний эдийн засаг, нийгэм, улс төр ба соёлын амьдралын онцлог шинж чанар, боломж бололцоог тодорхойлдог нэр томьёо юм.
Жендэрийн мэдрэмж	Эмэгтэй эрэгтэй хүмүүс, нийгмийн бүлгүүдийн ялгаатай хэрэгцээг, мөн тэдний хөгжлийн үйл явцад оролцох болон үр шимийг нь хүртэхэд хязгаарлалт болж буй хүчин зүйлсийг анхаарч тооцох хүсэл эрмэлзэл, мэдлэг, чадварыг жендэрийн мэдрэмж гэнэ.
Жендэрийн тэгш байдал	Эмэгтэй, эрэгтэй хүмүүс нийгэмдээ болон хувийн амьдралын хүрээндээ эн тэгш үнэлэгдэж, тэгш эрх мэдэл, оролцоотой байхыг жендэрийн тэгш байдал гэдэг.
Жендэрийн тэгш байдлын үзэл баримтлалыг бодлого төлөвлөлт, үйл ажиллагаанд тусгах (Gender mainstreaming)	Жендэрийн тэгш байдлын үзэл баримтлалыг бодлого төлөвлөлт, үйл ажиллагаанд тусгах (Gender mainstreaming) гэдэг нь бүх хүрээ, бүх түвшний аливаа бодлого, төлөвлөлт, үйл ажиллагааны, түүний дотор хууль тогтоомж, төсөл хөтөлбөрийн эмэгтэй эрэгтэй хүмүүст, нийгмийн бүлгүүдэд ялгаатай нөлөөлөх байдлыг анхаарч тооцох, тэдний ялгаатай хэрэгцээ болон мэдлэг туршлагыг эн тэнцүү үнэлж, анхаарах үйл явц, стратеги юм.
Жендэрийн дүн шинжилгээ	Жендэрийн дүн шинжилгээ гэж бодлого, төлөвлөлт, үйл ажиллагаа нийгмийн янз бүрийн бүлгийн эрэгтэй эмэгтэй хүмүүсийн хэрэгцээнд суурилсан эсэхийг, оролцох болон үр ашиг хүртэх тэгш боломжийг тэдэнд бий болгож байгаа эсэхийг үнэлэн судалж, анхаарч тооцох үйл явц юм.
Жендэрийн хэвшмэл ойлголт	Эмэгтэй эрэгтэй хүмүүсийн тухайд нийгэм соёлын нөлөөгөөр төлөвшин тогтсон хялбаршуулсан ойлголт, төсөөллийг жендэрийн хэвшмэл ойлголт (стереотип) гэж нэрлэдэг. Жендэрийн хэвшмэл ойлголт нийгэм соёл бүрт харилцан адилгүйгээс гадна цаг хугацааны явцад өөрчлөгддөг боловч эрэгтэйчүүдийг нийгмийн хүрээнд бүтээлч хөдөлмөр эрхлэгч, өрх гэрийн тэжээгч, харин эмэгтэйчүүдийг тэднээс хараат, голдуу өрх гэрийн хүрээнд хөдөлмөрлөгч гэж үзэх хандлагыг хадгалж бэхжүүлсэн түгээмэл шинжтэй байдаг.
Жендэрийн практик ба стратеги хэрэгцээ	Эмэгтэй эрэгтэй хүмүүст тэгш боломжийг бодитойгоор олгохын тулд тэдний амьдралын нөхцөл байдал, тэдэнд байгаа бодит боломж, тулгарах асуудлаас нь үүдэн гарч буй ялгаатай хэрэгцээг нь хангахыг зорих ёстой. Эмэгтэй эрэгтэй хүмүүсийн энэ ялгаатай хэрэгцээг жендэрийн практик ба стратеги хэрэгцээ гэж ангилдаг. Жендэрийн практик буюу бодит хэрэгцээ нь эмэгтэй эрэгтэй хүмүүсийн жендэрийн үүргээс үүсэн гардаг бол стратеги хэрэгцээ нь эрэгтэй эмэгтэй хүмүүсийн гэр бүл, орон нутагтаа болон нийгэмдээ эзэлж буй ялгаатай байр суурьтай холбоотой, хүмүүс өөрсдөө илэрхийлэн гаргахад хэцүү байдаг.
Жендэр ба Хөгжил хандлага	1980-аад оноос өмнө тэгш байдлыг хангах бодлого, үйл ажиллагаанд зонхилж байсан “Эмэгтэйчүүд ба хөгжил”, “Эмэгтэйчүүд Хөгжилд” хандлагууд нь эмэгтэйчүүдийг онцгойлон үзэж, тэднийг хөгжлийн үйл ажиллагаанд оролцуулахад анхаарч байсан бол “Жендэр ба Хөгжил” хандлага нь эмэгтэйчүүдийг бүлгийнх нь хувьд онцгойлон үзэхэд бус, эмэгтэй эрэгтэй хүмүүсийн хооронд тухайн нийгэм цаг үед төлөвшсөн харилцаанд, түүнийг өөрчлөхөд голлон анхаардаг. Хөгжлийн аливаа үйл ажиллагаанд жендэрийн тэгш байдлын үзэл баримтлалыг нэгтгэж, охид хөвгүүдийн, эмэгтэй эрэгтэй хүмүүсийн хөгжлийн ялгаатай хэрэгцээг таньж мэдэх, түүнийг хангахад зорих нь Жендэр ба Хөгжил хандлагын мөн чанар юм.

**ХУРААНГУЙЛСАН ҮГС**

<b>ЖМТ</b>	Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлт
<b>ЖЭТБХТХ</b>	Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль
<b>ДС</b>	Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийг хэрэгжүүлэх Засгийн газрын дунд хугацааны стратеги, үйл ажиллагааны төлөвлөгөө
<b>ЖМ</b>	Жендэрийн тэгш байдлын үзэл баримтлалыг бодлого төлөвлөлт, үйл ажиллагаанд тусгах стратеги
<b>ЗГ</b>	Засгийн газар
<b>УИХ</b>	Улсын их хурал
<b>ИНБ</b>	Иргэний нийгмийн байгууллага
<b>ТББ</b>	Төрийн бус байгууллага
<b>ҮСТ</b>	Үндэсний тооцооны систем

**НОМ ЗҮЙ**

- Монгол улсын Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, 2011 он
- Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийг хэрэгжүүлэх Засгийн газрын дунд хугацааны стратеги, үйл ажиллагааны төлөвлөгөө (2013-2016), 2013 он
- Байгаль орчны салбарын жендэрийн стратеги (2014-2030), БОНХЯ, 2014 он
- Жендэрийн үзэл баримтлалыг эдийн засгийн шилжилтийн бодлогод тусгах нь: Жендэрийн мэдрэмжтэй төсөв боловсруулахад Монгол болон бусад шилжилтийн орнуудын туршлага, Сангийн яам, НҮБХХ, 2005 он
- Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийн асуудлаарх сургагч багшид зориулсан сургалтын гарын авлагын төсөл, Даваагийн Цэвээнболор, Катрин Шнайдэр, 2014 он
- Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийн удирдамж, Даваагийн Цэвээнболор, Катрин Шнайдэр, 2014 он
- Эрх зүйн зохицуулалтын хүрээ: Жендэрийн асуудлыг хууль тогтоожинд тусгах удирдамж, Австри улсын Холбооны засгийн газрын хэрэг эрхлэх газар
- Төрийн захиргааны байгууллагуудад жендэрийн төсөвлөлтийг нэвтрүүлэх удирдамж, Вена, 2012 он



---

**Хянасан:**

М.Болормаа  
Л.Түвшинжаргал

**Боловсруулсан:**

Т.Амгалан  
Б.Онон

**Техникийн туслалцаа:**

Олон улсын зөвлөх Катрин Шнайдер  
Үндэсний зөвлөх Даваагийн Цэвээнболор

**НҮБ-ын Хүн амын сан**

НҮБ-ын Хүн Амын сан нь Монгол улсад Улс орныг дэмжих 5 дахь хөтөлбөрөө 2012-2016 оны хооронд хэрэгжүүлж байгаа бөгөөд энэхүү хөтөлбөр нь Жендэрийн тэгш байдлыг хангах тухай Монгол улсын хуулийг хэрэгжүүлэх, жендэрийн асуудлыг бодлого, хөтөлбөртэй уялдуулах үндэсний чадавхийг дээшлүүлэх зорилготой тусгай бүрэлдхүүн хэсэгтэй. Тус хүрээнд жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийн асуудлаар Засгийн газрын холбогдох байгууллагуудын чадавхийг дээшлүүлэх үйл ажиллагааг олон улсын болон үндэсний зөвлөхүүдийн дэмжлэгтэйгээр Жендэрийн Үндэсний Хороотой хамтран хэрэгжүүлж байна.

---

